

# **Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг тайлагнах Иргэний нийгмийн байгууллагуудын НЭГДСЭН ИЛТГЭЛ**

Монгол Улсын Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ

Улаанбаатар хот

2019 он

Иргэний нийгмийн байгууллагуудын сайн дурын илтгэл бичсэн:

ТХЗ-1	Г.Уранцоож С.Цэндбаатар	ХЭХТ ТББ Үндсэн уртраг ТББ
ТХЗ-2	Н.Оюунтуяа Г.Урантүлхүүр	Хэрэглэгч сан Хүнс эвсэл
ТХЗ-3	Б.Мөнхцэцэг Ч.Сэмжидмаа Б.Гэрэлтуяа	МГБССН Сэтгэлзүйн мэдрэмж ТББ Гүнж төв
ТХЗ-4	Д.Тунгалаг	Бүх нийт боловсролын төлөө Үндэсний эвсэл
ТХЗ-5	Д.Энхжаргал	МОНФЕМНЭТ Үндэсний сүлжээ
ТХЗ-6		
ТХЗ-7	Д.Сүхгэрэл	Оюу толгойн хяналт ТББ
ТХЗ-8	Ш.Ариунаа	МЭХДХ
ТХЗ-9		
ТХЗ-10	Г.Уранцоож	ХЭХТ
ТХЗ-11	Г.Норовсүрэн	Очирт цэцэн ханд сан
ТХЗ-12	Н.Оюунтуяа Л.Долгормаа Р.Нямдорж	Хэрэглэгч сан Байгаль орчин, эрүүл мэнд төв ТББ Заша өвс төв ТББ
ТХЗ-13	Н.Баярсайхан Б.Баттогтох	Хил хязгааргүй алхам ТББ Минчелл сан
ТХЗ-14		
ТХЗ-15	Н.Баярсайхан	Хил хязгааргүй алхам ТББ
ТХЗ-16	Б.Сувд Б.Туяа	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ Хүйсийн тэгш эрхийн төв ТББ Хөөрхөн зүрхнүүдийн аян Дэлхийн зөн Монгол ОУБ Глоб Интернэйшнл
ТХЗ-17	Л.Дугармаа Н.Оюунтуяа Н.Тунгалаг	Хөгжлийн ажиглагч ТББ Хэрэглэгч сан Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ

Тайланг эмхэтгэсэн:

Б.Цэрэнханд Сэтгэлзүйн мэдрэмж ТББ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БОНБҮТХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
ГБТ	Гэр бүл төлөвлөлт
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ДТХЗ	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖСАХ	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МГБССН	Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг
МУ	Монгол улс
МУТХҮБ	Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл баримтлал
МЭХДХ	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо
МВ	Мегаватт
НҮБХАС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан
НҮБУАӨСК	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
ОУБ	Олон улсын байгууллага
СБД	Сүхбаатар дүүрэг
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
УЦС	Усан цахилгаан станц
ҮЗХН	Үндэсний зорилтот хувь нэмэр
ҮСДИ	Үндэсний сайн дурын илтгэл
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв
ХУД	Хан-уул дүүрэг
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭФ	Хүний эрхийн форум
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭХДХХ	Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр

Гарчиг

I. 5	
II. 7	
III. 9	
IV. 12	
ТХЗ-1. Ядуурлыг устгах	12
ТХЗ-2. Өлсгөлөнг зогсоох	14
ТХЗ-3. Эрүүл мэндийг дэмжих	17
ТХЗ-4. Чанартай боловсролыг дэмжих	19
ТХЗ-5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах	26
ТХЗ-6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	30
ТХЗ-7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	31
ТХЗ 8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	35
ТХЗ-9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	39
ТХЗ-10. Тэгш бус байдлыг бууруулах	39
ТХЗ-11. Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих	41
ТХЗ-12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих	45
ТХЗ-13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	49
ТХЗ-14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах	54
ТХЗ-15. Хуурай газрын экосистемийг хамгаалах	54
ТХЗ-16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох	59
ТХЗ 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	68
V. 74	
VI. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	82

## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн улс орнууд 2015 онд хамтран боловсруулж баталсан Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийн тухай тайлангаа 2030 он хүртэл наад зах нь 2 удаа танилцуулах ёстой бөгөөд Монгол улс анхны илтгэлээ энэ 2019 оны 7-р сард НҮБ-ын Улс төрийн дээд түвшний чуулга уулзалтад танилцуулах гэж байна. МУ-ын

Засгийн газар Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)-ээ бэлтгээд байгаа энэ цаг үед Иргэний нийгмийн байгууллагуудын “ТХЗ ба ИНБ” Сүлжээ зэрэгцэн бэлтгэсэн илтгэлээ Та бүхэнд хүргэж байна. ҮСДИ-г олон талын оролцоотойгоор бэлтгэх зарчмыг хэрэгжүүлэх болон ЗГ-ын илтгэлд хувь нэмэр оруулах, ЗГ-ын болон ИНБ-ын хамтын ажиллагааг дэмжих, иргэдийн дуу хоолойг дэлхийн олон нийтэд хүргэх, өөрсдийн ажиллаж буй асуудлаар холбогдох салбар бүрийнхээ хөгжилд ахиц дэвшил гаргах боломж гэж харж бид илтгэлээ бэлтгэсэн.

ИНБ-ын илтгэлийг бэлтгэхдээ дэлхийн ТХЗ-ууд МУ-ын хөрсөнд хэр нутагшиж, ядуурал, хоол хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, тэгш бус байдал, ажиллаж амьдрах таатай орчин гэх мэт монгол хүн бүрийн өдөр тутмын амьдралтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудын хэрэгжилтийг өөрсдийн өнцгөөс харахыг зорьсон болно.

“ТХЗ ба ИНБ” сүлжээ ТХЗ, зорилтуудын хэрэгжилтийн тайланг бэлтгэх явцад Засгийн газар нээлттэй хамтран ажиллаж, хэлэлцүүлэг, ярилцлагууд хийж, ИНБ-ын байр суурь, дүгнэлт, зөвлөмжийг хангалттай хэмжээнд ҮСДИ-д тусгасанд нэн талархалтай байна. ИНБ-ын илтгэлийг бэлтгэх үйл явцыг дэмжин санхүүгийн тусламж үзүүлсэн НҮБ-ын ХХ-ийн багт талархаж байна.

Энэ удаагийн ҮСДИ-г бэлтгэснээр үйл ажиллагааг хязгаарлахгүй бөгөөд ТХЗ, зорилтуудын хэрэгжилтэд байнгын хяналт үнэлгээ хийхэд ИНБ-уудыг уриалан “ТХЗ ба ИНБ” Сүлжээний гишүүд өөрийн үйл ажиллагаанд хамаарах ТХЗ-н хэрэгжилтийн явцыг жил бүр тайлагнаж, төлөв байдал, үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг ТХЗ-н Үндэсний зөвлөл, НҮБ, бүс нутгийн холбогдох олон улсын байгууллагуудад хүргүүлж ажиллана.

ТХЗ, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх үйл хэрэгт ИНБ-ын илтгэл хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

“ТХЗ ба ИНБ” Сүлжээний зохицуулагч

/ Г.Уранцоож /

## I. УДИРТГАЛ

Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ) бол дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго (ДТХЗ)-2030-н хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд ололт амжилт, сайн туршлага, сорилт, сургамжаа хуваалцах, авах арга хэмжээгээ тодорхойлох дэлхий нийтийн нэгдсэн арга зам юм. Түүнчилэн төрийн бодлогыг сайжруулах, институцийг бэхжүүлэхэд олон салбарын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих, түншлэлийг өргөжүүлэх замаар ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжинэ гэж үзэж улс орнуудын тайланг НҮБ-ын Улс Төрийн Дээд Түвшний чуулга уулзалтаар хэлэлцдэг. Иймээс МУ-ын

ИНБ-ын сүлжээний байгууллагууд анхны нэгдсэн тайланг өөрсдийн ажилладаг, нэн тулгамдсан асуудалтай холбоотой ТХЗ-н үзүүлэлтээр бичиж байна. ОУ-ын түвшинд 2019 оны ТХЗ-н хэрэгжилтийн тайланг “Хүмүүсийг эрх мэдэлжүүлэх, хүртээмж ба тэгш байдлыг хангах” үйл ажиллагаанд чиглүүлэхийг уриалсан. МУ-ын ҮСДИ-н чиглэлд “агаарын бохирдол”-ыг хөгжлийн тулгамдсан асуудлын нэг хэмээн авч үзэж тусгайлан тайлагнаж байгаа болно.

ИНБ-ын тайланд үйл ажиллагаандаа шууд холбогдох ТХЗ, зорилтуудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй сорилтыг тодорхой авч үзэхийн зэрэгцээ ДТХЗ-н хэрэгжилтийг хангах, түргэсгэх бодит үндэслэл нь Монгол Улсын үндэсний бодлого, хөтөлбөрт хэр тусгагдан нутагшуулж, уялдсан байдлаас шууд хамаарна гэж үзэж байна. Иймээс ТХЗ-ын зорилт, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангах шийдэл, арга хэмжээ МУТХҮБ-2030, ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, Засгийн Газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох үндэсний хөтөлбөр, салбаруудын бодлогын баримт бичгүүдэд хэрхэн туссаныг тусгайлан авч үзлээ.

## ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

ТХЗ-н хэрэгжилтийн тайлан бичихэд “ТХЗ ба ИНБ” сүлжээний гишүүн байгууллагууд идэвхитэй хамтран ажиллалаа.

ТХЗ-н хэрэгжилт орон нутагт ямар ойлголт, мэдээлэл, хэрэгжилттэй байгаад ХЭХТ, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээтэй хамтран үнэлгээ хийлээ.

Орхигдож болзошгүй хүн амын нэг хэсгийг тодруулах зорилтот судалгааг МЭХДХ, Хөгжлийн хэлхээ ТББ хамтран зохион байгуулж, нийслэл хотын дэргэдэх хогийн цэг дээр ажиллаж, амьдарч буй хүмүүсийн талаарх мэдээллийг Төрийн сонорт хүргэлээ.

Глоб интернейшнл төв ТББ ТХЗ 16.10 зорилтын хүрээнд судалгаа хийж мэдээллийн ил тод байдал, мэдэх эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийн олон талын ололцоотой хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ТХЗ-н хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааны хүрээнд Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага санаачлан *Монгол Хүүхдүүд: "Тогтвортой Хөгжлийн Зорилго-2030"* анхдугаар хэлэлцүүлгийг зохион байгууллаа. ДТХЗ-2030-н талаар хүүхдүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, НҮБ-ын Улс төрийн дээд түвшний чуулга уулзалтад Монгол хүүхдийн төлөөллийг сонгон шалгаруулах тухай танилцуулах, шалгаруулалтын эхний үе шатыг явуулах, ҮСДИ-д хүүхдүүдийн санал, санаачилгыг тусгахад хэлэлцүүлгийн зорилго оршиж байлаа. Боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн эрх ба хамгаалал, хүүхдийн оролцоо, өрхийн эдийн засаг ба зохистой хэрэглээ гэсэн таван салбараар хэлэлцүүлэг явагдсан бөгөөд ТХЗ-н тухай ойлголтыг орон даяар түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэхэд энэ арга хэмжээ чухал үр дүнгээ өгнө гэж найдаж байна.

Сайн Дурынхны Байгууллагуудын Сүлжээнээс “Тогтвортой хөгжлийг хангахад сайн дурынхны оролцоо” сэдэвт зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулав. Тогтвортой хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой орчинг бий болгодог нь ТХЗ-д сайн дурынхны оруулж буй гол хувь нэмэр юм.

Бүх нийт боловсролын төлөө Үндэсний эвсэл “ТХЗ-4-ийг Монгол улсад нутагшуулах нь” Үндэсний зөвлөлдөх уулзалтыг боловсролын оролцогч талуудтай хамтран зохион байгуулж байна. Иргэд, ИНБ-уудын ТХЗ-4-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ном гарын авлага, видео гаргасан ба ТХЗ-4.7 Дэлхийн иргэний боловсрол олон талт симпозиум зохион байгуулсан.

МОНФЕМНЭТ Үндэсний сүлжээ “Эмэгтэйчүүдийн нүдээр: Агаарын бохирдол ба эх, хүүхдийн эрүүл мэнд” XIII чуулганыг зохион байгуулж явуулсан нь цаг үеэ олсон, мэдлэг, мэдээлэл дэлгэрүүлэх, туршлага хуримтлуулах чухал арга хэмжээ боллоо.

Иргэний нийгмийн олон байгууллага, сүлжээ, эвсэлүүд ТХЗ-н тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, засаг захиргааны бүх түвшинд мэдлэг мэдээлэл хүргэх, хэрэгжилтийг үнэлэх боломжийг нээсэн олон талт арга хэмжээг зохиож ҮСДИ бичих үйл ажиллагааг дэмжлээ. Цаашдын хамтын ажиллагаа, ажлын амжилт арвин байх итгэл найдвар дүүрэн байна.

## II. ИНБ-ын САЙН ДУРЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН СТРАТЕГИ

Монголын иргэний нийгмийн байгууллагууд ТХЗ-ыг хэрэгжүүлж, хөгжлийн үр нөлөөг хүн бүрт хүргэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 2017 оны 12 сараас эхлэн “ТХЗ ба ИНБ” сүлжээ болон зохион байгуулалтад орж ажилласан юм. Хөгжлийн үр нөлөө гэдгийг “ядуурлыг арилгах, жендерийн тэгш байдлыг хангах, байгалийн тэнцвэрийг хамгаалан хангах, иргэдийн мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, хариуцлага тооцох чадавхийг сайжруулахад гарсан ахиц дэвшил” гэж олон улсын иргэнийн нийгмийн байгууллагаас тодорхойлсоны дагуу ойлгож байгаа болно.

Сүлжээний зорилгыг ТХЗ, зорилтыг иргэдэд таниулах, тэдний хүчийг дайчлах, орон нутагт иргэдийн олон талтай хамтарч ажиллах, түншлэлийг хөгжүүлэх, нийтээр хөгжлийн идэвхитэй оролцогч болоход дэмжлэг үзүүлэх замаар ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах гэж тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газар ДТХЗ-ын хэрэгжилтээр ҮСДИ боловсруулж НҮБ-ын Улс төрийн дээд хэмжээний чуулган (УТДХЧ)-д танилцуулах тул сүлжээний байгууллагууд ҮСДИ боловсруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, өөрсдийн ажилладаг үйл ажиллагааны хүрээнд холбогдох ТХЗ-н хэрэгжилтээр илтгэл боловсруулан ҮСДИ-д хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн юм. Энэхүү хүсэлтийг Засгийн газрын тайланг бэлтгэх ажлыг манлайлж байгаа МУ-ын Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) хүлээн авч Засгийн газраас байгуулсан ҮСДИ бичих ажлын хэсэгт сүлжээний төлөөллийг оролцуулж, ҮСДИ-ийн хүрээ, агуулгыг тодорхойлох хэлэлцүүлэгт сүлжээний байгууллагууд идэвхитэй оролцлоо.

ҮСДИ боловсруулах үйл явцад оролцохдоо Сүлжээний байгууллагууд дараах стратеги зорилтыг хэрэгжүүлэхээр нэгдсэн болно. Үүнд:

- Сүлжээний байгууллагууд ТХЗ бүрээр баг болон ажиллаж, илтгэлээ бичнэ,
- Сүлжээний байгууллагуудын илтгэл агуулгын хувьд ҮСДИ-д тусгалаа олж, түүнийг баяжуулахад хувь нэмэр оруулахыг зорино,
- Сүлжээний байгууллагуудын илтгэлийн санал, зөвлөмжүүд ҮСДИ-ийн дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгалаа олсон байна.

Сүлжээний илтгэлд ДТХЗ бүрийг:

**ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ  
БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ  
САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

гэсэн бүтцээр, зөвхөн өөрсдийн хэрэгжүүлдэг үйл ажиллагааны хүрээнд бичсэн бөгөөд тайлан бичихэд оролцсон байгууллагуудын товч танилцуулга, салбар дундын тулгамдсан асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудын санал, бодлыг илэрхийлэхийг зорьлоо.

Дэлхий нийтээрээ боловсруулж, харилцан хүлээн зөвшөөрч баталсан Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ), зорилтуудын хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд МУТХҮБ-2030 болон үндэсний түвшний бусад бодлого, хөтөлбөрт хэрхэн туссаныг сүлжээний тайланд голлон анхаарсан болно. Учир нь ДТХЗ, зорилтуудыг өөрийн болгон нутагшуулж, үндэсний хэмжээний бодлого, төлөвлөлтөд суулгаж өгснөөр бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн дээд чуулганаар 2015 онд батлагдсан, 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэй дэлхийн ТХЗ-2030 хөтөлбөрийг нутагшуулах ажлын эхлэл болгон Монгол Улсын Их Хурал 2016 оны 16 дугаар тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (МУТХҮБ-2030)-г 44 зорилт, 20 шалгуур үзүүлэлттэйгээр баталсан. МУТХҮБ-2030 нь ДТХЗ-ын 13 зорилго 43 зорилтын хүрээнд тусгалаа олсон баримт бичиг болсон гэж ҮХГ-ын тайлан<sup>1</sup>-д тодорхойлсон

---

<sup>1</sup> Монгол Улсын Хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээний тайлан, ҮХГ, НҮБХХ, 2018



байна. ҮСХ-ны 2018 онд хийсэн ТХЗ-н хэрэгжилтийг үнэлэх мэдээллийн бэлэн байдлын үнэлгээгээр<sup>2</sup> ДТХЗ-н 118 үзүүлэлтийг хэмжих мэдээлэл бэлэн байгааг дараах хүснэгтэд зорилго бүрээр үзүүлэв.

ТХЗ	Зорилгын нэр	Зорилт /тоо/	Үзүүлэлт /тоо/	Мэдээлэл нь бэлэн үзүүлэлтийн тоо
1	Ядуурлыг устгах	7	14	7
2	Өлсгөлөнг зогсоох	8	13	7
3	Эрүүл мэндийг дэмжих	13	27	16
4	Чанартай боловсролыг дэмжих	10	11	8
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	9	14	8
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	11	6
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	6	4
8	Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	12	17	13
9	Инноваци болон дэд бүтцийн хөгжүүлэх	8	12	6
10	Тэгш бус байдлыг бууруулах	10	11	5
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	15	6
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	13	2
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5	8	3
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10	0
15	Хуурай газрын экосистемийг хамгаалах	12	14	5
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	23	12
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	25	10

“ТХЗ ба ИНБ” сүлжээний тайлангийн төслийг ИНБ-ын олон талт ажлын хэсгүүдэд танилцуулах хэлэлцүүлгийг 5 удаа зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг тусгасан хувилбарыг ҮСДИ бэлтгэх зөвлөх баг, ҮСДИ боловсруулах Ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газарт танилцуулсан явдал бол ИНБ-ын ТХЗ-н хэрэгжилтийн байдлаар тайлан бэлтгэсэн үйл ажиллагааны маш чухал ач холбогдол бүхий үе шат байлаа гэж бид үзэж байна. Сүлжээний байгууллагууд ҮСДИ-ийн тухай Үндэсний хэлэлцүүлэгт идэвхитэй оролцож, санал, зөвлөмжөө илэрхийлсэн болно. ҮСДИ эцэслэн нийтэд тараагдсаны дараа ИНБ-ын санал, зөвлөмж хэр туссаныг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх болно.

Ийнхүү МУ-ын “ТХЗ ба ИНБ” сүлжээний бэлтгэсэн ТХЗ-н хэрэгжилтийг тайлагнах ИНБ-ын илтгэлийг төв, орон нутгийн түвшинд төдийгүй англи хэлээр орчуулж бүс нутаг, дэлхийн олон нийтэд хүргэж байна.

### III. ТАЙЛАНГИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХУРААНГУЙ

#### Монгол Улсад ТХЗ, зорилтуудыг хэрэгжүүлэх бодлого, механизм: Нөхцөл байдал, Зөвлөмж

**Нөхцөл байдал 1. ТХЗ, зорилтуудыг МУ-ын хөгжлийн бодлогод тусгасан нь**  
Одоогоор ТХЗ, зорилтууд бүрэн агуулгаараа МУТХҮБ-2030 - Үндэсний болон салбарын, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусаагүй байна. Мөн ТХЗ, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшинг

<sup>2</sup><http://sdg.gov.mn/Home/Availability>

тодорхойлоогүй байна. Иймээс ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, төсөвлөх ажил хийгдээгүй мөн мэдээллийн бэлэн байдал бүх зорилтуудаар бүрэн хангагдаагүй байна.

*Зөвлөмж 1. ТХЗ-ыг бүрэн агуулгаар нь хөгжлийн бодлогод тусган хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшинг тодорхойлон хэрэгжүүлж эхлэх.*

*ТХЗ, зорилтуудыг МУТХҮБ-2030 үндэсний, бүсчилсэн, орон нутгийн болон салбаруудын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд бүрэн тусгах шаардлагатай байна. ТХЗ, зорилтуудыг хэрэгжүүлэн хүрэх түвшин, хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг олон нийтийн оролцоотой шуурхай боловсруулж, мэдээллийн бэлэн байдлыг ханган нийтийн хэрэгцээнд нээлттэй болгон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, санхүүжилтийг төлөвлөн хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх ажлыг эхлэх хэрэгтэй.*

**Нөхцөл байдал 2. ТХЗ-ын гурван тулгуурын хүрээнд салбаруудын бодлогын уялдаа, нэгдмэл байдлыг хангах, зохицуулах, хянах бүтэц, механизм бүрдээгүй байна.**

ТХЗ-ын гурван тулгуурын хүрээнд салбаруудын бодлогын уялдаа, нэгдмэл байдлыг хангах, зохицуулах, ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, үнэлэх, төлөвлөх үүргийг одоогоор ҮХГ гүйцэтгэхээр хуульчилсан. Гэвч энэ үүргийг хэрэгжүүлэх хангалттай эрх мэдэл ҮХГ-т олгоогүй байна.

*Зөвлөмж 2. ТХЗ-ын гурван тулгуурын хүрээнд салбаруудын бодлогын уялдаа, нэгдмэл байдлыг хангах, зохицуулах, хянах бүтэц, механизмыг бүрдүүлэх.*

*Салбаруудын бодлогын уялдаа, нэгдмэл байдлыг хангах, зохицуулах, ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, үнэлэх, төлөвлөх үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдлийг ҮХГ-т өгөх өөрчлөлтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд хийх хэрэгтэй.*

**Нөхцөл байдал 3. Салбарын болон салбар хоорондын бодлогын зөрчлийг арилгах олон талын зөвлөлдөх механизм байхгүй байна.**

Хөгжлийн (урт, дунд, богино хугацааны, үндэсний, бүсчилсэн, орон нутгийн болон салбарын) бодлогын тэнцвэр, нэгдмэл байдлыг хангаж чадахгүй байна. Үндэсний хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн бодлоготой, эрдэс баялгийг ашиглах бодлого байгаль орчны бодлоготой зөрчилдөх, хөгжлийн томоохон төслүүд нутгийн иргэдийн эрх ашгийг зөрчин тэдний амьжиргааг доройтуулах сөрөг нөлөө үзүүлж байна. Салбарын дотор ч хөгжлийн бодлого, хөтөлбөрийг олон талаар хэлэлцүүлэх шаардлага байна. Тухайлбал ерөнхий боловсролын салбарт багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхчүүд, сургуулийн захиргаа, салбарын мэргэжилтнүүд хамтран хэлэлцэж шийдэх асуудлуудыг нэг талын саналаар шийдэх гэж оролдон олигтой ахиц гаргаж чадахгүй байна. Ийм нөхцөл эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг олон салбарт ажиглагдаж байна.

*Зөвлөмж 3. Салбарын болон салбар хоорондын бодлогын зөрчлийг арилгах олон талын зөвлөлдөх механизмыг байгуулж ажиллуулах*

*Салбар хоорондын бодлогын зөрчлийг арилгах, уялдааг хангах, талуудын эрх ашгийг тэнцвэржүүлэх олон талын зөвлөлдөх механизмыг ҮХГ-ын дэргэд, салбарын хөгжлийн асуудлыг хэлэлцэх олон талын механизмыг яам тус бүрийн дэргэд байгуулан ажиллуулах хэрэгтэй байна.*

**Нөхцөл байдал 4. Яамдын үйл ажиллагаанд ТХЗ, зорилтууд тусгагдаагүй байна.**

Одоогоор яамдын нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, үйл ажиллагааны тайлангийн шалгуур үзүүлэлтүүд ТХЗ-2030 хөтөлбөрийн хэнийг ч үлдээхгүй байх, оролцоот сайн засаглалыг хөгжүүлэх, тэгш бус байдал, ядуурлыг арилгах, жендэрийн тэгш байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах зэрэг салбар дамжсан асуудлуудыг шийдвэрлэхэд дорвитой хувь нэмэр оруулж чадахааргүй байна.

***Зөвлөмж 4. Яамдын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг ТХЗ, зорилтуудтай нийцүүлэх***

*Яамдын үйл ажиллагааны хяналт, үнэлгээний тогтолцоог ТХЗ, зорилтуудтай нийцүүлэн сайжруулах. Үүний тулд яамдын нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, үйл ажиллагааны тайлангийн шалгуур үзүүлэлтийг ТХЗ-2030 хөтөлбөрийн хэнийг ч үлдээхгүй байх, олон нийтийн оролцоот сайн засаглалыг хөгжүүлэх, тэгш бус байдал, ядуурлыг арилгах, жендэрийн тэгш байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах зэрэг салбар дамжсан асуудлуудыг шийдвэрлэхэд оруулсан хувь нэмрээр үнэлэхээр тогтоох шаардлагатай байна.*

**Нөхцөл байдал 5. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд ИНБ-уудын оролцоог гүйцэд хангахгүй, иргэдийн мэдлэг, туршлага, сайн дурын үйл ажиллагааг дайчлахгүй байна.**

ИНБ-ууд нь нийтийн эрх ашиг, байгаль орчинг хамгаалах, хөгжлийн үр шимийг бүх нийтэд хүргэх төрийн үүргийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж, төрийн байгууллагын үйл ажиллагааг хянан үнэлдэг. Түүнчлэн иргэдийн сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулан дайчлах боломж бүрдүүлж байна. Гэхдээ хөгжлийн бодлого, хэрэгжилтийн төлөвлөлт, үнэлгээ, хяналтанд ИНБ-ыг тогтмол оролцуулах механизм бүрдээгүй, иргэдийн сайн дурын үйл ажиллагааг дэмжих бодлого, зохицуулалт байхгүй байна. ИНБ-тай хөгжлийн асуудлаар хэзээ, яаж хамтарч ажиллах тодорхой бодлого, дүрэм журам аль ч яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагад байхгүй. Одоогоор ИНБ-ын оролцоог нэг удаагийн хурал, уулзалтаар хязгаарлах, төрийн байгууллагын ажлын хэсэг, хороодод “өөрсдийн” ИНБ-ыг хамруулах нь түгээмэл. Энэ байдал ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд үргэлжлэх эрсдэлтэй. Үүнийг арилган бүх түвшинд ТХЗ, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахаар ИНБ-ууд чармайж байна. “ТХЗ ба ИНБ” сүлжээ 2030 он хүртэл жил бүр ТХЗ-ын хэрэгжилтээр үнэлгээ, дүгнэлт хийх зорилготой ажиллаж байна.

***Зөвлөмж 5. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд ИНБ-ын оролцоог институтчлах***

*ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулдаг ИНБ-ын үйл ажиллагааг дэмжих, УИХ, ЗГ, ҮХГ, яамд, агентлагууд, орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулах бүтэц механизмд ИНБ-ын төлөөллийг ажиллуулах дүрэм журамтай болж хэрэгжүүлэх. ИНБ-ын төлөөллийг сонгохдоо ТХЗ-ын хэрэгжилтээр зохион байгуулалтанд орон ажиллаж байгаа “ТХЗ ба ИНБ” сүлжээтэй зөвлөх хэрэгтэй байна.*

**IV. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО/ТХЗ/ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

**ТХЗ-1.Ядуурлыг устгах**

**ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ**

МУТХҮБ-2030-д ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгож, 2030 он гэхэд нийт хүн амын 80 хувийг дундаж давхаргын ангилалд багтаах зорилтуудыг дэвшүүлсэн.

Ядуурлын чиг хандлага, хот, хөдөөгөөр



Албан ёсны статистикийн мэдээгээр ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь болж өмнөх үеэсээ эргэн өссөн байна<sup>3</sup>. Энэ чиг хандлага нь 2016-2020 оны хугацаанд ядуурлын түвшинг 18% хүртэл бууруулах ТХҮБ-2030-д дэвшүүлсэн зорилт хэрэгжих боломж хүнд сорилттой тулгарч байгааг харууллаа.

Эх сурвалж: Ядуурлын дүр төрх судалгаа, 2016 ҮСХ

### Төрөөс авч буй арга хэмжээ:

Хүүхдийн мөнгө, Хүнсний талон, Цалинтай ээж, Зорилтот өрх хөтөлбөрүүд болон бусад халамж, хамгааллын арга хэмжээнүүд.

### Тулгарч буй сорилтууд:

- Хүүхдийн мөнгө, Хүнсний талон олгох арга хэмжээний хүртээмж хангалтгүй, зохих эзэндээ хүрэхгүй байх жишээ олон.
- Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлал үндэсний онцлогийг бүрэн тусгаж чадахгүй байна.
- Зорилтот өрх хөтөлбөр нь цөөн тооны өрхийг хүний болон санхүүгийн нөөцдөө тохируулан сонгон ажиллаж байгаа учир хамрах хүрээ нь маш бага байна.
- Ядуурлыг бууруулах тухай МУ-ын Нэгдсэн бодлого байхгүй байна.

**Орон нутагт ТХЗ-ын хэрэгжилт ямар байна вэ?:** Дорнод аймгийн Баяндун сум ТХЗ-2030 хөтөлбөрийн тухай мэдээлэл, мэдлэг дутмаг байна. Хамгийн бага орлоготой өрхөд дэмжлэг үзүүлэх суурь мэдээлэл бүрдүүлдэг амьжиргааны түвшин тогтоох судалгааны бүртгэл үнэн зөв хийгддэг эсэх нь эргэлзээтэй байна.

Хөдөө орон нутагт ажлын байр дутмаг, дэд бүтэц муу хөгжсөн, суманд сүүлийн таван жилд ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөвлөсөн, зарцуулсан төсөв байхгүй байна. Мөн ажилгүй иргэдийн 47 хувийг 20-30 насны залуучууд эзэлж байна.

“Орхигдох эрсдэлд байгаа хүн ам байна уу?”

### Жишээ 1: Цагаан давааны хогийн цэг дээр хийсэн судалгааны дүнгээс...

<sup>3</sup> ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 2016



*Хөгжлийн Хэлхээ Төв ТББ болон Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо хамтран “Өөрчлөх боломж бий” төслийн хүрээнд Цагаан давааны хогийн*



*цэг дээр тогтмол ажиллаж, амьдардаг 94 хүнийг хамруулан 2017 онд 5 өдрийн турш ажиглаж, ярилцаж, асуулга авч энэхүү судалгааг хийсэн болно. Судалгаанд оролцсон 94 хүний ар талд 159 хүүхэд, өөрсдийг нь оролцуулан 211 насанд хүрсэн иргэн нийт 370 хүн амьдарч байжээ. Судалгаанд оролцогчдын 67% нь эмэгтэйчүүд, 28.7% нь иргэний баримт бичиггүй, 47.9% нь бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, 48.9% нь өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байна. Хогийн цэг дээр ажиллаж, амьдарч буй иргэдийн ажиллах нөхцөл наад захын эрүүл ахуй, ариун цэвэр, амьдрах орчны шаардлага*

*хангах боломжгүй байна. Судалгаанд оролцогчдын 8 нь 9 ба түүнээс дээш жил, 27 нь 5-8 жил, 42 нь 2-4 жил, 17 нь 1 хүртэл жил хогийн цэг дээр ажиллаж байгаа бөгөөд тэд нарын 31 нь ажлын хувцас сольдоггүй, 44 нь багаж хэрэгсэл хэрэглэдэггүй, нүцгэн гараар ажилладаг гэжээ.*

**Жишээ 2.** Хөгжлийн хэлхээ ТББ: 2009-2012 он хүртэл гудамжинд гуйлга гуйн амьдарч байгаа 30 гэр бүлийн 42 хүүхэдтэй ажиллан хүүхдүүдийг гэр бүлд нь эргүүлэн нэгтгэсэн. 2012-оноос одоог хүртэл хараа хяналтгүй, хогийн цэг дээр хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, орон гэргүй хүүхдүүдэд өдрийн халамжийн үйлчилгээг үзүүлж жил бүр 30 гэр бүлтэй ажилласнаар 30 хувийг нь өрхийн орлоготой болгосон төдийгүй ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулж ажлын байртай болгон ажиллаж ирсэн. Жил бүр давхардсан тоогоор 60 хүүхдийг хоол хүнс, өмсөх хувцсаар хангаж ажилладаг.



## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХУБ-2030-н 2.2.1.1-д Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно гэсэн зорилтыг дэвшүүлсэн байгаа нь ДТХЗ-той нийцэж байна.

Нийгмийн халамжийн тухай МУ-ын хуулийн 18.3-т Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ гэж заасан нэн ач холбогдолтой заалт амьдралд хэрэгжихгүй байна.

“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах”, “Хүнсний талон” үндэсний хөтөлбөрүүдийн үр дүн зохих эзэддээ бүрэн хүрэхгүй байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Ядуурлыг бууруулах нэгдсэн бодлого алга байна. Ядуурлыг бууруулах арга хэмжээний хүртээмж хангалтгүй, чанаргүй, эзэндээ хүрэхгүй, хэрэгжилт муу, хяналтгүй байна. Монгол Улсын тухайд хэнийг ядуу гэх вэ, гачигдал хомсдолын хэмжүүр ямар байх ёстой вэ гэдгийг ойлгомжтой тодорхойлох шаардлагатай байна. Иймээс дараах арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд анхаарах. Үүнд:

- Ядуурлыг устгах нэгдсэн бодлого, хөтөлбөртэй болох,
- Ядуурлыг тооцох аргачлал, арга зүйг үндэсний онцогийг тусган сайжруулах,
- Ядуу өрхүүд эрхэлж болохуйц жижиг дунд үйлдвэрлэл, жижиглэн худалдаа болон өрхийн үйлдвэрлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн дэмжих,
- Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад нэн ядуу өрхүүдийн хөдөлмөрийн насны иргэд, тэр дундаа өсвөр насныхан, залуусыг үнэ төлбөргүй хамруулах,
- Орхигдож болзошгүй хүн амд хүрч ажиллах үйл ажиллагаанд ИНБ-тай хамтран ажиллах, техник, санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
- Хамгийн бага зардлаар туйлын ядуу өрхийг тогтвортой амьжиргаанд системчлэгдсэн аргачлалаар хүргэж байгаа Дэлхийн Зөн ОУБ-ын аргачлал зэрэг сайн туршлагуудыг нэвтрүүлэх,
- ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилго, зорилтыг орон нутагт таниулах, мэдлэг мэдээлэл өгөх, хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд ИНБ-ын хүчийг ашиглах.

### ТХЗ-2. Өлсгөлөнг зогсоох

#### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Хүн амын хамгийн бага хэрэглээтэй бүлэгт дэмжлэг үзүүлэх “хүнсний талон” хөтөлбөрийг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2015 оноос нийт 24642 өрхийн 135413 хүнд, насанд хүрэгчдэд 13000, хүүхдэд 6500 төгрөгийн тусламж олгож байна. Энэ үйл ажиллагаа нь орлого багатай иргэдийг хоол тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлж хоногт авах шаардлагатай илчлэгийг авах боломж олгож байгаа юм.

*Кэйс: Хүнсний талон эзэндээ хүрэхгүй байгаа тухай нийгмийн сүлжээгээр мэдээлж, хүнсний талон авдаг иргэн “машинтай хүн хүнсний талоноор хүнс аваад явдаг” гэсэн гомдлыг хүнсний эрхээр ажилладаг байгууллагын ажилтанд мэдүүлж байсан.*

МУ-ын Хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудал, 2017<sup>4</sup> үндэсний V судалгаагаар бичил тэжээлийн дутал нь хүн амын бүх бүлэг, ялангуяа нялх, бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тархалттай байгааг тогтоожээ. Бичил тэжээл буюу аминдэм, эрдэс бодисийн дутал нь 5 хүртэлх насны хүүхдийн дунд хамгийн өндөр тархалттай, тэдний 27 хувь цус багадалттай, 21 хувь төмөр, 70 хувь А аминдэм, 90 хувь Д аминдэмийн дуталтай эсвэл хангалтгүй нөөцтэй байсан байна.

Хүнсний баталгаат байдал (ХББ) нь алдагдсан өрхийн үзүүлэлт нийт бүс нутагт түгээмэл, Хангай бүс (80%) болон Улаанбаатар хот (68%)-д хамгийн өндөр, Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 27 хувьд ХББ ноцтой

<sup>4</sup> Монгол Улсын Хүн амын хоол тэжээлийн тулгамдаж буй асуудал, 2017, ЭМЯ, НЭМТ, НҮБХС

алдагдсан нь 5 хүртэлх насны хүүхэдтэй ядуу өрхийн хүн ам хэрэгцээт хэмжээгээр хооллож чадахгүй, хүнсний хомсдолтой байгааг судалгааны дүн харуулж байна.

Хүнсний үнэ тогтворгүй, хүнс баталгаагүй, чанаргүй, гений өөрчлөлтөд орсон байгааг илтгэх баримт олон байна. Тухайлбал:

- Сургууль, нийтийн хоол, хүнсний үйлдвэр зэргийн хоол хүнсэнд хүмүүс бөөнөөр хордох,
- Хоол хүнсний сав баглаа боодол, усны сав нь хүнсний зориулалтын бус хуванцар нийлэг химийн бодисын сав байх,
- Импортоор оруулж ирж буй хүнс, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхойгүй, чанарын баталгаагүй, хугацаа хэтэрсэн, аюулгүй байдалд хийх хяналт шалгалт сул,
- Хүнсний хангамж, түгээлт нэгдсэн системгүй, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах нийтэд үйлчилдэг хөндлөнгийн лаборатори байхгүй зэрэг нь хэрэглэгчдэд аюул дагуулсаар байна.

Дараах зурагт Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Улаанбадрах сумдад



бий болоод байгаа нөхцөл байдлыг харууллаа. Ашигт малтмал олборлох, тээвэрлэхтэй холбоотой үүссэн орчины бохирдол хүнсний аюулгүй байдалд нөлөөлж байна.

Эх сурвалж: Эмэгтэйчүүдийн нүдээр, 2019 чуулган дээр Хил хязгааргүй алхам ТББ-ын Тэргүүн Н.Баярсайханы тавьсан илтгэлээс

Малын бэлчээр, тариалангийн газар хомсдож хөрс ус бохирдож байна. ГЕГ-ын статистик мэдээгээр манай улс 2017 онд 74.8 мянган тонн хүнсний ногоо импортоор оруулсан нь 2016 оноос 5.4 мянган тонноор өсжээ. Дотоодын зах зээлийн төмсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн, харин улаан буудайн 94.4 хувь, хүнсний ногооны 52.5 хувийг хангаж, үлдсэн хувийг импортоор хангасан байна. Улаан буудайн нөөцөд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 2017 онд 2016 оноос 19.7 пунктээр өссөн<sup>5</sup> байна.

ХАА\МАА-н салбарын эдлэн бэлчээр ба тариалангийн газарт ашигт малтмалын лиценз давхардуулан олгосноос үүсэх хохирлыг нөхөх эрх зүйн тогтолцоо байхгүй, уламжлалт зохицуулалттай нүүдэлч малчдын бэлчээр ашиглах эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах эрх зүйн тогтолцоо байхгүйгээс ХАА\МАА-н үйлдвэрлэлийн дэд бүтэц доройтох, хомсдох улмаар үлдэж буй бэлчээр талхлагдах явдал нэмэгдсээр байна. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын мэдээгээр 2017 онд

<sup>5</sup> ҮСХ, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, 2017, тал 107

хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 114.8 сая га болж өмнөх онтой харьцуулахад 87.6 мянган га-гаар, 2013 онтой харьцуулбал 518 мянган га-гаар буурсан<sup>6</sup> байна.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХУБ-2030-д дам байдлаар агуулгын хувьд уялдаж байгаа ч ТХЗ-2-ын зорилтууд огт тусгагдаагүй байгаа юм.

МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хүнсний тухай хууль, 2012, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, 2012 он, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль, 2017, Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр, 2016-2025, Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги, 2016-2021 зэрэг бодлого, эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байгаа боловч бодит амьдралд хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна гэж ИНБ-ууд үзэж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хүнсний үнэ тогтворгүй, хүнсний аюулгүй, шимт, баталгаат чанар алдагдах, генийн өөрчлөлтөд орсон бүтээгдэхүүн элбэгших, хүнсний үйлдвэрлэл, хангамж, түгээлт хяналтгүй, хүнсний зохисгүй хэрэглээ бий болох, хүнсний хангамж, түгээлт нэгдсэн системгүй байгаа бодит байдалд дүн шинжилгээ хийж дараах арга хэмжээг даруй хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байна.Үүнд:

1. Орхигдож болзошгүй хүн амын хүнсний хэрэглээнд үнэлгээ хийж, хүний өлсгөлөнгөөс ангид байх эрхийг баталгаажуулах,
2. Хүнсний талоны хүртээмжийг нэмэгдүүлэх, ядуу, эмзэг бүлгийн нийт өрх, орхигдож болзошгүй хүн амыг бүрэн хамруулах,
3. Эмзэг бүлгийн хүүхдэд зориулсан хүнсний хөтөлбөр нь хүүхдийн хүнсний бүтээгдэхүүнээр авах хоногийн илчлэг, шимт бодисын физиологийн нормын хэдэн хувийг хангаж байгаа эсэхийг тодорхойлж, Хүүхдийн хүнс, тэжээлийн дутагдлыг арилгах бусад арга хэмжээтэй уялдуулах,
4. Бэлчээр, тариалан зэрэг хүнс үйлдвэрлэлийн эдлэн газрыг бусад салбарын хэрэгцээнд зориулж лиценз олгохгүй байх, олгосон тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлж, тухайн газрыг буцаан авах эрх зүйн орчин бүрдүүлэх.
5. Хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, ИНБ-ын оролцоог хангах арга хэмжээг санхүүжилт, эрх зүйн орчноор дэмжих,
6. Хүнсний бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах хараат бус лабораторийн хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн хүний нөөц болон техник технологийг сайжруулах, магадлан итгэмжлэл олгох
7. Монголын үндэсний олон нийтийн радио телевиз иргэдэд зориулж хүнсний асуудлаар шинжлэх ухаанд суурилсан ойлголт, мэдлэг, хүнсний бүтээгдэхүүний тухай бодит мэдээлэл түгээх тогтмол нэвтрүүлэгтэй болох.

## ТХЗ-3. Эрүүл мэндийг дэмжих

*ТХЗ-3.5. Мансууруулах бодис хэрэглэх, түүний дотор хар тамхи хэтрүүлэн хэрэглэх, архийг эрүүл мэндэд хортойгоор хэрэглэх явдлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах*

<sup>6</sup><http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=XAA-2017.pdf&In=Mn>



## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлээр сүүлийн арван жилд /2006-2016 он/ мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг 388 бүртгэгдэж, 1112 хүн холбогдон шалгагдсан бөгөөд дээрх бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр улам нарийсан, уг гэмт хэргийг зохион байгуулалттай үйлдэх болжээ. 2019 он гарсаар Хар тамхитай тэмцэх газраас 130 холбогдогчтой 67 гэмт хэргийг илрүүлэн шалгаж байгаа бөгөөд холбогдогчдын 80 гаруй хувь нь 18-35 насны залуучууд байгаа нь асуудал маш ноцтой байгааг харуулж байна<sup>7</sup>.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХҮБ-2030-д тусгагдаагүй.

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталж, ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан Үндэсний хороог байгуулсан.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодисын хэрэглээ, эрсдэлт зан үйлийг тодорхойлох үндэсний хэмжээний тандалт судалгаа явуулах,
- Дараах үзүүлэлтүүдийг шинээр бий болгох саналтай байна. Үүнд:
  - Архи, тамхи, хар тамхи мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой өвчлөл, нас баралт, сэтгэл гутралыг эмчлэх эмчилгээний төвүүдийн тоо,
  - Архи, тамхи, хар тамхи мансууруулах бодисын донтолтод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны чанар, ялгаварлан гадуурхалтыг бууруулах талаар хийсэн ажлуудад хяналт үнэлгээ хийсэн тухай мэдээлэл бий болгох.

*ТХЗ-3.7.1 Гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээ нь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргаар хангагдсан нөхөн үржихүйн насны (15-49) эмэгтэйчүүдийн хувь*

## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар ГБТ-ийн хангагдаагүй хэрэгцээ 2003-2013 оны хугацаанд 4.6-аас 16.0 хувь болтлоо нэмэгджээ. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хэрэглээ буурч байна. 2003 онд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 69.0 хувь, 2008 онд 55.2 хувь нь жирэмслэхээс сэргийлэх ямар нэгэн эм, хэрэгсэл хэрэглэдэг байсан бол 2013 онд 54.6 хувь болж буурчээ.

Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэхгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлс<sup>8</sup>:

<sup>7</sup>[www.police.gov.mn/a/4363](http://www.police.gov.mn/a/4363)

<sup>8</sup> Монгол улс дахь гэр бүл төлөвлөлтийн чанарын судалгаа, 2016 он, ЭМЯ, НҮБХАС, хуудас 38

- Жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн талаарх буруу ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг байдал,
- нөхөр/хамтран амьдрагчтайгаа ярьж ойлголцох ур чадвар дутуу, найз нөхөд орчин тойрны хүмүүсийн сөрөг хандлага,
- Хоёрдогч ба гуравдагч шатлалын эмч нар эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн жор бичих эрхгүй байгаа нь ГБТ-ийн үйлчилгээний хүртээмжийг хязгаарлаж байна<sup>9</sup>.

Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээний тайланд дурдсанаар Монгол улс эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламжийг маш сайн хөгжүүлсэн хэдий ч ГБТ-ийн тусламжаа орхигдуулсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх гурван шатлалд ГБТ-ийг өргөнөөр, нээлттэйгээр сурталчлахгүй байгаа нь ГБТ-ийн тусламжийн чанар хангалтгүй байгааг нотолж байна.

### **Жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслийн санхүүжилт, зарцуулалт**

Засгийн газар жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн зардлыг тодорхой хэмжээгээр санхүүжүүлж 2009-2013 онд 85-163 сая, 2014 онд 210 сая төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн боловч, 2015-2018 онуудад буурч 150 сая болсон байна<sup>10</sup>.

Жирэмслэхээс сэргийлэх тариа, ерөндөг, суулгац хөнгөлөлтөнд хамрагддаггүй. Хувийн салбар дахь ГБТ-ийн эм, хэрэгслийн санхүүжилтын томоохон эх үүсвэр нь ГБТ-ийн үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгч өөрөө төлөх зардал болж байна. Үйлчлүүлэгч улсын эрүүл мэндийн байгууллагаас жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэл үнэгүй аваагүй бол хувийн эмийн сан, хувийн эмнэлгээс гэр бүл төлөвлөлтийн эм хэрэгслийн нийгмийн маркетингийн хөтөлбөрөөс худалдан авах шаардлагатай болдог.

### **БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ**

МУТХҮБ-2030-д Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих тухай ерөнхий заалт байгаа хэдий ч ДТХЗ-н 3.7.1 үзүүлэлт огт тусгагдаагүй байна.

Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, 2017-2021-т Нөхөн үржихүйн эрхийг хангасан ГБТ-ийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулна гэсэн зорилт дэвшүүлжээ. Энэ зорилтын хүрээнд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь 2014 онд 48.2 байгааг 2020 он гэхэд 60 хувьд хүргэнэ. Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэлд улсын төсвөөс зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээг 2016 онд 150 төгрөг сая зарцуулсан бол 2020 он гэхэд 400 сая болгож өсгөх, 15-49 насны эмэгтэйчүүдийн ГБТ-ийн хангагдсан хэрэгцээ 70 (2014 оны байдлаар) байгааг 2020 онд 80 болгож, жирэмслэхээс сэргийлэх 5-аас доошгүй эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хувь 30.4 (2015 он) байгааг 2020 он гэхэд 50 хувьд хүргэхээр зорьжээ.

<sup>9</sup> Монгол улс дахь гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2016 он, ЭМЯ, НҮБХАС, хуудас 29

<sup>10</sup> Монгол улс дахь ГБТ тусламж үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ, 20-р хуудас, 2016

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон бусад зорилтот бүлгийн мэдээллийг дэлгэрэнгүй гаргах боломжийг НҮТС-ны асуулгад нэмж оруулах,
- “Эрүүл мэндийг дэмжих” зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг МУТХҮБ-2030-д нэмж оруулах замаар хэрэгжилтийг хэмжих боломж бүрдүүлэх,
- Зах зээлд санал болгож буй орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх аргын нэр төрөл, бренд, тэдгээрийн үнэ өртөг, бүтээгдэхүүн бүрийн эрэлт, болон эрүүл мэндийн даатгалын нөлөөлөл зэргийг нарийвчлан судалж, хувийн сектор болон жирэмслэхээс сэргийлэх аргаар мэрэгшсэн төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх,
- Үүдэн эмнэлгүүд, ТББ-ыг даатгалын тогтолцоогоор дэмжих,
- Умайн ерөндөг, тариа, суулгац зэргийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, хоёрдогч ба гуравдагч шатлалын бүх эрүүл мэндийн байгууллагад хүртээмжтэй болгох, жор бичих эрхийг бүх эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт олгох талаар судлах.

### ТХЗ-4. Чанартай боловсролыг дэмжих

Эрүүл мэндийг дэмжих 3.7, Жендэрийн эрх тэгш байдлын 5.6, Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийн 8.6, Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн 12.8, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах 13.3 - зорилтууд боловсролын зорилготой шууд хамааралтай байна.

## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

### *ТХЗ-4.2.1 Эрүүл мэндийн байдал, сэтгэх, суралцах чадвар, нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн хувьд зөв төлөвшилд яваа 5-аас доош насны хүүхдүүдийн эзлэх хувь*

2013 оны НҮТС-ны дүнгээр 76% байгаа нь 2010 оны түвшнээс (85.1%) буурсан байна. Бие бялдрын ба суралцах чадварын хөгжлийн хувьд 97.8-99.0%-ийн өндөр үзүүлэлттэй гарч байгаа ч хүүхдүүдийн 75.7% нь л нийгэм сэтгэл зүйн хөгжлийн хувьд хэвийн түвшинд явж байгааг анхаарах шаардлагатай. Эрэгтэй, үндэсний цөөнх, тусгай хэрэгцээтэй байх зэрэг нь хүүхдийн хөгжлийн үр дүнд нөлөөлж, бага буюу доогуур оноо авах нөхцөл болж байна.

### *ТХЗ-4.2.2 Сургуульд орох албан ёсны насанд хүрэхээс нэг жилийн өмнө зохион байгуулалттай сургалтад хамрагдагчдын эзлэх хувь*

2016 онд өмнөх оноос өссөн (66.2-68.3%) боловч 2017 онд эргээд буурсан (64.6) дүн гарчээ. 2017/2018 оны хичээлийн жилд нийт шинээр элсэгчдийн 6.4 хувийг сургуульд элсэх наснаас хожуу насандаа элссэн суралцагч эзэлж байгаа болон СӨБ-ын хамран сургалтын хувь 2017 оны байдлаар 79.2% байгаа нь СӨБ-ын стандарт, хөрөнгө оруулалтад анхаарах шаардлагатай байгааг харуулж байна. Малчдын хүүхдийг СӨБ-д хамруулахаар нүүдлийн гэр цэцэрлэг ажиллуулсан ч хамрагдалт бага хэвээр төдийгүй хүүхдийн хөгжлийн үр дүнгийн үзүүлэлтээр ердийн цэцэрлэгт хамрагдсан хүүхэдтэй харьцуулах боломжгүй доогуур байдалд байна.

**ТХЗ-4.3.1 Сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан насанд хүрэгчид, залуучуудын эзлэх хувь**

Бодлогод залуусын хяналт ТББ-аас Насан туршийн боловсролын төвүүд болон төрийн санхүүжилттэй бусад сургалтын байгууллагуудын хүртээмж, залууст ээлтэй байдлын зураглалыг 2018 онд хийлээ. Зураглалд 10 аймагт үйл ажиллагаа явуулдаг 62, нийслэл Улаанбаатар хотод байрладаг 28 сургалтын байгууллагыг хамруулсан. Зураглалаас харахад сургалтын байгууллагууд хүн ам нягт суурьшсан гэр хороололд цөөн, орон сууцны хороололд олноор ажиллаж байна.



Жилд төлөвлөсөн зорилтот бүлгийнхээ 10%-д спорт урлагийн болон олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа ихэвчлэн зохион байгуулж сургалт, боловсролын үндсэн хөтөлбөрийн үйл ажиллагааг орхигдуулж байна.

**ТХЗ-4.6.1 15-24 насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын хувь, хүйсээр**

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 15-24 насны эрэгтэйчүүдийн дунд бичиг үсэгт тайлагдалт 95.2 %, эмэгтэйчүүдийн дунд 97.5% байсан бөгөөд 2013 онд хийсэн НҮТС-аар энэ хувь өөрчлөгдөөгүй байна. Хотод залуучуудын дунд бичиг үсэг үл мэдэх байдал бараг устсан (эрэгтэй-98.4% ба эмэгтэй-99.2%) байхад хөдөөд эрэгтэйчүүдийн бичиг үсэгт тайлагдалт 88.2% байгаа нь туйлын доогуур үзүүлэлт юм. Ядуу өрхийн залуусын эрэгтэйчүүдийн хувьд 84.4%, эмэгтэйчүүдийн хувьд 87.9% байгаа нь анхаарал татна. Бичиг үсэг тайлагдалтын түвшинг өмнөх 10 жилийн бага боловсролын үр дүн гэж үздэг ба нийгмийн дэвшил, эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх хүчин зүйл гэж тооцдог.

**ТХЗ-4а1 (а) Цахилгаан эрчим хүчинд холбогдсон; (б) сургалтын зорилгоор ашиглах интернеттэй; (в) сургалтын зорилгоор ашиглах компьютертэй; (г) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан дэд бүтэц, сургалтын материалаар хангагдсан, (д) ундны усаар хангагдсан; (е) эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн байгууламжтай; and (ё) гар угаах өрөөтэй (WASH үзүүлэлтийн тодорхойлолтын дагуу) сургуулиудын эзлэх хувь**

Цахилгаан эрчим хүчинд холбогдсон сургуулиудын эзлэх хувь 2015 оноос хойш тогтмол 96.6%-тай байгаа бол сургалтын зорилгоор ашиглах интернеттэй сургуулиудын эзлэх хувь бага зэрэг өсч 67.8-68.4%-д хүрчээ. Сургалтын зорилгоор ашиглах компьютертэй сургуулиудын эзлэх хувь бага зэрэг нэмэгдэж, 94.8-95.4% болжээ.

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-ийн 522 дотуур байранд 34,7 мянган хүүхэд амьдарч байгаагийн 82 хувь нь малчин өрхийн хүүхдүүд байна. Дотуур байранд суухаар хүсэлт гаргасан 38,444 хүүхдийн 35,196 нь дотуур байранд орж чадсан байна. БСШУСЯ, НҮБХС-тай хамтран 2017 онд зохион байгуулсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдал” судалгааны үр дүнгээс үзэхэд нийт дотуур байрны 71 хувь нь төвлөрсөн бус усан хангамжтай, 61 хувь нь гадаа байрлах нүхэн жорлонтой, зөвхөн 17 хувь буюу 68 дотуур байр дотор байрлах ариун цэврийн өрөөтэй байна. Дотуур байрны 56 хувьд нь сурагчид халуун усанд орох боломжтой байна.

*ТХЗ-4.с.1 Тухайн шатны сургуульд багшлах ур чадварын хамгийн бага шатны сургалтад багш болохоосоо өмнө болон багш болсны дараа хамрагдсан багш нарын эзлэх хувь (а) сургуулийн өмнөх, (b) бага, (c) дунд, (d) ахлах сургуулийн багш нарын дунд*

2015 онд СӨБ-ын багш нарын 95.7% нь, бага сургуулийн багш нарын 92.7% нь, дунд болон ахлах сургуулийн багш нарын 82.4% нь тухайн шатны сургуульд багшлах ур чадварын наад захын сургалтад багш болохоосоо өмнө хамрагдсан байна. Тэгвэл 2017 онд энэ хувь СӨБ-ын шатанд 95% болж буурч, бага болон дунд, ахлах сургуулийн багш нарын хувьд 98.8% болон 99.2% болж тус тус өсчээ.

#### **Албан ёсны статистикийн мэдээллээр гарахгүй байгаа үзүүлэлтүүд:**

*ТХЗ-4.1.1 (i) Унших болон (ii) тоо бодох наад захын чадварыг эзэмшсэн (а) 2/3-р анги, (b) Бага анги төгссөн, (c) Дунд анги төгссөн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр*

Сурагчдын хөтөлбөрийн сорилын гүйцэтгэлийг авч үзвэл бага боловсролын I ангийн сурагчдын дунд 60-100 хувийн гүйцэтгэлтэй сурагчдын эзлэх хувь 90.6; II ба III ангид 41-80 хувийн гүйцэтгэлтэй сурагчдын эзлэх хувь харгалзан 85.4 ба 88.3; IV ба V ангид 21-60 хувийн гүйцэтгэлтэй нь 84 ба 98 хувь байна. Энэ нь анги ахих тусам сурагчдын гүйцэтгэлийн хувь буурч, хангалтгүй гүйцэтгэлтэй сурагчдын эзлэх хувь өсч байна. Сургалтын үр дүнтэй гарц гэж юу болох, унших болон математикийн наад захын ур чадвар эзэмшсэн байх зэргийг тодорхойлж, хэмжиж эхлэх шаардлагатай.

*ТХЗ-4.7.1 (i) Дэлхийн иргэний боловсрол жендэрийн тэгш байдал, хүний эрхийн асуудлыг хамруулсан (ii) тогтвортой хөгжлийн боловсролыг (а) үндэсний боловсролын бодлого, (b) сургалтын хөтөлбөр, (c) багш нарын боловсрол болон (d) суралцагчийн үнэлгээнд тусгасан байдал*

Боловсролын хүрээлэнгээс “Дэлхийн иргэний боловсрол: Монгол улсад” ЕБС, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн шинжилгээг хийсэн бөгөөд Дэлхийн иргэний боловсролын сэдвүүд болон суралцахуйн зорилго, зорилтууд манай улсын ерөнхий боловсролын одоо мөрдөж буй нийгмийн ухаан, иргэний боловсролын хөтөлбөр ба сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулга, чиглэл, аргазүй, үнэлгээнд ямар нэг байдлаар тусгалаа олсоныг бидний шинжилгээ харуулж байна. Бага, суурь

боловсролын сургалтын цөм хөтөлбөрт глобаль болон бүс нутгийн түвшний асуудал бага, харин тухайн улс үндэстний асуудал түлхүү тусгагдсан байна гэж дүгнэжээ.

Азийн 22 улс орны боловсролын бодлого, бага ба дунд боловсролын сургалтын хөтөлбөрт, ялангуяа гол хичээлүүдийн агуулгад ТХЗ-4.7 хэр туссаныг шинжилж үзэхэд Монгол улсын хувьд хүний сайн сайхан, аюулгүй байдал, энх тайван, байгаль хамгаалал, байгаль орчны тогтвортой байдал, хүний эрх, эрх чөлөө, соёл, өв уламжлал зэрэг агуулга, амьдрах ухааны, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх, бүтээлч болон шүүмжлэлт сэтгэхүй зэрэг ур чадварууд хангалттай хэмжээнд туссан байна гэж дүгнэжээ. Гэтэл эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдлын менежмент, эрүүл амьдрах хэв маяг, нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрийн тэгш эрх, тэнцвэрт байдал, хэм хэмжээ, нийгэмшил, охид/эмэгтэйчүүдийн эрх мэдэлжилт, энх тайвныг тогтоох, хүчирхийллийн хэлбэрийг таних, дэлхийн засаглалын тогтолцоо, үйл явц, үндэстэн дамнасан корпорациуд, терроризм, ядуурал, тэгш бус байдал, колониололын түүх, олон соёл, ялгаатай байдлыг хүндэтгэх, хүн төрөлхтний айдентити зэрэг агуулга огт тусгагдаагүй, цогцоор сэтгэх, системтэй сэтгэх, дэлхийн болон орон нутгийн түвшинд сэтгэх, 21-р зууны ур чадваруудад сургах байдал хомс байгааг илрүүлжээ.

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд 25 сургуулийн 186 бүлэгт 7,335 суралцагч 3-р ээлжинд хичээллэж байна. Эдгээр 3-р ээлжийн бүлгийн 85.5% нь бага ангийнх байна. Цаашид энэ тоо өсөх магадлалтай байна. Гурван ээлжээр хичээллэж байгаа 25 сургуулийн 3 нь аймагт, 22 нь Улаанбаатар хотод байрлаж байна. 2013-2014 оны хичээлийн жилээс хойш энэ тоо буурсангүй. Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт 28.3 байгаа нь өмнөх жилээс 0,2 пунктээр, үүнээс төрийн өмчийн сургуульд 29.5 байгаа нь өмнөх жилээс 0,5 пунктээр тус тус өсчээ. Бүлэг дүүргэлт нормативт хэмжээнээс дээгүүр буюу 37.0-53.7-той нийслэлийн 35, аймгийн 5 сургууль байгаа ба өмнөх жилээс нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХҮБ-2030, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ДТХЗ-н үзэл санаа хэрхэн туссан байдалд дүн шинжилгээ хийсэн дүнгээс харахад:

1. Боловсролын **хүртээмжийг** зонхилон анхаарсан,
2. Насан туршдаа суралцахуй, тэгш хамруулах боловсрол, боловсролын чанарыг өргөн хүрээнд авч үзэх, боловсрол дахь тэгш байдлыг хангах зэрэг чухал үзэл санаа, зарчмууд тусгалаа олоогүй,
3. Эдгээр бодлогын баримт бичгийн зарим заалтууд хоорондоо уялдаа холбоогүй, бие биетэйгээ зөрчилдөж байна<sup>11</sup>.

Тухайлбал, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2014-2024 баримт бичигт ЕБС-иуд 2024 он гэхэд нэг ээлжээр хичээллэх боломж бүрдэнэ, ТХҮБ-2030-д 2026-2030 онд 2 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог 50 хүртэл хувиар

<sup>11</sup> “Боловсрол: Чанар, санхүүжилт, хариуцлага” иргэний нийгмийн үндэсний 7-р чуулганд оролцогчдоос Монгол улсын Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүлэх санал, 2016

бууруулахаар заасан байгаа нь дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүд уялдаагүй, бодит тооцоон дээр суурилагагүй байгааг харуулж байна<sup>12</sup>.

МУТХҮБ-2030 болон ГТХ бодлого, 2018-2020-д боловсролын салбарт тулгамдсан гол асуудал болох чанартай боловсрол олгох зорилт байгаа **ч сургалтын чанарыг сайжруулах** чиглэлээр авах арга хэмжээ огт тусгагдаагүй, олон улсын чанарын судалгаанд хамрагдахыг үр дүн болгосон нь хэт явцуу зорилт юм. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичгээс бусдад нь санхүүжилтыг хэрхэн зохицуулсан талаар тодорхой заалт байхгүй, боловсролын санхүүжилтыг тэгш хувиарлах талаар огт дурьдаагүй байна.

Монгол улсын боловсролын талаархи бодлогын баримт бичигт насан туршийн боловсролын талаар “Иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх” тухай хэд хэдэн заалтууд тусгагдсан байна. Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах үе шаттай арга хэмжээ авах, орчин үеийн эрэлт хэрэгцээг хангахуйцаар сургалтын агуулга хөтөлбөрийг өөрчилж, түүнд нийцсэн лабораторийн техник, технологийн шинэчлэлийг хийж Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрөлжүүлэх гэх мэт заалтууд орсон нь сайшаалтай.

МУТХҮБ-2030-д насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ гэсэн үр дүнгийн зорилт байгаа ч “Насан туршийн боловсрол” гэдэг ойлголтыг тодорхойлоогүй тул зөвхөн насан туршийн боловсролын төвийн буюу одоогийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар хязгаарлах эрсдэлтэй байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Боловсролын хүртээмж, гарах үр дүн хүн бүрт ижил бус байгаа нь нийгмийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх, ядуурлыг гүнзгийрүүлэх, “хэнийг ч орхигдуулахгүй” байх зорилт боловсролын салбарт хэрэгжихгүй байгаа шалтгаан болж байна. Боловсролын салбарыг улс орны хөгжлийг хурдасгагч гэж харахын оронд нийгмийн хөгжилтэй хамаатай зорилт гэж явцуу харж байна. Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын асуудлууд дийлэнх тохиолдолд боловсролын салбарын төсөв, санхүүгийн боломж, цалин хангамж, ажиллах орчин нөхцөл, эцэг эхчүүдийн хандлагатай ихээхэн холбоотой байна.

Чанартай боловсролыг дэмжих дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх санал дэвшүүлж байна. Үүнд:

- МУТХҮБ-ын боловсролын салбарын гол үзүүлэлтийг дундачлах биш ЕБС-ийн анги дүүргэлтийг Бага/дунд, хот/хөдөө, сум/аймгийн төв, хотын төв/гэр хороолол, улс/хувийн сургуулиудаар ялгаж гаргах,
- Сургуульд бэлтгэх шаардлагыг хангасан бага насны хүүхдийн хөгжил, халамж, боловсролыг багтаасан наад зах нь нэг жилийн чанартай СӨБ-ыг үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх зорилго тавих,

<sup>12</sup> “Залуусын дүн шинжилгээ” Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2016 он



- Сургуульд огт элсээгүй, элсээд завсардсан хүүхдэд тулгарч байгаа саад тогторыг судалж тогтоох, түүнийг арилгахад чиглэсэн тогтвортой арга хэмжээг нэн даруй авах,
- Бүх хүүхдийг хамруулах гэсэн нийтлэг зорилгын үүднээс мөн боловсролын ердийн тогтолцоо нь бүх хүүхдийг сургах ёстой гэсэн итгэл үнэмшлийн үүднээс агуулга, хандлага, бүтэц, стратегид өөрчлөлт хийх,
- Хүртээмж, оролцоо, сурлагын амжилтанд байгаа гадуурхал, маргиналчлал, ялгаатай байдал, тэгш бус байдлыг шийдвэрлэх-**хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, үндэстний цөөнх, хөдөлмөр эрхлэгч, нинжа нарын хүүхдүүд, морь унаач, малчдын хүүхдүүд зэрэг** хүүхдүүдэд чиглэсэн бодлого, төсвийн хүчин чармайлт гаргах,
- Чанартай боловсрол олгох болон сургалтын үр дүнг сайжруулахад мэргэжлийн түвшинд сайтар бэлтгэгдсэн, өндөр ур чадвартай, урам зориг бүхий чадварлаг багш, сурган хүмүүжүүлэгчдэд зохистой удирдлага, бүрэн хангагдсан нөөц бүхий орчинд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх,
- Тогтвортой хөгжлийн боловсрол, Дэлхийн иргэний боловсролоор дамжуулан олон улсын болон орон нутгийн түвшинд тулгамдаж буй сорилт, бэрхшээлд хариу үйлдэл үзүүлэх замаар шийдвэр гаргах, амьдрах чадварыг нийт иргэдэд эзэмшүүлэх,
- Албан бус, сургуулиас гадуур эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжийг хүлээн зөвшөөрч, магадлан итгэмжлэх, жишиг болгон шилжүүлэн тооцох зэрэг боловсролын уян хатан чанарыг дээшлүүлэх,
- Дээд боловсролын үр дүн, эрдэмийн зэрэг цолд чанарын баталгаажилт хийх, чанартай зайны сургалтыг интернет, олон нийтэд нээлттэй онлайн хичээлийн хүртээмжийг сайжруулж, чанарын стандартыг хангасан бусад арга хэлбэрүүдийг зохих санхүүжилт, технологи ашиглалтын хамт нэвтрүүлэх,
- ЕБС-иудын үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл дарамт, архи тамхины хэрэглээ зэрэг хүүхдүүдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадавхийг бий болгох, “боловсролын (сургуулийн ба дотуур байрны) орчин дах хүүхэд хамгаалал” хөтөлбөрийн санхүүжилтийг шинээр бий болгох,
- Үндэсний/аймаг, орон нутгийн түвшинд дараах асуудлаар боловсролд хамаатай талууд зөвлөлддөг соёлыг тогтоох:
  - ✓ Боловсролын бодлогын тэргүүлэх чиглэл, стратегия тодорхойлох,
  - ✓ Хөтөлбөрийн төлөвлөлт хийх,
  - ✓ Үйл ажиллагааны төлөвлөлт хийх,
  - ✓ Мониторинг үнэлгээ хийх арга замаа тодорхойлох,
  - ✓ Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх
- Үндэсний хэмжээнд боловсролд хамаатай талууд (багш, эцэг эх, ИНБ-ууд, судлаачид, хандивлагчид гэх мэт) тогтмол зөвлөлдөх олон талын оролцоотой механизм байгуулах, байнгын үйл ажиллагаатай болгож төлөвшүүлэх, дараах ажлуудыг хийж гүйцэтгэх:
  - ✓ Боловсролын салбарын нөхцөл байдлын үнэлгээг олон талын оролцоотой хийх,



- ✓ Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, дахин шинэчилж хийх,
  - ✓ Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль бодлого, хөтөлбөрүүдэд үнэлгээ хийх, шаардлагатай бол өөрчлөлт хийх
- Боловсролын “Удирдлага мэдээллийн сан”-гийн хүүхдийн сурлагын дүн гэх мэт мэдээллээс бусад боловсролын статистикийн мэдээлэл, төсөв, санхүү, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, иргэд, ИНБ-ууд ашиглах боломжийг бүрдүүлэх,
  - Агаарын бохирдолд ихээр өртдөг хүүхдүүдэд богино хугацаанд шууд эерэг үр нөлөө үзүүлэх магадлалтай, хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнд анхаарах тухайлбал, пневмококкийн вакциныг хийх, хүүхдэд зориулсан олон нийтийн газрын дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, олон нийтийг сайн чанарын амны хаалтын хэрэглээ, хүртээмжийн талаар зааварчилгаа мэдээллээр хангах, олон нийтийн зан үйлд тасралтгүй нөлөөлөх мэдээлэл сурталчилгааны аян зохион байгуулах,

- Монгол Хүүхдүүд: "Тогтвортой Хөгжлийн Зорилго-2030" Анхдугаар хэлэлцүүлэгт оролцогчдын санаачлага, Дэлхийн зөн ОУБ:
- Улсаас цэцэрлэг, сургууль, эмнэлэг барихаар төлөвлөхдөө барилгын

Тулгамдаж буй асуудал	Шийдэл
<p>Сургууль дээр хичээлээс гадуур анги байдаггүй</p> <p>Сурах бичгийн хүрэлцээ муу, чанар нь харилцан адилгүй</p> <p>Сургалтын <b>хөтөлбөрт</b> нийгмийн чиглэлийн агуулга хангалтгүй, байгалийн шинжлэх ухааны агуулга илүү байдаг. Гэтэл нийгэм маш хурдацтайгаар цаг үеэ даган өөрчлөгдөн шинэчлэгдэж байна</p> <p>Сургуулийн шийдвэр гаргах түвшинд хүүхдүүдийн саналыг сонсох- нийгмийн ажилтан сонгохдоо хүүхдийг оролцуулах</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн ЕБС-д суралцахад багш хүүхдүүдийн сургуулийн хандлага эерэг байх</p> <p>Боловсролын хөтөлбөр маань хүүхдийн хэрэгцээнд нийцсэн уян хатан байх</p> <p>Гэр бүл, хүүхэд, багшийн оролцоотойгоор хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг багасгах</p> <p>Багшийн ур чадвар арга барилыг нэмэгдүүлэх</p> <p>Ялгаварлан гадуурхахгүй, тэгш харилцааг бий болгох</p> <p><b>Сургуулийн хүүхдүүдэд зориулсан харилцаа, хандлага, хувь хүний хөгжилд чиглэсэн амьдрах ухааны агуулгатай сургалтуудыг хүртээмжтэй болгох</b></p> <p>Багшийн ёс зүй үүргээ ухамсарлах</p> <p>Сургуулийн материаллаг орчинг сайжруулах</p> <p>Хичээлийн хэрэглэгдэхүүн, лабораторийг нэмэгдүүлэх тав тухтай орчинг бий болгох</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих</p> <p>Багш нарыг үнэлдэг тогтолцоог нь сайжруулах</p> <p>Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин сургууль болон сургуулиас гадуур олноор бий болгох</p> <p>Сургууль, гэртээ гадуур хувцсаа уутанд хийж тавих</p> <p>Сургууль дотроо углааш хэрэглэж байя, эсвэл гутлаа солих</p> <p>Спорт заалыг сурагчдад үнэгүй олгох, олон спорт заал байгуулах</p>

дулаалга, тусгаарлагчийн зардал, мөн дотоод агаарын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх хөрөнгийн зардлыг төсөвт суулгаж тооцох,

- Цэцэрлэг, сургууль, эмнэлгүүдэд техникийн шийдэл болон зан үйлийн өөрчлөлтийг хослуулсан дотоод агаарын чанарын удирдлагын цогц аргачлал боловсруулж хэрэгжүүлэх.

### ТХЗ-5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах

#### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

*ТХЗ-5.2.1 Сүүлийн 12 сарын хугацаанд одоогийн болон хуучин хамтран амьдрагчийнхаа зүгээс бие махбодь, бэлгийн эсвэл сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байсан 15 болон түүнээс дээш насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь*

ҮСХ-ны 2017 оны Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны<sup>13</sup> тайланд 15-49 насны эмэгтэйчүүдийн 14.7 хувь, 15-64 насны эмэгтэйчүүдийн 12.7 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна гэжээ. Сүүлийн 12 сарын байдлаар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь харилцан адилгүй байгаа бөгөөд энэ үзүүлэлт Өвөрхангай (19.4%), Дундговь (15.3%), Өмнөговь (15.3%) аймагт хамгийн өндөр байна. Гэтэл улсын дундажаас өндөр тархалттай дээрх аймгуудад нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байр огт байхгүй байна. Энэ нь хүчирхийлэлд өртсөн хохирогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал хамгаалагдаж чадахгүй байсаар цаг бусаар эндэхэд хүргэж байна.

*Тохиолдлын жишээ: Хохирогч Э, суманд амьдардаг, 28 настай, 3 хүүхэдтэй, нөхөртэйгээ амьдраад 8 жил болсон. Түүнийг гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг талаар орон нутгийн цагдаа болон ах дүү, төрөл төрөгсөд нь мэддэг байсан ч ямар ч туслалцаа үзүүлж байгаагүй. Тэрээр 2017 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас нөхөртөө зодуулж амь насаа алдсан. Гэр бүлийн хүчирхийллийн хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдэгдсэн хүн амины гэмт хэрэг байтал хуулийн байгууллага нөхрийг нь “бусдыг амиа хорлоход хүргэсэн” (бага ял авдаг) гэсэн эрүүгийн хуулийн зүйл ангиар 2018 онд шийтгэсэн.*

### *ТХЗ-5.6 Нөхөн үржихүйн эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг хүн бүрт хүртээх*

#### *Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хангагдаагүй хэрэгцээ*

НҮТС, 2013<sup>14</sup> оны дүнгээс үзэхэд 2010-2013 онд ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээ 15-19 насныхны дунд 2.6 дахин өсчээ. Өсвөр насны охидын төрөлтийн болон үр хөндөлтийн түвшин өндөр байгаа нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдахгүй байгааг илтгэсэн ихээхэн ноцтой чиг хандлага юм<sup>15</sup>. Нийт төрөлтөд 15-19 насны охидын төрөлтийн эзлэх хувь сүүлийн 10 гаруй жилд харьцангуй тогтвортой байж, 2016 онд бага зэрэг буурсан ч, 15-19 насны 1000 охид тутамд ногдох төрөлтийн түвшин мөн хугацаанд бараг 2 дахин өсч, 33.1-д хүрсэн нь энэ хугацааны хамгийн өндөр үзүүлэлт юм.

Зураг 5. 15-19 насны 1000 охид тутамд ногдох төрөлтийн түвшин

<sup>13</sup> Хүчирхийллийн нүцгэн үнэн: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа, 2017, ҮСХ, НҮБХАС, AusAID болон Швейцарийн хөгжлийн агентлаг

<sup>14</sup> Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018 онд хийгдсэн ч одоогоор үр дүн нь эцэслэгдэн мэдээлэгдээгүй байгаа тул 2013 оны судалгааны дүнгээс эшлэл татсан баримтуудыг ашиглаж байгааг анхаарна уу

<sup>15</sup> Бэлгийн болон нөхөн үржихүйн баримтын хуудас-2018, ЭМЯ, НҮБ-ын Хүн Амын Сан



Эх сурвалж: Бэлгийн болон нөхөн үржихүйн баримтын хуудас-2018, ЭМЯ, НҮБХАС

15-19 насны охидын үр хөндөлтийн түвшин 2003 онд 1000 охид тутамд 0,6 байснаа 2013 онд 4,9 болж өсчээ. Өсвөр насныхны дунд үр хөндөлт өсч, бэлгийн замаар дамжих халдварын түвшин буурахгүй байгаа нь тэдэнд ээлтэй тусламж үйлчилгээ хүртээмжгүй, өөрсдөө болон эцэг эх, асран хамгаалагч нь өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар хангалттай мэдлэггүй байгааг илтгэж байна<sup>16</sup>.

ЕБС-ийн 2018-2019 оны хичээлийн жилээс бэлгийн цогц боловсролын агуулгыг багтаасан Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг бие даасан хичээлээр судалж эхэлсэн нь нөхөн үржихүй, бэлгийн эрхийг хангах чиглэлд гарсан ахиц дэвшил юм. Одоо үндэсний хэмжээнд эрүүл мэндийн хичээл зааж буй багш нарыг давтан бэлтгэх, нөөц багш бэлтгэх зайлшгүй хэрэгцээ үүсч байгаа ба уг ахиц дэвшлийг тогтвортой хадгалахын тулд бодлого, санхүүжилтийн түвшинд хүчин чармайлт гаргах, эрүүл мэнд, боловсролын салбарын уялдаа, салбар дундын зохицуулалт, олон талт түншлэгчдийн хамтын ажиллагааг зангидах, ТХЗ-3.7-гийн үр нөлөөг хэмжих үүднээс эрүүл мэндийн хичээл заахаар тусгайлан бэлтгэгдсэн багшийн тоог шалгуур үзүүлэлтийн нэг болгож тусгаж өгөх шаардлагатай.

*Монгол Хүүхдүүд: "ТХЗ-2030"  
Анхдугаар хэлэлцүүлэгт  
оролцогчид, Дэлхийн зөн ОУБ:*

- Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангалттай бус,
- Сургуулийн гадна, доторх орчин, хоолны газар, бие засах газар ариун цэврийн анхан шатны шаардлага хангахгүй байна,
- Эрүүл мэндийн боловсролын мэдлэгийг үе шаттайгаар огт авч чадахгүй байна.

МУ-ын Засгийн Газар ЖСАХ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, 2019 оны улсын төсөвт 1.7 тэрбум төгрөг суулган баталсан нь энэ чиглэлээр гаргасан томоохон дэвшил болохыг онцолж байна. Бүх аймаг, орон нутагт нийгмийн эрүүл мэндийн газраар дамжуулан төсвийн хүрээнд худалдан авч, өсвөр үеийн клиник, оюутан, малчин эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд хуваарилагдахаар төсөвлөгдсөн энэ санхүүжилтийн хуваарилалт болон зорилтот бүлэгтээ хүрч байгаа эсэхэд мониторинг хийх явцын хяналтын механизмыг тухайн иргэд болон ТББ-уудын оролцоотойгоор бий болгож хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээр хэнийг ч орхихгүй байх зарчим хангагдах ба цаашид ХДХВ халдвартай

<sup>16</sup> Бэлгийн болон нөхөн үржихүйн баримтын хуудас-2018, ЭМЯ, НҮБ-ын Хүн Амын Сан

хүмүүсийг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг үнэ төлбөргүй авах бүлэгт нэмж оруулбал 2030 оны зорилтот түвшинд хүрэх нөхцөл бүрдэнэ.

### *Эхийн эндэгдэл*

Эхийн эндэгдэл 2016 онд огцом өсч, сүүлийн 2 жилд 2015 оны түвшин рүү буцаад буурчээ. Хамгийн сүүлд хийсэн эхийн эндэгдлийн судалгаагаар<sup>17</sup> эхийн нас баралтын талаас илүү хувь (54%) нь цус алдалт, үжил халдвар болон цусны даралт ихсэх зэрэг эх барихын шууд шалтгаанаас үүдэлтэй байна. Мөн нийт эндэгдлийн 45%-ийг жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тусламжийг чанартай, үр дүнтэй үзүүлснээр сэргийлэх боломжтой байсан гэж дүгнэжээ.

НҮТС-2013 жирэмсний хяналтын чанарыг 5 үзүүлэлтээр тодорхойлж, чанартай хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувийг тооцоход улсын хэмжээнд дөнгөж 37.3% байв.

Эрүүл мэндийн тухай хуулинд жирэмсний хяналт, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэхээр заасан ч жирэмсэн эхчүүд хувийн эмнэлэгт оношлогоо шинжилгээнд багагүй мөнгө зарцуулж байна<sup>18</sup>.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

ТХЗ-5 жендэрийн эрх тэгш байдал нь МУТХҮБ 2030-ын 2.2-ын **зарчим** хэсэгт ерөнхий байдлаар тусгагдсаныг эс тооцвол орхигдсон зорилго гэж тооцогдож байна.

МУТХҮБ 2030-ын 2.2.2.2-т Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн зорилтуудыг дэвшүүлж, шалгуур үзүүлэлтүүд, суурь түвшинг тодорхойлжээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, 2017-2021 батлагдсан.

Дээрх зорилтуудад хүрэхийн тулд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

---

<sup>17</sup> Эх яагаад эндэв, 2012-2015

<sup>18</sup> Бэлгийн болон нөхөн үржихүйн баримтын хуудас-2018, ЭМЯ, НҮБ-ын Хүн Амын Сан

МУТХҮБ 2030-д бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхтэй холбоотой зорилт, шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ талаас нь харсан тоон үзүүлэлтээр хэмжихээр тусгасан нь хангалтгүй.

Зөвлөмж:

- ТХЗ 5-ыг бие даасан зорилт болгон МУТХҮБ 2030-д тусгах,
- Бэлгийн болон НҮЭМ-ийн үйлчилгээний хүртээмж, хүлээн зөвшөөрөгдөх байдал болон чанартай холбоотой хүсэлт, гомдлыг барагдуулах механизмыг тухайн үйлчилгээг хүртэгч иргэдийн төлөөлөл, оролцоотойгоор бий болгох зорилтыг мөн тусгах;
- Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг үнэ төлбөргүй авсан зорилтот бүлгийн тоог ТХЗ 3.8-ын шалгуур үзүүлэлтийн нэг болгож тусгах;
- ХДХВ халдвартай хүмүүсийг ЖСАХ-ийг үнэ төлбөргүй авах бүлэгт нэмж оруулах;
- Уурхайн орчмын хүн ам, уурхайн ажиллагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндэд үнэлгээ хийж хамгаалах бодлого, эрх зүйн орчин бүрдүүлж хэрэгжүүлэх.

**Монгол Хүүхдүүд: "ТХЗ-2030"  
Анхдугаар хэлэлцүүлэгт  
оролцогчид:**

Сургууль бүр дээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог тогтмол явуулах,  
Сургуулийн орчныг эко болгох Улаанбаатар хотын хэмжээнд дугуйн замыг байгуулах  
Сургууль, цэцэрлэгийн үдийн цайны чанарыг сайжруулах,  
Эрүүл мэндийн хичээлийг хүүхдийн өөрийн онцлогт тохируулж заах,  
Машингүй өдрийг долоо хоногт нэг удаа зохион байгуулах,  
Хүүхдүүдэд сургууль дээр дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшүүлэх,  
Хүүхдүүдэд эрүүл мэндийн хичээлийг танхимын бус аргаар тогтмол явуулах,  
Зөв хооллолтын сургалт хийдэг байх.

**ТХЗ-6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах**

**ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ**

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол Улсын нийт хүн амын 72.6 хувь буюу 1922.2 мянган хүн баталгаат ундны усаар хангагдаж байна.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХҮБ 2030-ын 2.3.1: Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх зорилт дэвшүүлсэн байна.

Хүн ам, орон сууцны тооллогын тухай хууль, Усны тухай хууль, 2012

Ус бохирдуулсан төлбөрийн тухай хууль, 2012 батлагдсан боловч хэрэглээгүй байсаар нэмэлт өөрчлөлт орох гэж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хөгжлийн бодлогыг боловсруулахдаа олон талын оролцоог хангаж байж шийдвэр гаргах ёстой гэсэн ҮХГ-ын баримтлалыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- Ус сэргээгдэхгүй, нөхөгдөшгүй байгалийн нөөц гэдгийг бүх түвшинд ойлгох нь ундны усаа хамгаалах арга хэмжээний эхлэл байх ёстой.

ТХЗ-7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Дэлхий нийтээрээ сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахыг зорьж буй өнөө үед дэлхийн нийт анхдагч эрчим хүчний нийлүүлэлтийн 14 орчим хувийг сэргээгдэх эрчим хүч бүрдүүлж байгаа бол манай улсад энэ үзүүлэлт 4 орчим хувьтай байна<sup>19</sup>.

Дэлхийн түвшинд 2016 оны байдлаар нүүрсийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд эх үүсвэр болгон ашиглаж буй хувь 38.4, харин Ази тивд 54.3 хувь байна. Манай улсад харин 92.7 буюу хэт өндөр хувьтай байна.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХҮБ 2030-2.1.5.2 Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана. 2030 он гэхэд Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглаж эхлэх зорилт дэвшүүлсэн.

МУ-ын Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахаар дэвшүүлсэн Үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН) зорилгын хэрэгжилтийг МУ-ын Засгийн газрын 325-р Тогтоолоор 2018 оны 10-р сарын 24-нд батлагдсан *Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр*<sup>20</sup> (ЭХДХХ)-тэй харьцуулан шинжвэл дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх магадлал алга байна.

Салбарын хамгийн шинэ бодлогын баримт бичиг болох ЭХДХХ-ийг МУТХҮБ, ДТХЗ, Парисын болон бусад уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг тогтоох амлалтуудад чиглэсэн бодлогын уялдаа, санхүүгийн болон бусад нөөцийг хангасан эсэхийг шинжилж үзлээ.


Зураг 6: МУ-ын ҮЗХН-ийн өөрчлөлтгүй үргэлжлэх (BAU-business as usual) хувилбар ба бууруулах төлөвлөлтийн харьцуулалт. Эх сурвалж: Монголын ҮЗХН 2015

Ямар ч Өөрчлөлтгүй үргэлжлүүлэх хувилбар (Зураг 6: BAU) үндэсний хүлэмжийн хийн өсөлтийг 2010 оны байдлаас 2030 гэхэд 2.5 дахин буюу 21 to 51 Mt CO<sub>2</sub> eq хүрэх юм. МУ өөрчлөлтгүй үргэлжлүүлэх хувилбараас бууруулах хувилбарыг сонгохдоо хүлэмжийн хийн ялгарлыг 14-хөн хувиар бууруулах амлалт авсан бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэл 10%-ийг нь буюу 3\2-ыг бууруулахаар тооцсон. ҮЗХН-т жагсаасан бууруулах арга хэмжээний нийлбэр үр дүн нь жилд 7.3 Mt CO<sub>2</sub>-eq бууруулах (BAU-тай харьцуулбал) бөгөөд нэг үгээр хэлбэл МУ хүлэмжийн хийн ялгарал нь 150% өсөх байсан бол 120%-иар бууруулж өсгөх амлалт авсан юм. Мөн “ямар ч нөхцөлд хэрэгжүүлэх”, “тодорхой нөхцөлтэй хэрэгжүүлэх” гэсэн орнуудтай харьцуулбал энэ амлалт нь бас “бүрэн нөхцөлтэй” буюу зөвхөн олон улсын ба

<sup>19</sup> МУ-ын Эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ, 2019, ҮСХ


<sup>20</sup> МУ-ын Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр, 2018-2023





гадаад хөрөнгө оруулалт олгогдсон тохиолдолд хэрэгжүүлж буруулна гэсэн нөхцөлтэй.

Зураг 7. Хийн ялгарлын өөрчлөлтгүй үргэлжлүүлэх хувилбар. НҮБ-ын УАӨСК-д хүргүүлсэн Үндэсний 3-р илтгэлээс



2017 онд НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенци (UNFCCC)-д хүргүүлсэн Үндэсний 3-р илтгэлтэй харьцуулбал Дунд хугацааны хөтөлбөрт дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Салхины эрчим хүчний үүсгүүр суурилуулах төлөвлөгөөг 300 MW-аас 100 MW болгож бууруулсан,
- Нарны эрчим хүний үүсгүүр суурилах төлөвлөгөөг 100 MW-аас 60 MW болгож бууруулсан,
- Нүүрсний эх үүсвэрээс үйлдвэрлэх эрчим хүчний өсөлтийг 150% буюу 2760 MW –аар өсгөх BAU- Өөрчлөлтгүй үргэлжлүүлэх хувилбарын төлөвлөлтөөс 800% буюу 9000 MW (9GW) хүргэхээр өөрчилсөн байна. Дунд хугацааны хөтөлбөрийн Хүснэгт 1<sup>21</sup>-ийг үзнэ үү.

Хэрэв ЭХДХХ-ийг төлөвлөсөн ёсоор хэрэгжүүлбэл ҮЗХН-д дараах байдлаар нөлөөлнө:

1) 2030 он гэхэд эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын 30%-ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр эзлэх амлалт биелэхгүй (төлөвлөлт хамгийн бүтэмжтэй хөгжсөн байх хувилбараар авч үзвэл 400 MW СЭ, түүн дээр 400 MW усан цахилгаан станц (Дэлхийн өвийн сан ба Рамсарын конвенциор хамгаалагдсан газруудад сөргөөр нөлөөлөх нэлээд эрсдэлтэй УЦС) баригдлаа гэхэд нүүрсээр галлах ДЦС-ийн хүчин чадал нь 9000 MW хүрч өссөн байх юм.

<sup>21</sup><https://www.legalinfo.mn/annex/details/8750?lawid=13738>

2) Хүлэмжийн хийн ялгарлыг амласан дагуу 14%-иар бууруулахын оронд өөрчлөлтгүй үргэлжлүүлэх хувилбарын ялгарлыг 60 сая тонн CO<sub>2</sub> eq нэмэгдүүлэх буюу одоогийн түвшинийг 2 дахин нэмэгдүүлэх эсвэл 2010 оны түвшинээр тооцвол 5 дахин нэмэгдүүлэх тооцоо гарч байна.

Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөрийн хавсралт Хүснэгтээс харвал нүүрсний эх үүсвэр бүхий төслүүдэд хөрөнгө санхүүгийн тооцоо, төсөв хийгдсэн байх боловч сэргээгдэх эрчим хүч, нарны дээвэр мэт төслүүдэд төсөв тавигдаагүй байгаа нь ТХЗ-д хүрэх магадлал бага байгааг харуулж байна.

Мөн Улаанбаатар хотын 2,3 ба 4-р ДЦС-ын хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх, Багануурт шинээр 700 MW хүчин чадал суурилуулах буюу өнөөгийн нийт улсын хэмжээнд үйлдвэрлэж буй 1200 MW-д хүргэх төлөвлөгөө нь өнөөдөр гамшигийн түвшинд хүрсэн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх магадлалтай байна.

Орчин үед дэлхий нийтээр нүүрснээс ангижрах бодлого баримталж буй цагт урт хугацаанд нүүрсний технологиуд хэрэглэгдсээр байх дэд бүтцийг суурилуулж байгаа нь тогтворгүй, хүн ам, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хамгаалах үндэсний ТХЗ-ын зорилтуудтай уялдаагүй бодлого хэрэгжүүлж байна.

Тогтворгүй энэ бодлогын нөгөө талд одоо авах зээлийн тооцоо 4 тэрбум орчим ам. доллароор төсөвлөгдсөн байгаа нь өрийн дарамтаас салах бодлогод нийцэхгүй байна.

#### САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр нь МУТХҮБ 2030-д сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр нэмэгдүүлэх зорилтод нийцэж байгаа эсэхэд ИНБ-ын оролцоотой үнэлгээ хийх, нийцүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенциудын дагуу авсан ҮЗХН амлалтад хэрхэн нөлөөлөх үнэлгээ, тооцоог ИНБ-дын оролцоотой хийх, нийцүүлэх;
- Хүн амын эрүүл мэнд, орчны ба агаарын бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэх ТХЗ-дад нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, ИНБ-тай зөвлөлдөх, нийцүүлэх;
- Эдийн засгийн тогтвортой хөгжил, өр зээлийн бодлогод хамаарах ТХЗ-дад нийцэж байгааг тогтоох тооцоо, үнэлгээ хийх, ИНБ-тай зөвлөлдөх, нийцүүлэх;

## ТХЗ 8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих

### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Ажиллах хүчний 2018 оны судалгааны<sup>22</sup> дүнгээр улсын хэмжээнд нийт 1253.0 мянган хүн хөдөлмөр эрхэлсний 669.6 (53.4%) мянга нь эрэгтэйчүүд, 583.4 (46.6%) мянга нь эмэгтэйчүүд байна.

*ТХЗ-8.3. Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацийг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих*

Орон нутагт зохистой ажлын байр бий болсон эсэхийг тодорхойлохоор ХЭХТ, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ хамтран Дорнод, Хэнтий аймгууд, Дорнод аймгийн Баяндун суманд ажилласан. Зохистой ажлын байр бий болохгүй байна. Учир нь:

- ТХЗ-н талаарх мэдлэг, мэдээлэл муутай,
- ЖДҮХС-аас ямарч санхүүжилтгүй,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хэмжээ буурсан,
- Ажлын байр нэмэгдүүлэх төсөв буурсан,
- Тендерийг богино хугацаанд зарлаж орон нутгийн иргэд оролцох боломжийг хязгаарладаг,
- Түр мэргэжил эзэмшигчдийг мэргэшүүлэх, хөгжүүлэх дэмжлэг байхгүй,
- Ажлын байранд сургах механизм байхгүй,
- Бичиг үсгийн мэдлэггүй залуус нэмэгдсэн,
- Санхүүгийн боловсролгүй байх нь нийтлэг байна гэж дүгнэжээ.

*ТХЗ-8.5 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэйчүүд залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтэд хамруулах, зохистой ажлын байраар хангах, адил үнэлэхүйтэй ажилд адил цалин хөлс олгох*

Нийт хүн амын 50.8%-ийг эзэлж буй эмэгтэйчүүд хөдөлмөрийн насны хүн амын дотор эрчүүдээс өндөр хувийг эзэлж байгаа ч ажил эрхлэлтийн түвшин доогуур байгааг Ажиллах хүчний 2018 оны судалгааны<sup>23</sup> дүнгээр Хүснэгт-3-т харуулав.

<sup>22</sup> Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, 2018, ҮСХ


<sup>23</sup> Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, 2018, ҮСХ

**Хүснэгт-3. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр**

Тухайн үеийн байдал	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
15, түүнээс дээш насны хүн ам	2 226 596	100.0	1 051 276	47.2	1 175 320	52.8
Ажиллах хүчний оролцооны түвшин		61.0		69.5		53.4
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин		56.3		63.7		49.6
Ажилгүйдлийн түвшин		7.8		8.3		7.1


Ажиллах хүчний 2018 оны судалгаагаар 15, түүнээс дээш насны нийт хүн амын 39.0% нь эдийн засгийн идэвхгүй хүн амын бүлэгт багтаж байгаагийн 63% нь эмэгтэйчүүд байна.

**Зураг 8. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, голлох шалтгаанаар, 2010-2018**



Судалгааны дүнгээс харахад охид, эмэгтэйчүүд эдийн засаг, байгалийн баялагаас тэгш хүртэж чадахгүй, бага орлоготой салбарт ажиллаж, бага цалин хөлстэй байхын зэрэгцээ тэд нарыг хөдөлмөрийн өрсөлдөхүйц салбарт бэлтгэх, бизнес эрхлэхэд тэдний онцлогт тохирсон дэмжих бодлого үгүйлэгдэж байна.

Хамгийн өндөр болон хамгийн бага цалин хөлстэй тус бүр 5 салбар дахь ажилчдын эзлэх хувийг хүйсээр харуулбал:



Ажиллах хүчний судалгааны 2013-2015 оны мэдээлэлд үндэслэн ҮСХ-ноос хийсэн эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын цалингийн тэгш бус байдлын шинжилгээний дүнгийн ерөнхий хандлагыг харахад ижил боловсролтой боловч цалингийн түвшин хүйсийн хувьд ялгаатай, эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын цалингийн зөрүү 17.3 хувь байна гэжээ. Ажиллагчдын хүйсийн байдал нь тэдний боловсрол, ур чадварын түвшинтэй энэ тэнцэхүйц цалингийн ялгаанд нөлөөлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүйсээр болон насаар ялгаварлан гадуурхах явдал өндөр байдаг бөгөөд хөдөлмөрийн зах зээл дээр шинээр зарлагдаж байгаа хоёр ажлын байр тутмын нэг нь насаар, гурван ажлын байр тутмын нэг нь хүйсээр ялгаварлаж байна. **Хөдөлмөрлөх эрхийн зөрчил буюу ижил үнэлгээтэй ажилд ижил цалин хөлсгүй ажилласан ажилтан 34.2%, удирдлагын зүгээс ажлын байран дээр дарамтад өртөж байсан тохиолдол 79% байна. Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтад өртөх үзэгдэл нэмэгдэж байгаа бөгөөд гурван эмэгтэй тутмын 1 нь АББД-д өртөж, нийт хохирогчдын 98% эмэгтэйчүүд, 2% нь эрэгтэйчүүд эзлэж байна.**

Ажил эрхэлж буй олон эмэгтэйчүүд баталгаагүй ажлын нөхцөлд гацдаг, ажлын байрны тогтвортой бус байдал, цалин хөлс нь баталгаатай бус, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэрийн тогтолцоонд хамрагдаж чаддаггүй.

Нийгмийн халамжийн тогтолцооны нэг дутагдалтай тал нь ядуу болон ядууралд ойрхон байгаа, мөн нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдах шалгууруудын аль аль ангилалд багтахгүй байгаа хүмүүст нийгмийн баталгаа болох дэмжлэг үзүүлэхгүй байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд 2016 онд 56.7, 2017 онд 50.6, 2018 онд 65 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байдаг бөгөөд энэ хугацаанд тус сан нийт 1178 төслийн санал авч 480 төсөл шалгаруулснаас, 136 төсөлд 3%-ийн хүүтэй зээл олгосны 122-ыг УИХ-ын гишүүд болон төрийн өндөр алан тушаалтан тэдгээрийн хамаарал бүхий аж ахуйн нэгж авсан байна. Хувиараа болон аж ахуйн журмаар бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүд ЖДҮС-аас 5-аас 200 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл хүссэн боловч “санхүүжилт байхгүй” шалтгаанаар авч чадаагүй байгаа юм.

Ажиллах хүчний 2018 оны судалгаагаар, ажил эрхлээгүй хүн амын 56.1 хувь нь 15-34 насныхан, 19.5 хувь нь ажиллах хүчинд шинээр элсэн орсон 20-24 насныхан байна. Ажилгүй иргэдийн 25.3 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна. Иймээс залуучууд хөдөлмөр эрхлэхгүй байгаад анхаарал хандуулах, холбогдох арга хэмжээ авах, МСҮТ-ийн суралцагчдын хөгжлийн асуудлыг хамт авч үзэх хэрэгтэй байгааг өнөөгийн бодит байдал харуулж байна. Түүнчилэн, ААНБ, компанийн нийгмийн хариуцлагыг үнэлэхдээ ажлын байран дахь сургалт, ажилчдаа хөгжүүлсэн байдал, МСҮТ-д суралцаж буй суралцагчдаас ирээдүйн мэргэшсэн ажилтнаа сонгон дэмжиж бэлтгэсэн зэрэг шалгуур тавьж болох юм.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

ТХЗ-8.5 нь МУТХҮБ 2030-ын Нийгмийн тогтвортой хөгжил хэсгийн 2.2.2-т агуулгын хувьд туссан байна. МУТХҮБ 2030-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эдийн засгийн идэвхтэй байдлыг 2030 он гэхэд 70 хувьд, ажилгүйдлийн түвшинг 3 хувьд хүргэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг 300 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэх” зорилт тавьжээ.

Гэхдээ МУТХҮБ-2030-д нийгмийн ялгаатай бүлгүүд тус бүрийн онцлогт тохирсон бодлого тодорхойгүй, зохистой хөдөлмөр эрхлэлтийн гол багана болсон хөдөлмөрлөх эрхийн зөрчил, хөдөлмөрийн таатай орчны тухай тусгаагүй байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогод хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, хөдөлмөрийн чадварт нь тохирох техник, тоног төхөөрөмж бүхий ажлын байрыг эрх зүйн зохицуулалтаар дэмжинэ гэж дурьдсан хэдий ч хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн таатай орчин буюу зохистой ажлын байрны асуудлыг орхигдуулсан байна.

МУТХҮБ-2030-н үе шат бүрд хүрсэн байх эдийн засгийн идэвхи, ажилгүйдлийн түвшинг тодорхойлсон байхад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гарсан 6 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлсэн, ажилгүйдэл буурсан үзүүлэлтийг тусгаагүй байгаа нь бодлогын хэрэгжилтийг хэмжихэд тодорхойгүй байдал бий болгохоор байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хөтөлбөр байгаа ч “хүүхдээ харсан, гэр бүлийн хэн нэгнийг асарсан” шалтгаанаар ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эмэгтэйчүүдийн тоо жил бүр нэмэгдсээр байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд шууд нөлөөлөх цэцэрлэг яслийн хүрэлцээ, хүртээмж, хүүхэд харах үйлчилгээ, зайнаас ажиллах боломж, ажлын уян хатан цагийн хэрэгцээг тооцон зохицуулах шаардлага байна.

Бодлого, хөтөлбөртөө зохистой хөдөлмөр эрхлэлтийн үндсэн шалгуурын нэг болох хөдөлмөрлөх эрх, тэгш үнэлүүлэх эрхийн хэрэгжилтийг огт дурьдаагүй, шалгуур үзүүлэлтэд эдгээр асуудал тусгагдаагүй байгаа нь цаашид охид, эмэгтэйчүүд ажлын байрны бэлгийн дарамт, нас хүйс, үзэл бодлоор ялгаварлагдах, жирэмсэн эсэхээр ялгаварлагдах нөхцөл хэвээр үргэлжлэхээр байна.

Улсын төсвөөс ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгоход шууд санхүүжилтийн дэмжлэг олгосон ч эдгээр нь зорилтот бүлэгтээ хүрэхгүй байна.

ЖДҮ эрхлэгчдийг дэмжих сангийн санхүүжилт нь эзэндээ зөв хүртээмжтэй хүрэхгүй байгаа нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж ажлын байр бий болгох алхамд их саад болж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтыг хэмжихэд:

- Ижил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох хуулийг хэрэгжүүлэх,
- Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг МУТХҮБ болон бусад салбарын бодлого, хөтөлбөрүүдэд шингээх,
- Охид, эмэгтэйчүүдийн хөдөлмөр, бизнес эрхлэлтийг дэмжихдээ тэдний дуу хоолойг сонсох, шийдвэр гаргахад эрх тэгш оролцуулах, дүрэм журам боловсруулахдаа тэдний хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, онцлог байдалд тохируулах,
- Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний ажил хөдөлмөрийн үнэ цэнийг бий болгох бодлогыг МУТХҮБ-2030-д суулгах, салбарын бодлогуудад хөдөлмөрлөх эрхийн хангалт, түүнийг хэмжиж болохуйц “эрхийн зөрчил, гомдлын бүртгэлийг хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт болгон оруулах,
- Үндэсний бодлого, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг салбарын бодлого, хөтөлбөр, нэгж салбарын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрт шингээж, хэрэгжилтийг дүгнэх,
- Хөдөлмөрчний эрх ашгийг хамгаалах, хангах үүднээс нэгдээгүй, батлаагүй байгаа Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенциудад нэгдэн хэрэгжүүлэх.

ТХЗ-9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх

ТХЗ-10. Тэгш бус байдлыг бууруулах

## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Тэгш бус байдлыг бууруулах нь манай улсын хувьд тулгамдсан асуудал. ТХЗ-10-ын дөрвөн зорилт нь улс орны дотоод дахь тэгш бус байдлыг эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд бууруулж, хөгжил, цэцэглэл, оролцоо, нийгмийн хамгааллын үр шимийг хүн бүрт тэгш хүргэх “хэнийг ч орхилгүй хөгжих” гэсэн ТХЗ-ын гол үзэл санааг хэрэгжүүлэхэд чиглэсэн. Иймээс ТХЗ-10-ын зорилт бүрийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах нь ихээхэн ач холбогдолтой. ТХЗ-10-ын 1-р зорилт: “хүн амын хамгийн<sup>24</sup> бага орлоготой 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дундажаас дээгүүр хэмжээнд хүргэн барих” гэсэн зорилтоор хамгийн бага орлоготой хэсгийн орлогыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд чиглэсэн. Мөн ядуурал нь нийгмийн тогтолцоо, системийн асуудал болохыг хүлээн зөвшөөрч түүнийг засахын тулд 10-2-р зорилт: “нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриас үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангах”; 10-3-р зорилт: “ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халах, ийм чиглэлийн

<sup>24</sup> “Хамгийн” гэсэн үгийг орхиж орчуулсан байсныг нэмж оруулав. Энэ үгийг орхиж болохгүй. Учир нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнг бууруулна.

хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг дэмжих”; 10.4-р зорилт: төсөв санхүү, цалин, нийгмийн хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах”; “2030 он гэхэд шилжин суурьшигчдын хийдэг мөнгөн гуйвуулгын гүйлгээний төлбөрийг 3 хувиас бага түвшинд хүртэл бууруулж, 5 хувиас дээш төлбөртэй мөнгө гуйвуулах үйлчилгээг зогсоох” зэрэг улс орны дотоод дахь тэгш бус байдлыг арилгахад бодитой үр дүн гаргах маш тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХҮБ-2030-д ТХЗ 10-ын зөвхөн 1-р зорилтыг “...орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувийг дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтаах” гэсэн томъёоллоор хязгаарласан ба ялгаварлан гадуурхалтыг арилгах, төсөв санхүү, цалин, нийгмийн хамгааллын бодлого хэрэгжүүлэх, мөнгөн гуйвуулгын төлбөрийг бууруулах зэрэг зорилтыг тусгаагүй болно. Иймээс ТХЗ-10-ын хэрэгжилт хангагдахгүй байхаар зогсохгүй, түүнд шууд болон шууд бусаар нөлөөлж болох тогтвортой хөгжлийн бусад 16 зорилгын 60 зорилтын хэрэгжилтийг сааруулж ТХЗ-ын хэрэгжилтэд бүхэлд нь саад учруулах эрсдэлтэй.

Түүнчлэн Монгол Улсын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх Арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын 2018-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн суурь баримт бичиг болох Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэгт ТХЗ 10 огт тусгагдаагүй болохыг хүснэгтээс харж болно.

Нэгэнт “хамгийн” гэдэг үгийг орхиж “бага орлоготой хүн амын 40 хувийн орлогын өсөлтийг” хангах гэж орчуулсан болохоор МУТХҮБ-д “орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтаах” зорилго тавьсан. Цаашилбал ЗГ-ын 2016-2020 оны ҮАХ-ийн 3.3.2-т “Өрхийн орлого, зарлага, ядуурлын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулж, бодит амьдралд нийцүүлнэ”. ЗГ-ын ҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ-ний 3.3.2-т: “Ядуурлын үндсэн үзүүлэлтийг тооцох болон өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх, судалгааг 2018-2020 онд хийнэ. Үүнд 14.4 тэрбум төгрөг зарцуулахаар тусгажээ. Гурван тулгуурт хөгжлийн бодлогод зөвхөн “ядуу өрх, иргэдэд хүрсэн бодлого хэрэгжүүлэх” гэж туссан болно.

*ТХЗ-10, түүний зорилтууд МУТХҮБ-2030, ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх Арга хэмжээний төлөвлөгөө, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан байдал:*

ДТХЗ-10	МУТХҮБ-ын холбогдох заалт	ЗГ-ын 2016-2020 оны ҮАХ	ЗГ-ын ҮАХ-ийг хэрэгжүүлэх АХТ	Гурван тулгуурт хөгжлийн бодлого
10.1 2030 он гэхэд “хамгийн” <sup>25</sup> бага	4. Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт	3.3.2 Өрхийн орлого, зарлага, ядуурлын	3.3.2 Ядуурлын үндсэн үзүүлэлтийг тооцох болон өрхийн	Ядуу өрх, иргэдэд хүрсэн

<sup>25</sup> “Хамгийн” гэдэг үгийг хаяж орчуулсан байна.



орлоготой хүн амын 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр дүвшинд хүргэж хадгалах	хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.	түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулж, бодит амьдралд нийцүүлнэ.	амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх, судалгаа хийх. /2018-2020/ 14.4 тэрбум төг.	бодлого хэрэгжүүлэх
---	--	---	--	---------------------

“Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна. Орлогын тэгш бус байдлын үзүүлэлтийг 2014 оны ядуурлын суурь түвшинг 36.5-аас 30.0 болтол бууруулах” гэж МУТХҮБ-2030-ын 2.2 Нийгмийн тогтвортой хөгжлийн 2.2.1. Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал хэсгийн Ядуурлын бүх төрлийг эцэс болгох Зорилт-1-д тусгалаа олсон. Энэ зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эхлэл мэдрэгдэхгүй байна. Ядаж л “дундаж давхарга” гэж хэнийг хэлээд байгаа тодорхойлолт байхгүй тул хаана яваагаа хэлж чадахгүй байна гэж харж байна.

**САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

- Тэгш бус байдлыг бууруулах нь манай улсын хувьд тулгамдсан асуудал болоод байна,
- Санхүүгийн ялгаварлалт их, зээл хүртээмжгүй, цалин бага байна,
- Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн үр дүн харагдахгүй, зохих эзэндээ хүрэхгүй байна.
- Тэгш бус байдлыг бууруулах орлого нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхалтыг арилгах, оновчтой арга хэмжээг тодорхойлсон бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**ТХЗ-11. Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих**

**ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ**

Нийслэл Улаанбаатар хотод Монгол улсын нийт хүн амын 46 хувь<sup>26</sup> нь оршин суудаг бөгөөд хот нь голын хөндийд оршдог, өвлийн улиралд хүчтэй температурын инверс тогтдог, халаалтын улмаас агаарт хаягдах хаягдлын хэмжээ эрс нэмэгддэг учраас агаарын бохирдол маш ихтэй хүн ам оршин суухад найдваргүй хот болоод байна. Улаанбаатар хот нь Монгол улсын газар нутгийн дөнгөж 0.3% буюу 4704.4 км.кв талбайг эзэлдэг бөгөөд нийт тээврийн хэрэгслийн 60.9 хувь нь нийслэлд бүртгэлтэй байна.<sup>27</sup>

**ТХЗ-11.2.1 Нийтийн тээврээр ая, тухтай зорчдог хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр**

<sup>26</sup><http://www.1212.mn/>

<sup>27</sup><http://1212.mn/> Үндэсний Статистикийн Хороо

Нийтийн зорчигч тээврийн хэрэгслээс зөвхөн автобус, тролэйбусаар зорчигчийн картын төрлийг үндэслэн зорчигчдын<sup>28</sup> бүтцийг тодорхойлж байгаа хэдий ч хүйс, насны бүлгээр задлах боломжгүй бөгөөд хэр ая тухтай зорчиж байгааг илэрхийлэх мэдээлэл байхгүй байна.

Хүснэгт-4. Нийтийн зорчигч тээврийн тролэйбус, автобусаар зорчигчид, хувиар, 2018

Зорчигчдын бүтэц	Нийт зорчигчдод эзлэх хувь
Энгийн том хүн	50.8
Ахмад настан	19.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	7.3
Оюутан	7.1
Хүүхэд	15.0

2030 он гэхэд эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх зорилт биелэх нөхцөл хараахан бүрдээгүй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих ээлтэй дэд бүтэц бий болоогүй байна.

*ТХЗ-11.3.2 Хот төлөвлөлтөд иргэний нийгмийн шууд оролцоог бүрдүүлсэн, тогтмол, ардчилсан байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг удирдлага, төлөвлөлттэй хотуудын эзлэх хувь*

Хот, хөдөөгийн хөгжил, хүн амын амьжиргааны түвшний ялгаатай байдал, байгалийн гамшиг, ган, зуд болон томоохон уул уурхайн төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан хөдөө орон нутгаас хот суурин газарт суурьших иргэдийн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэн. Иргэний газар эзэмших болон өмчлөх эрх зүйн баталгааг олгох, орон байрны хүртээмж аюулгүй байдлыг хангах, боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг хот төлөвлөлтийн наад захын шаардлагууд хэрэгжихгүй байна.

Цэцэрлэг, сургуульгүй хотхон баригдаж, орон сууцны хороолол дунд замын түгжрэл үүсэж, хог, цэвэр ба бохир усны асуудал нь бүрэн шийдэгдээгүй зэрэг том хотын менежментийн асуудал ихээр хөндөгдөж байна. Дахин төлөвлөлт хийхдээ олон нийтийн оролцоог бүрдүүлэх, хуулийн дагуу ажиллах, шударга үйл ажиллагаа явуулах, нөхөн олговрыг бүрэн олгох зэрэг хүний эрхийн олон улсын эрх зүй, хэм хэмжээг мөрдөхгүй байна.

*ТХЗ-11.5.1 100,000 хүнд ногдох гамшигийн улмаас амь насаа алдсан, сураггүй алга болсон болон гамшигт шууд нэрвэгдсэн хүний тоо*

<sup>28</sup><http://transport.ub.gov.mn> Нийслэлийн Тээврийн Газар

2018 оны 10 дугаар сард Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн явцын хяналтын эхний тайланг 2015, 2016, 2017 оны мэдээллээр НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас боловсруулсан цахим аргачлалын дагуу гаргасан мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

100,000 хүнд ногдох гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй алга болсон, шууд нэрвэгдсэн хүний тоо		
2015 он	2016 он	2017 он
1106.4	2811.5	274.3

*ТХЗ-11.6.1 Хот суурин газарт тогтмол цуглуулдаг хатуу хог хаягдал, түүнээс хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдын эзлэх хувь, хотоор*

Хог хаягдлын 40 хувийг дахин боловсруулах боломжтой цаас, хуванцар сав, хөнгөн цагаан лааз, шил эзэлдэг байна. 2017 онд гэхэд 26 тонн хогийг дахин ашиглаж хоёрдогч түүхий эд болгон экспортод гаргажээ.

*ТХЗ-11.6.2 Хотын агаар дахь нарийн болон том ширхэглэгт тоосонцрын (өөрөөр хэлбэл, РМ 2.5 болон РМ 10) жилийн дундаж хэмжээ (хүн амд харьцуулсан)*

Улаанбаатар хотын гадаад орчны агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцор нь зүрх-уушигны хавсарсан өвчний шалтгаант нас баралтад 28.8%, уушигны хавдарт 39.9%-иар, нийслэлийн хүн амын нийт нас баралтад 9.2%-иар нөлөөлж байгааг судалгаагаар тогтоосон байна<sup>29</sup>.

Агаарын бохирдол аюултай түвшинд хүрч нийслэл хотын хүн ам Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын стандартад заасан жилийн дундаж нарийн ширхэглэгт тоосонцрын (PM2.5) хүлцэх хэмжээнээс 25 дахин их бохирдолд өртөж байна. Энэ нь зөвхөн нийслэлээр хязгаарлагдахгүй зарим аймгийн төвд ч агаарын бохирдол сэтгэл түгшээх түвшинд хүрээд байна.

Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцрын агууламж 2011 онд жилийн 365 хоногийн 63.3-66.3 хувь буюу дунджаар 237 өдөр хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс давж байсан нь 2018 онд 92.2-93.0 хувь буюу 338 өдөр болж тасралтгүй өссөн байна. Хотын хүн амын хувьд нарийн ширхэгт тоосонцрын хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан агаараар амьсгалах өдрүүд нэмэгдсээр байна<sup>30</sup>.

*ТХЗ-11.7.2 Сүүлийн 12 сард бие махбодын хохирол амссан, бэлгийн дарамтад орсон хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хэрэг гарсан байршлаар*

Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар 2015-2016 онд улсын хэмжээнд 298 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Энэ нь зөвхөн хууль хяналтын байгууллагад бүртгэгдэж шалгагдсан бэлгийн хүчирхийллийн гэмт

<sup>29</sup> Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний суурь судалгаа, 2018 <http://mnts.ub.gov.mn/p/wp-content/uploads/master-plan-2018.06.21-1-boti-tolowlogoonii-suuri.pdf>

<sup>30</sup> Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд, 2018, ҮСХ

хэргийн тоо бөгөөд үүнээс гадна хичнээн хүүхэд бие сэтгэлээрээ хохирч байгааг тоолж, тодорхойлсон судалгаа өнөөдөр байхгүй байна. Харамсалтай нь эдгээр хүүхдийн 48 хувь нь гэр бүл, ураг төрлийнхөө хүний хүчирхийлэлд өртөн бүх насаараа бие махбод, сэтгэл санааны гүн шархтай үлдэж байна.

*ТХЗ-11.б.1 Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны суурь баримт бичигтэй уялдуулсан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг баталж, хэрэгжүүлдэг эсэх*

Гамшгаас хамгаалах талаар Төрөөс баримтлах бодлого, 2011, Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, 2011, Гамшгаас хамгаалах тухай МУ-ын хууль, 2017 зэрэг үндэсний бодлогын баримт бичгүүд үйлчилж байна. Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2015-2020 батлан хэрэгжүүлж байна.

Гамшгийн эрсдлийг бууруулах тайлан мэдээг Сендайн үйл ажиллагааны бичиг баримтын дагуу тайлагнаж байх болсон<sup>31</sup>.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

*МУТХУБ-2030*–н Зорилт 2.1.5.5 нь ТХЗ-11.3.2-ыг бүрэн тусгасан, Зорилт 2.3.3.2 нь ТХЗ-11.6-тай нийцсэн гэж үзэхээр байгаа боловч I үе шат (2016-2020): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох гэсэн зорилтын хэрэгжилтийн түвшин 2019 оны байдлаар хангалттай түвшинд хүрч хэрэгжих боломжгүй байгаа нь аливаа бодлого, хөтөлбөр амьдралд хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

*МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Барилга, хот байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.89-д Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ* гэж заасан боловч ТХЗ-11.3.2-д заасан **иргэдийн оролцоотой шийдвэрлэх** талаар оруулж өгөөгүй нь төсөл хөтөлбөрийн хоорондын уялдаагүй байдлыг харуулж байна. ТХЗ-11.7.2, ТХЗ-11.6.1, ТХЗ-11.б-н хэрэгжүүлэх үндэслэл болох зорилтууд хөтөлбөрт тодорхойлогдсон байгаа боловч бодит үр дүн хараахан гараагүй байна.

*УИХ-аас 2017 оны 3 дугаар сард батлан гаргасан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”*-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд Засгийн газар онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрт:

- Гэр хороололд амины орон сууц барихад чиглэсэн дэд бүтэц байгуулж, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх,
- Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн инженерийн хангамжид холбох, дэд төвүүдийг байгуулах,

<sup>31</sup> Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны 05 сарын 28-ны өдрийн А/184 тушаал

- Улаанбаатар хотод ажиллаж байгаа халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчийг төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжид үе шаттайгаар холбох зэрэг томоохон зорилт тусгагдсан.

*“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”* баримт бичигт тусгагдсан гэр хорооллын дахин төлөвлөлтийн эхний ээлжийн арга хэмжээ нь ТХЗ-11.3, 11.6 дахь зорилтуудын үндсэн үзүүлэлтийн хувь хэмжээг бууруулахад дэмжлэг болсон төсөл хэрэгжих нь гэж үзэж байна.

Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн гэх дээрх хөтөлбөрүүд нь нөгөөтэйгүүр, хотын барилгажилт, орон сууц түлхүү барих замаар дулаан ба цахилгаанаар хангах эх үүсвэрийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх, улмаар агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх, хүн амын 64 хувийг 2040 он гэхэд Улаанбаатарт төвлөрөхөд шаардагдах орон сууц бэлтгэх зорилгоор АХБ, Уур амьсгалын ногоон сан, Дэлхийн банк зэргээс их хэмжээний зээл авч зохистой хэмжээнээс хэтэрсэн өрийн дарамт нэмэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаар авсан ҮЗХН-ийн хэрэгжилтийг үгүйсгэсэн сөрөг хандлагууд дагалдаж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төрөөс гаргасан бодлогын баримт бичгийн дийлэнх хэсэг нь зөвхөн бүтээн байгуулалт хийх, материаллаг шинж чанартай байгаа нь хүнээ хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх бодлого нь орхигдоод байна уу гэж үзэхээр байна.

МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1-д Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтална гэж оруулснаас өөрөөр хүний хөгжлийн талаар дорвитой авч хэрэгжүүлэх заалт ховор байгааг дүгнэмээр байна.

Тухайн эдийн засаг нь хөрөнгө оруулах, бизнес эрхлэх, ажлын байр бий болгох, хүн амын тогтвортой аж байдлыг дээшлүүлэх боломжийг нээж л байвал ядуурлаас гарах боломж бүрдэх юм. Ядуурлаас ангижрах гол арга зам бол ажил хөдөлмөр мөн.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:

- ТХЗ-н хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний болгон томъёолж, ойлголт, тодорхойлолтыг нэгтгэх ажлыг эрчимжүүлэх,
- Иргэдийн нийтийн тээврээр ая тухтай, аюулгүй зорчсон гэдгийг тодорхойлох, “ядуусын хороолол” гэсэн томъёоллыг өөрчлөх,
- Хот төлөвлөлтөд иргэний нийгмийн шууд оролцоог хангах, бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах,
- Нийслэлийн иргэний боловсролыг анхаарч хүнээ хөгжүүлэх.

## ТХЗ-12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих

### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Хариуцлагатай, тогтвортой хэрэглээг бий болгох ялангуяа хүнс, шатахуун зэргийн нөөцтэй байх тухай бодлого, төлөвлөгөө гарган нэг хүнд ногдох материалын өгөөж,

ДНБ-д ногдох материалын хэрэглээ, аюултай хог хаягдал, химийн бодисын тухай, байгаль орчны гэрээ, хэлэлцээр хийх, мэдээлэл солилцох зэрэг олон олон арга хэмжээ авч түүний дагуу ЗГ, зээл, бондоос хөрөнгө хүч гарган ажиллаж, тоолж тайлагнаж<sup>32</sup> байна. Гэвч амьдрал дээр ашгийн төлөө хэт улайрсан бизнесүүд хортой хэрэглээ-гаазтай ундаа мэтийг сайн хэмээн сурталчилж төөрөгдүүлдэг, тогтвортой зөв зохистой эко хэрэглээний тухай нийтийн дунд мэдээлэл, мэдлэг ойлголт дутмаг, хууль дүрэм журам хэрэгжихгүй байгаа нь тогтвортой эко хэрэглээ бодитоор бий болж төлөвших өнгө төлөв **одоогоор огт байхгүй** байна.

Тухайлбал мах, шатахуун хэт өндөр үнэтэй, банк санхүүгийн орчин ээлгүй, барилга, дэд бүтэц чанаргүй, хорт утаа болон хог хаягдалд хөрс, ус, агаар, орчин бохирдсон, нэг хүнд ногдох согтууруулах мансууруулах хэрэглээ, үйлчилгээ, зээл байх хэмжээнээс давсан байна.

**Хэрэглэгч** хог, утаанд дарагдаж өөрөө мэдэхгүй зохиомол өрөнд барьцаалагдсан байдалтай байна.

Алт олборлохдоо мөнгөн ус, цианид натри хэрэглэсэн, уран, хар тугалга хүнд металийн үлдэгдэлтэй ундны ус, хэрэглээ газар авсан тухай тайлагнах бүү хэл нэг ч дурьдахгүй, аюултай хог хаягдал тоологдохгүй, хаях тусгай цэг тогтоогоогүй, хэрэглэгчид мэдээлэлгүй мэдэхгүй хордсоор байна. Сүүлийн 2 жилд Хятад улсаас төрийн болон хувийн худалдан авалтаар 9 мянган тонн буюу 16 тэрбум төгрөгийн үнэ бүхий гялгар уут оруулж ирсэн. Гялгар уутны 8 хувийг дахин боловсруулж, 92 хувь нь хөрс, ус, агаарт оршиж, түлшинд хэрэглэгдэж, хот хөдөө аялал жуулчлалын бүс нутаг, орчныг бохирдуулж<sup>33</sup> байна.

Хүнсний зориулалтын бус хуванцар сав нь хүний биед хортой химийн 4000 гаруй бодис агуулахын зэрэгцээ химийн бодисуудыг байнга ялгаруулж хадгалж буй бүтээгдэхүүний чанарт муугаар нөлөөлдгийг эрдэмтэд тогтоочихсон. Хуванцар, нийлэг, гялгар материалын хяналт, шалгалтгүй өргөн хэрэглээ нь ТХЗ-12-н хэрэгжилт маш муу байгааг илэрхийлж байна.

---

<sup>32</sup><https://www.legalinfo.mn/annex/details/7499?lawid=12308>

<sup>33</sup>Хуванцар савны хэрэглээг бууруулахад иргэн, аж ахуйн нэгжийн идэвх санаачилга, шинэ санаа, шилдэг шийдэл чухал байна <http://mofa.gov.mn/exp/article/entry/1440>



Монгол Хүүхдүүд: "Тогтвортой Хөгжлийн Зорилго-2030" Анхдугаар хэлэлцүүлэгт оролцогчдын санаачлага, Дэлхийн зөн ОУБ:

Тулгамдаж буй асуудал	Шийдэл
Цахилгааны зохисгүй хэрэглээ их байна	Даалгавраа хийж байхдаа зурагт үзэхгүй байх
Усны зохисгүй хэрэглээ их байна	Өдөр бүр савалсан ус авахгүй усны сав хэрэглэе
Шаардлагагүй бараа материал худалдан авах нь их байна	Шүдээ угаахдаа аяганд ус хийж хэрэглэе Өрхийн санхүүгийн боловсролыг хүүхэд нэг бүрт хүргэе Бараа бүтээгдэхүүн сонгохдоо хаягдалгүй сонголт хийх, дахин ашиглах боломжоор хэрэгцээгээ хангах

*ТХЗ-12.5 2030 он гэхэд хог хаягдлын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах, дахин ашиглах замаар хаягдлын хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах*

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар хог хаягдлын зориулалтын 371 цэгт 2,3 сая тонн хог хаягдал цугларсан бол, зориулалтын бус газарт 104 мянган тонн хог хаягдал хаягджээ. Орон нутагт нийт 357 зориулалтын хогийн цэг байгаагийн зөвхөн 68 нь хог хаягдлыг хөрсөөр дарж устгадаг бөгөөд бусад нь ил задгай хаяж байна. Эдгээр хогийн цэгийн эзлэх талбай нь ойролцоогоор 3586 га, зориулалтын хур хог бүхий 242 га талбай байна. Мөн нийслэлийн гэр хороололд хүйтний улиралд ойролцоогоор 81 мянган тонн буюу нэг өрх ойролцоогоор 450 кг хог хаягдлыг шатааж, агаарын бохирдолд нөлөөлж байна. /БОАЖЯ/. Нарангийн энгэр, Морингийн даваа, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт өдөрт 2000-2500 тн ахуйн хог хаягдлыг хүлээн авч, дарж устгах үйл ажиллагааг өдөр бүр ландфилл технологийн дагуу хийж байна.

Хог хаягдлын бүтцийн хувьд орон сууцанд амьдардаг болон цаг улирлын байдлаас шалтгаалж өөр өөр байдаг. Тухайлбал Улаанбаатар хотын нийт өрхийн 57.7 хувь нь гэр хороололд 43.3 хувь нь орон сууцанд амьдардаг байна. Эдгээрээс өвлийн улиралд гэр хорооллын хог хаягдлын дийлэнх хэмжээг үнс эзэлдэг. Жилд орон сууцанд амьдардаг өрхийн тоо 6600, харин гэр хороололд 8000 орчмоор нэмэгддэг байна. Ийм учраас хог хаягдлын хэмжээ жилээс жилд ихэссээр байна. Нийслэлд жил бүр 850 мянган тонн хог хаягдал үүсдэг үүнээс 750 мянган тонн нь ахуйн, 80 мянган тонн нь барилгын хог байна. 2016 онд хог хаягдлын хэмжээ 800 тонн байсан бол 2018 онд 1.4 тонн болж нэмэгдсэн байна. Нийт хог хаягдлын 50 орчим хувь нь дахин боловсруулах боломжтой хог хаягдал байгаа боловч цуглуулж, дахин боловсруулж, экспортлож байгаа хог хаягдлын хэмжээ нэг хувьд ч хүрэхгүй байгаа юм байна. /БОАЖЯ-ны мэдээ, 2017 он/.

Манай улс жилд дунджаар 3.5 сая кг хуванцар, 44 сая ширхэг шилэн лонх болон тэдгээртэй ижил төрлийн бүтээгдэхүүн импортолдог гэсэн Гаалийн ерөнхий газрын мэдээлэл байна. Харин жилд дунджаар 1.2 сая тонн хуванцар, 382 мянган тонн шил, шилэн бүтээгдэхүүнээс үүссэн хог хаягдал ялгардаг. Энэ тоо жил ирэх

бүр өсөх хандлагатай байгаа учир хог хаягдал дахин боловсруулагч аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, дахин боловсруулсан хог хаягдал ашиглагч аж ахуйн нэгжүүдийг урамшуулах шаардлага гарч байна.

**Аюултай хог хаягдал.** 2007 онд Улаанбаатар хотоос жилд 10 мянган тонн аюултай хог хаягдал гарсан бол одоо жилд 29–58 мянган тонн болсон байна. Химийн бодисын хэрэглээний байдалд 2011 онд хийсэн судалгааны дүнгээс харахад зөвхөн Улаанбаатар хотын 6 дүүргийн 75 аж ахуйн нэгжид 400 гаруй нэр төрлийн 891 орчим тн химийн бодис ашиглаж байгааг тогтоожээ. Гэтэл эдгээр аж ахуйн нэгжээс гарсан хаягдлыг хор, аюулгүй болгосон эсэх, ямар хэмжээтэй хаягдлыг хааш нь яаж зайлуулсан зэрэг мэдээлэл тодорхойгүй байна. Мөн 2014 оны тооллогоор Улаанбаатар хот, 21 аймгийн 137 суманд нийт 297 аж ахуйн нэгж, байгууллагад хугацаа нь дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон 369 тонн, 69 мянган литр химийн бодис хадгалагдаж байгаа нь тогтоогджээ.

Аюултай хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар устгах байгууламж байхгүйгээс ихэнх нь энгийн хог хаягдалтай хамт хогийн цэгт, зарим нь хөрс усанд шууд хаягдаж, үлдсэн нь зориулалтын бус газар хадгалагдаж байна. Химийн хорт бодисын хаягдлыг хор аюулгүй болгон зайлуулах байгууламж өнөө болтол манай улсад байхгүй байна. Мөн аюултай хог хаягдлын ангилалд хамрагдах цахилгаан ба цахим хаягдлын асуудал ч тодорхой зохицуулалт байхгүй байна. Эдгээрийг дахин ашиглах, боловсруулах шаардлагатай байгаа юм. Зөвхөн нэг жишээ авч үзэхэд “Байгаль орчин, эрүүл мэнд төв” ТББ –ын 2014 онд хийсэн судалгаагаар нэг өрх 15-17 зайг цахилгаан хэрэглэлдээ хэрэглэж байсан байна. Энэ нь Европын хөгжингүй орнуудын айл өрхийн хэрэглээтэй ойролцоо байгаа юм. Эдгээр улс нь хэрэглэсэн зайгаа тусад нь цуглуулан, дахин боловсруулах үйлдвэрт явуулдаг байна. Гэтэл бид хэрэглэсэн олон нэр төрлийн зайг хаа сайгүй ахуйн хаягдалтай хамт хаясаар өнөөг хүрч байна.

Харин халдвартай хаягдал болох эмнэлэг, эмчлэн сэргийлэх байгууллагаас гарч буй хаягдлыг тусад нь цуглуулж, зөөвөрлөн шатааж байна. Гэхдээ энэ шатаах зуух нь орон нутагт зарим газарт зохих байршлаа олоогүй, зориулалтын бус зуух хэрэглэж байгаагаас нь орчны хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байгаа юм.

*Хог хаягдлын асуудлыг зохистойгоор шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа асуудал:*

- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, устгах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цогцоор нь шийдвэрлэх санхүүгийн чадавхи байхгүй;
- Хог хаягдлын хэмжээ, бүтцийн талаар нарийвчилсан судалгаа, мэдээлэл хангалтгүй;
- Аюултай хог хаягдлыг зохих шаардлагын дагуу зайлуулахгүй байна;
- Төр, хувийн байгууллагын үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог сайжруулах, түүнийг хэрэгжүүлэх хүний нөөц, чадавх, санхүүгийн зэрэг олон асуудлыг цогцоор шийдэгдэхгүй байна;
- Хог хаягдлыг эцэслэн зайлуулах ариун цэврийн ландфилл байхгүй;
- Аюултай хог хаягдлыг аюулгүй болгон зайлуулах туршлага дутмаг байна;
- Хог хаягдлын чиглэлээр сургалт сурталчилгаа хийдэггүй зэрэг болно.



## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХУБ-2030-н 2.3.3.2-т хог хаягдлын менежментийг сайжруулах зорилт дэвшүүлж, дахин боловсруулах хувь хэмжээг үе шаттайгаар тогтоожээ.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах асуудлыг тусгадаг боловч түүнийг хэрэгжүүлэх, үр дүнтэй, зохистой ажил хийгдээгүй байна.

2012-2013 онуудад “Хог хаягдлын тухай хууль”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр” зэрэг хууль эрх зүйн баримт бичгийг шинэчлэн гаргасан. Эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдох дүрэм, журам, заавар хангалттай гарсан байна гэж үзэхээр байгаа юм. Гагцхүү түүнийг хэрэгжүүлэх ажил туйлын хангалтгүй байна.

“Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах хог хаягдлын бүртгэл, мэдээллийг нарийвчлан авч байх асуудлыг 2014 оноос эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан. Мөн хувийн компаниудаар түлхүү хийлгэх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Төр, хувийн компаниуд тодорхой эрх зүйн хүрээнд хамтын ажиллагаагаа нийцүүлэн ажиллах нь манай улсын хувьд илүү үр дүн өгөх юм.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Тогтвортой зохистой эко хэрэглээг оновчтой томъёолж, амьдралд хэрэгжихүйц хөтөлбөр боловсруулж амжаагүй, төлөвлөсөн болон хийгдэж байгаа ажлууд үр дүнд хүрэхгүй цаасан дээр байна.

Банк санхүүгийн орчин ээлгүй, төсвийн ажилтан, тэтгэврийн хөгшид, малчдын 85-90 хувь нь өндөр хүүтэй цалингийн зээлтэй, төрийн үйлчилгээ, эмнэлэг, сургууль, халамж, тэтгэвэр хүртээмжгүй байгаа нь хариуцлагатай, тогтвортой хэрэглээг дэмжихгүй байна.

### **Зөвлөмж**

- Хүний эрүүл мэнд, амь бие, байгаль орчинд сөрөг нөлөөтэй хэрэглээг хориглосон хууль дүрэм журмыг биелүүлж ажиллах,
- Хэрэглэгчдэд олон нийтийн хэрэглээний тухай сургалт хийх, мэдлэг мэдээллийг сайжруулж шинэ шатанд гаргах,
- Бусад улс орнуудаас шахагдсан тоног төхөөрөмж, хуучирсан техник технологийг оруулахгүй байх,
- Иргэдэд хог хаягдлын боловсрол, мэдлэг олгох зохих түвшний мэдээлэлтэй байлгах чиглэлийн ажлыг төр, хувийн хэвшил, ТББ хамтран зохих төлөвлөгөө, аргачлалын дагуу тогтмол явуулж байх,
- Хог хаягдлын хэмжээ, шинж, чанараас хамааран цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээг төрөөс зохион байгуулан явуулах,
- Хог хаягдлын асуудлыг эрхлэх сонирхолыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, тэдгээрийг олон талаар нь хөхүүлэн дэмжих,

- Олон улсад баримталж байгаа “Үүсгэгч нь хариуцах”, “Бохирдуулагч нь төлөх” зарчмуудыг хэрэгжүүлэх чиглэлээр олон талт ажил зохион байгуулах,
- Аюултай хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг зохистойгоор зохион байгуулах бусад улсын туршлага дэмжлэг авах,
- Химийн бодисын болон зарим импортолсон бараа бүтээгдэхүүний хэрэглээнээс үүсэх хаягдал, сав баглаа боодлыг эргүүлэн татаж цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах асуудлыг үйлдвэрлэгч болон импортлогч нь хариуцах асуудлыг шийдвэрлүүлэх зэрэг болно.

### ТХЗ-13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах

*ТХЗ-13.2 Үндэсний хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой арга хэмжээнүүдийг тусгах*

#### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтуудын хэрэгжилт эхлэл төдий, эрх зүйн орчныг сайжруулахад илүүтэй чиглэж байна. Энэ удаагийн тайланд ТХЗ-13-н хэрэгжих нөхцөлийг хангах эрх зүйн орчны байдал, үндэсний бодлого хөтөлбөрт хэрхэн туссаныг үнэлсэн мэдээллийг түлхүү оруулж байна.

#### БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

МУТХҮБ-2030-2.3.2.1-д УАӨ-д дасан зохицох, 2.3.2.2-т Сэргээгдэх эрчим хүчийг дэмжихээр тусгажээ. УАӨ-ийг үүсгэх сөрөг нөлөөллийг буруулах, нөлөөллийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндсэн санаа агуулга тусгагдаагүй.

Зөвхөн гамшиг тохиолдсон үед дасан зохицох болон гамшгаас хамгаалах, бүртгэх, сан үүсгэхээр тусгажээ. Харин мэдлэг боловсрол, хүний болон институцийн чадавхийг дээшлүүлэх үүргийг зөвхөн насан туршийн боловсролын тогтолцоонд даалгасан нь төр үндсэн чиг үүргээ гэж өөриймшүүлэхгүй байна гэж үзэж байна. Энэ нь цаашид жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлдээ тусгахгүй орхих, төсөв санхүүжилт зарцуулахгүй донор санхүүжүүлэгчдэд найдаж байна гэж харагдаж байна.

МУТХҮБ-2030-2.3.2.2-т УАӨ-д нөлөө үзүүлэх хүлэмжийн хийг бууруулсан гэдгийг MNS ISO14001 багц стандарт нэвтрүүлсэн ААН-ийн тоогоор хэмжих гэж байгаа нь байгалийн нөөцөд түшиглэсэн бизнесийн салбарын хүсэл санаачлагаас хамаарсан сайн дурын үйл ажиллагаа мэт харагдаж, заавал хэрэгжүүлэх үүрэг болж чадахгүй байна.

Дэлхийн ТХЗ-13-т заасан УАӨ-д нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийг багасгахад **НЭН яаралтай** арга хэмжээ авах агуулга бүхэлдээ орхигдсон байна.

*ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхарга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5-д 5 арга хэмжээ төлөвлөсөн хэдий ч УАӨ-ийг үүсгэх сөрөг нөлөөллийг буруулахад чиглэсэн агуулга болон нөлөөллийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, дасан зохицох арга хэмжээ тусгагдаагүй байна.*

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт 2016.09 сард нэгдэн орсон тухай<sup>34</sup> УИХ-ын тогтоол гарсан хэдий ч мөрдөх огноо болон тус тогтоолын дугаарыг олгоогүй болно.

Төлөвлөгөөний 4.2.6-д 6 арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд төрөөс бодлого боловсруулах, стандарт шинэчлэн мөрдүүлэх нь зүйн хэрэг хэдий ч нөхөн сэргээлт хийгээгүй орхисон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хөрөнгийг гаргуулах, бизнесийн хариуцлага хүлээлгэх, БОАЖЯ-ны тусгай сангаас хөрөнгө гаргах талаар арга хэмжээ төлөвлөөгүй, татварын болон ОУ-ын төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрэх үр дүнг харуулахдаа 2016 оны суурь үзүүлэлтээ оруулаагүй байгаа нь хэдий хэмжээний ахиц гарсныг харах боломжгүй байна.

#### *Уур амьсгалын өөрчлөлтийн тухай үндэсний хөтөлбөр, 2011-2021*

Хөтөлбөр 8 дах жилдээ, 2 үе шаттай хэрэгжиж байгаа хэдий ч тайлагнал нээлттэй бус, орон нутагт үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв санхүү, арга зүйгээр дэмждэггүй, урамшуулал, хариуцлагын тогтолцоо болон хөгжлийн оролцогч бусад талуудын оролцоо байхгүй зэргээс болж хүссэн үр дүн гарахгүй байна.

#### *Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2010-2020*

Хөтөлбөр 2 үе шаттайгаар 9 дэх жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд БОАЖЯ-ны сайдаар ахлуулсан Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо ажилладаг. НҮБ-аас 2010-2020 оныг Дэлхийн цөлжилттэй тэмцэх 10 жил болгон зарласан хүрээнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Цөлжилттэй тэмцэх конвенцийн хороонд тайлагнах үүргийг ЗГ хүлээсэн хэдий ч тайлагнасан эсэх нь тодорхойгүй байна.

#### *МУ-ын ногоон хөгжлийн бодлого, 2014-2030*

ТХЗ-13.2 болон 13.3 дахь зорилт, агуулга Ногоон хөгжлийн бодлогод маш сайн тусгагдсан болно.

#### *Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, 2015-2030*

Аж үйлдвэрийн салбарыг МУ-ын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилттой 5 таван жилээр 3 үе шаттай хэрэгжих бодлого нь аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ УАӨ-д үзүүлэх нөлөөллийг хэрхэн бууруулах, хөгжлийн оролцогч талуудыг хэрхэн оролцуулах талаар хангалттай тусгаагүй байна. Тухайлбал, Аж үйлдвэрийн Бодлогын зөвлөлд ИНБ-ын болон ШУБ-ын төлөөлөл оролцоогүй байна.

#### *Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, 2014-2025*

Тус бодлогын баримт бичигт УАӨ-д хамгийн нөлөө бүхий салбарт ТХЗ-13-н үзэл санаа огт тусгагдаагүй байна.

<sup>34</sup><https://www.legalinfo.mn/law/details/12109>

### “АЛТ-2” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2017-2020)

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, МУТХҮБ-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар улс эх орны эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилтуудыг хэрэгжүүлэх үндэслэлээр боловсруулсан баримт бичиг. АЛТ-2 хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд ээлтэй байх, нөхөн сэргээх хариуцлагыг сайжруулах талаар тусгасан ч урт хугацаандаа УАӨ-д үзүүлэх нөлөөлөл, үр дагавар, ул мөрийг сааруулах, бизнесийн хариуцлага, үүргийг тусгаагүй орхигдуулсан байна. Бодлогын хэрэгжилтэд зөвхөн УУХҮЯ, БОАЖЯ хяналт тавихаар хязгаарласан байна.

#### *Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, 2018-2027*

Тус бодлогын баримт бичигт газрын тосны салбарыг хөгжүүлж, боловсруулах үйлдвэр байгуулснаар УАӨ-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ төлөвлөөгүй боловч харин 2.3.5.1-д байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологи, олон улсын тэргүүн туршлага, стандартыг нэвтрүүлж, ногоон хөгжлийг дэмжих гэж тусгажээ.

#### *Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр*

Хүн ам олноор төвлөрсөн засаг захиргааны нэгжийн хувьд хүний үйл ажиллагаанаас УАӨ-д үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн мэдлэг ойлголтыг олон нийтэд өгөх, сурталчилгаа хийх, талуудын оролцоог хангах зэрэг тэргүүн ээлжинд хийгдэх арга хэмжээг төлөвлөөгүй байна.

#### *Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын “БИД ХАМТДАА” хөтөлбөр*

121.Цөлжилтийг сааруулах шинэ менежемент хэрэгжүүлж, нөхөрлөл иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ, 122. Усны нөөцийг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ, 109. Уул уурхайн мэдээллийн төв байгуулна гэсэн зорилтууд төлөвлөсөн байна. Харин УАӨ-ийн талаар авах арга хэмжээ огт төлөвлөөгүй байна.

### САНАЛ ЗӨВЛӨМЖ

Үндэсний 10 гаран бодлогын баримт бичгүүд, салбарын болон орон нутгийн бодлогод ТХЗ-ийн үзэл санаа туссан байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд УИХ болон ЗГ-ын буюу илүү чадавх, мэдээлэлтэй төрийн захиргааны төв байгууллагууд боловсруулсан баримт бичгүүдэд ТХЗ-2030-н үзэл санаа хангалтгүй байсан тул орон нутгийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд хэрхэн тусгаж байгааг дүгнэж үзэхэд адилхан хангалтгүй байна.

ДТХЗ-2030, МУТХҮБ-2030 баримт бичгүүдэд үндэслэн боловсруулсан МУ-ын ногоон хөгжлийн бодлого хамгийн сайн бодлого болсон байгаа боловч 2014 оноос хойш 4 жил өнгөрөхөд хэрэгжилт хангалтгүй, өнөөдрийн хүрсэн байх түвшингээ хангасан үр дүн гараагүй байна. БОАЖЯ энэ бодлогын баримт бичигтээ үндэслэн

бусад салбарын бодлогуудыг уялдуулахад анхаарахгүй орхигдуулж байгааг Гурван тулгуурт хөгжлийн бодлого болон АЛТ-2 хөтөлбөрөөс харж болно.

МУ-ын ЗГ-аас баталсан бодлогуудад ТХЗ-ийн үзэл санаа, агуулга, мөн чанар хангалттай тусгагдаагүй, хоорондоо уялдаа муутай нь нийтлэг байгааг мэдлэг чадавхи дутмаг байгаатай холбоотой гэж үзэж байна. УАӨ түүнд нөлөөлөх хүчин зүйл, бууруулах, сааруулах, дасан зохицох арга хэмжээ авч хэрэгжүүлэх арга замуудыг зөвхөн байгаль орчныг хамгаалах, шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, гамшгаас сэргийлэх, даван туулах, мэдээллийг бүртгэж сан үүсгэх, тэдгээрийг олон нийтэд мэдээлэх төдийгөөр хязгаарлаж, явцуу харж төлөвлөсөн байдал нийтлэг байна.

Дэлхийн ТХЗ-2030-д зориуд цохон тэмдэглэж дэвшүүлсэн “**нэн яаралтай**” анхаарах асуудлуудыг МУТХҮБ-2030 болон түүнээс хойш гарсан бодлого, мөрийн хөтөлбөрүүдэд ч анхаарч үзээгүй орхигдуулжээ.

2016 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан УИХ, ЗГ нэг намын төлөөллөөс бүрдсэн. Энэ нь үндэсний болон салбарын бодлогыг боловсруулах шатанд болон батлах явцад ДТХЗ-2030, МУТХҮБ-2030-н зорилтуудыг 2016-2020 оны мөрийн хөтөлбөртөө бүрэн тусгаж, нэгдсэн уялдааг ханган, санхүүжилт төлөвлөж хэрэгжилтийг хангах улс төрийн давуу нөхцөл байдал, боломж бүрдсэн. Гэвч хөгжлийн аливаа талуудтай хэлэлцээр хийхдээ ДТХЗ-2030-н зорилтуудыг үндэсний суурь хэрэгцээ болгож ашиглаж чадаагүй, улс төрийн хүсэл санаачлага гаргаагүй байна. Тухайлбал, ОУВС-тай хэлэлцээр хийхдээ нөхцөлүүдийг хүлээж авах биш, харин ч ОУ-ын өмнө хүлээсэн үүргээ барьж АЛТ-2 хөтөлбөрийг батлахгүй байх боломжтой байсан гэж үзэж байна.

2016 оноос хойш УИХ, ЗГ-аас гаргасан бодлогууд УАӨ-ийг бууруулахад МУ-аас хүлээх үүргийг уялдаатай төлөвлөж чадаагүй, нэг бодлого нь нөгөө бодлогоо хэрэгжихэд дэмжлэг болохгүй харин ч саад болохуйц, үгүйсгэж байна. Тухайлбал, Ногоон хөгжлийн бодлого (2014)-ын хэрэгжилтийг хангахад Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2015), Аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлого (2015), Газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018), АЛТ-2 (2017) үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүдээс харж болно. Мөн үндэсний бодлого, хууль тогтоомжийн зарчим, төлөвлөсөн бодлогоо зөрчсөн захиргааны актууд гаргах замаар угаас ТХЗ, үзэл санааг бүрэн тусгаж чадаагүй бодлогуудын хэрэгжиж үр дүн гаргах боломжийг улам ордуулж байна. Тухайлбал, ЗГ-ын 2014 оны 239-р тогтоолоор ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хуулиар өргөдлөөр олгодог зохицуулалтыг ЗГ-ын тогтоолоор түр зогсоож, ЗГ-ын баталсан журмаар өндөр үнэ төлсөн байдлаар сонгон шалгаруулж олгодог болсон нь иргэдийн оролцоо, хяналтыг байхгүй болгосон төдийгүй Ногоон хөгжлийн бодлого, Орон нутгийн ТХ-ийн бодлого хэрэгжих боломжгүй болгож байна.

УИХ болон ЗГ-аас хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах үе шат, арга зүйг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоож өгсөн. Гэтэл эдгээр хуулиудыг УИХ, ЗГ өөрсдөө баримтлахгүй, нөхцөл байдлын болон үр нөлөөний үнэлгээ хийхгүй, судалгаа шинжилгээнд үндэслэхгүй, хөгжлийн бусад оролцогчидтой зөвлөлдөхгүй бодлого, хууль батлаж байгаагаас дэлхийн ТХЗ-2030-ийн 13.2. Үндэсний бодлого, стратеги,

төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг тусгах зорилт үндсэндээ маш хангалтгүй байна.

Салбарын бодлогуудыг эдийн засгийн хөгжил гэхээс илүүтэй санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гэж хэлж болохоор байна. Гэсэн хэрнээ Цэвэр хөгжлийн механизмын ОУ-ын сайн зохицуулалттай холбогдох талаар үндэсний бодлогуудад тусгаагүй орхигдуулсан байна. УАӨ-д МУ сөрөг нөлөөлөл үзүүлж бий болгосон эдийн засгийн эх үүсвэрээ хэрхэн нийгмийн салбарт, ядуурлыг бууруулахад зарцуулах тооцоолол, бодлого салбарын бодлогуудад тусгалаа олоогүй байна.

МУТХҮБ-2030-г боловсруулахдаа салбарын яамд тус бүрдээ өөрсдийн үндсэн чиг үүрэг, уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн хөгжил, бизнесийн салбарт ээлтэй байхад анхаарч боловсруулсан тул салбар дундын бодлогын уялдаагүй, хууль журмын хэрэгжилтийг хангаж, авилгаас ангид хөгжих боломжгүй, эдийн засгийн шударга бус өрсөлдөөн, нийгмийн хүртээмжийн тэгш бус байдлыг бий болгосон байна.

Монгол Улсад байгаль орчинд үзүүлэх хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн нөөцийг хамгаалах, байгаль орчинд хал багатай, ээлтэйгээр ашиглах, нөхөн сэргээх замаар уур амьсгалын өөрчлөлтийг таслан зогсоох, дасан зохицоход хүрээлэн буй орчны бохирдол, газрын бүрхүүлийн хурдацтай өөрчлөлт, хөрсний доройтол, ус-агаарын бохирдол, нөөц ашиглалтын даацын хэтрэлт зэрэг нь Уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байгаа хамгийн тулгамдсан асуудал болоод байна.

Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн өсөлт, МАА, газар тариалангийн эдийн засгийн өгөөжгүй, тоо хөөсөн чанаргүй өсөлт, үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв шинжийг яаралтай өөрчилж, байгальд ээлтэй загварт шилжих нь чухал болохыг Монгол Улсын сүүлийн 20 гаруй жилийн хөгжлийн сургамжууд харуулж байна.

### **Зөвлөмж**

- Бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай болон Хууль тогтоомжийн тухай хуулиа баримталж, Төр, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, ИНБ, ААН байгууллага зэрэг олон талт оролцоог хангаж, бүхий л салбар, түвшинд уялдаатай хэрэгжүүлдэг практик бий болгох,
- Дэлхийн ТХЗ-13-т заасан УАӨ-д нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийг багасгахад **нэн яаралтай, тусгай** арга хэмжээ авах зорилтуудыг МУТХҮБ-2030-д тусгаж, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох,
- Ногоон хөгжлийн бодлогод тулгуурлан холбогдох бусад бодлогуудыг нийцүүлэх замаар УАӨ-г бууруулахад амлалтыг төлөвлөлтөд тусгах.

### **ТХЗ-14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах**

МУТХҮБ-2030-д усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх зорилт дэвшүүлсэн.



### ТХЗ-15. Хуурай газрын экосистемийг хамгаалах

ТХЗ-15.1 2020 он гэхэд хуурай газрын цэнгэг усны экологийн тогтолцоо, түүний үйлчилгээ, тухайлбал ой, намаг балчиг, уулс, хуурайшилттай газрыг олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах.

ТХЗ-15.2 2030 он гэхэд цөлжилттэй тэмцэх, цөлжилт, ган, үерийн улмаас доройтсон газар, хөрсийг нөхөн сэргээх, дэлхийд газрын доройтлыг зогсоох нөхцөлийг бүрдүүлэх.

### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

МУ-ын УИХ-аас 2005.07.16-ны өдөр “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль батлагдсанаар 240 гаран тусгай зөвшөөрлийг цуцалж, усны эхийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн. Гэтэл өнөөдрийг хүртэл хэдэн тусгай зөвшөөрөл цуцлагдаж, хэдий хэмжээний газар нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн акт байхгүй төдийгүй МХЕГ, БОАЖЯ, АМГТГ-ын аль байгууллага нь энэ ажлыг хариуцан ажиллах зохицуулалт тодорхойгүй, нэгдсэн мэдээллийн сан, хяналт шалгалтын тайлан мэдээ байхгүй байна. Энэ хугацаанд ЗГ-ын 14 тогтоол, сайдын 2 тушаал гаргах замаар хуулийн хүрээнд хамаарах газраас чөлөөлсөн тогтоолууд гаргаж хуулийн анхны зорилго хэрэгжихгүй болсон байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012 онд батлагдаж, БОАЖЯ дагаж мөрдөх журмыг одоо болтол боловсруулж батлаагүйгээс 2018 оны жилийн эцсийн байдлаар дээрх хууль хэрэгжиж эхлээгүй байсаар байна. Иймээс Ус үндэсний хөтөлбөр, Усны тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй, цэнгэг усны экологийн тогтолцоо, түүний үйлчилгээ, тухайлбал ой, намаг балчиг, уулс, хуурайшилттай газрыг олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах талаар ахиц гарсангүй. Ус бохирдуулсаны төлбөрт тушаах 9 тэрбум төгрөгийн татварыг жилд улсын төсөвт төвлөрүүлж чадахгүй байна.

Монгол улс 29 усны сав газрын 21 сав газрын захиргаадыг байгуулсан ч шаардлагатай туршлага, судалгааны бааз байхгүй учир эдгээр сав газрын захиргаадын ажиллагчдыг сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх явдал ТХЗ-уудын хэрэгжилтэд ач холбогдолтой юм<sup>35</sup>. Тухайлбал, Усны тухай хуулийн 17-р зүйлийн 17.2 дахь хэсэгт зааснаар олборлох салбарын тусгай зөвшөөрлийг олгохын өмнө Сав газрын захиргааны саналд үндэслэн эцсийн шийдвэр гаргахаар заасан ч энэ хэмжээний дүгнэлт гаргах мэдээллийн сан, судалгаа, чадавх нөөц байхгүй байна. АМГТГ нь энэ хуулийн заалтыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол огт байхгүй байна.

<sup>35</sup> МУ-ын Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан, 2018. НҮБ-ын Европын эдийн Засгийн комисс

МУ-ын Усны тухай хуулиар 4 жил тутамд явагддаг усны тооллогын дүнгээс харахад жилд дунджаар гадаргын усны 12 % ширгэсэн, сүүлийн 13 жилд гол горхины 8 хувь, булаг шандын 11 хувь, нуур тойрмын 18 хувь нь ширгэсэн байна.

Монгол улс 1990-ээд оны эхэн үеэс 2017 оны байдлаар засаг захиргааны ялгаатай түвшинд 47 сая га газар буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 29.9 хувийг хамгаалалтад авсан байна<sup>36</sup>. Гэвч зэрлэг амьтдын амьдрах их хэмжээний бүс нутаг, өргөн тархалттай, дэлхий нийтийн хэмжээгээр чухал ач холбогдолтой төрөл зүйлүүдийн нүүн шилжих бүс нутаг (коридор) улсын нийт нутгийн 70 хувийг эзлэх “хамгаалагдаагүй ” хэсэгт үлдэж хоцроод байна. Түүнчлэн, хамгаалалттай зарим газарт ч гэсэн өнөөгийн бүсчлэлийн байдал нь чухал ач холбогдол бүхий зэрлэг амьтдын амьдрах орчныг хамгаалж чадахгүй байна<sup>37</sup>.

Засгийн газар ТХЗ-15.3–тай уялдуулан 2030 он гэхэд доройтсон газрын 70–аас доошгүй хувийг сэргээх, цөлжсөн газрын хэмжээг нийт нутгийн 60 хувьд хүртэл бууруулах томоохон зорилтууд дэвшүүлсэн. Гэвч газрын доройтлыг бууруулахад чиглэсэн бодлогыг амьдрал дээр хэрэгжүүлэхэд талуудын оролцоо дутмаг, мэдээлэл нээлттэй биш, байгууллагуудын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтгүйгээс үр дүнд хүрэхгүй байна.

2015 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь ямар нэгэн байдлаар эвдэрч, доройтолд орсоноос 24.1 хувь нь бага зэрэг, 29.8 хувь нь дунд зэрэг, 16.8 хувь нь хүчтэй, 6.1 хувь нь маш хүчтэй доройтолд ороод байна. Хүчтэй болон маш хүчтэй доройтолд орсон газар нь Увс нуурын сав газар, Их нууруудын хотгор, Дундговь болон Дорноговь аймгийн хуурай болон цөлөрхөг нутагт ажиглагдаж байна<sup>38</sup>.

Газрын доройтлын ихэнх нь ХАА-н газарт ажиглагдаж байна. Бэлчээрийн бүс нутаг 1987 онд 123.6 сая га газар эзэлж байсан бол 2016 онд 112.2 сая га болж багасчээ. Энэ хугацаанд малын тоо толгой 1987 онд 22.7 сая байснаас 2018 онд 61.5 сая болж 2.7 дахин нэмэгджээ. Үүний улмаас малын тоо толгойн нягтшил 1987 онд 100 га газарт 18 толгой мал ногдож байсан бол энэ үзүүлэлт 2016 онд 54 толгой мал болж нэмэгдсэн нь бэлчээрт үзүүлэх дарамтыг эрс нэмэгдэхэд хүргэсэн байна. 2015 оны эцэс гэхэд нийт бэлчээрийн 63 хувь нь хэт бэлчээрлэлтэд өртжээ<sup>39</sup>.

Хэт бэлчээрлэлтийн зэрэгцээ ХАА-н газарт уул уурхайн тусгай зөвшөөрлүүд олгогддог бөгөөд 2019 оны 02 дугаар сарын 04 өдрийн байдлаар ашигт малтмалын нийт 3074 тусгай зөвшөөрөл байгаагаас ашиглалтын 1681, хайгуулын 1393 тусгай зөвшөөрөл, газрын тосны 24 гэрээт талбай, 20 орчим баяжуулах боловсруулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл байна<sup>40</sup>. Уул уурхайн үйлдвэрлэлд хатуу хучилттай зам тавихгүйгээр тээвэрлэлт хийх, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг орхигдуулах, төрийн хяналт шалгалтын хариуцлагагүй, сул дорой, авилгын өндөр эрсдэл зэрэг нь бэлчээрт ихээхэн дарамт учруулж байна. Монгол улсад газрын доройтлыг сэргээх, хамгаалах болон бэлчээр ашиглалтыг зохицуулах эрх зүйн

<sup>36</sup> МУ-ын Байаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016

<sup>37</sup> МУ-ын Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан, 2018, НҮБ-ын Европын эдийн Засгийг комисс

<sup>38</sup> Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016, БОАЖЯ

<sup>39</sup> Монгол улсын жендэрийн үндэсний үнэлгээний тайлан, 2019, ЖҮХ

<sup>40</sup> <https://mrpam.gov.mn/public/pages/133/2019.01.pdf>



орчин байхгүй байсаар байна. Энэ хууль олон жил яригдаж хэлэлцэгдэж байгаа ч төсөл хэлбэрээр байсаар байна.

Уул уурхайн үйл ажиллагаа сүүлийн 20 жилд эрс нэмэгдэж, уул уурхайн бүс дэх иргэд болон агаар, хөрс, ус, мал аж ахуй, цаашлаад тэдний эрүүл мэнд уул уурхайн үйл ажиллагааны хуримтлагдсан нөлөөлөлд өртөж байна. Уул уурхайн эрүүл мэндэд учруулах гамшигт шороо тоостой холбоотой амьсгалын замын өвчин болон химийн бодист хордох явдал орж байна. Гэтэл БОНБУ-ний хуулиар заагдсан хуримтлагдах болон эрүүл мэнд, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй, энэ үнэлгээг хийлгэх үүрэгтэй БОАЖЯ болон ЭМЯ нь хүсэл санаачлага гаргахгүй байна.

Ашигт малтмалыг сорчлон олборлох нь АМТХ-иар хориотой хэдий ч компаниуд сорчлон олборлоод байгаль орчны үүргээс бултах байдал хэвийн үзэгдэл болсон ба БОАЖЯ-ны сайд 2011 онд хэвлэл мэдээллээр өгсөн ярилцлагадаа уул уурхайн эдэлбэрт өртсөн газрын 46.8% нь эзэнгүй талбай байна гэж мэдээлж байсан бол 2018 оны сүүлээр БОАЖЯ орхигдсон газрын тооллого хийгээд 59 мянган га талбайд төрөөс хөрөнгө гаргаж нөхөн сэргээлт хийх шаардлага байна гэж тайлагнасан. 2015-2016 оны БО-ны төлөв байдлын тайланд дурьдсанаар 1 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж дуусах хүртэл 200.0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гаргасан байдаг.

Гэтэл БОНБУ тухай хууль болон АМТХ-д зааснаар компани нь тухайн жилийн нөхөн сэргээлт хийх баталгаа болгож БОАЖЯ-ны төрийн сангийн тусгай дансанд нийт зардлын 50 хувийг жил бүр шинээр байрлуулж, нөхөн сэргээлт хийсний дараа буцааж компанид олгох, харин нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд БОАЖЯ мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлтийг хийлгэж дутагдах хөрөнгийг компаниас үл маргах журмаар гаргуулан авч жил бүр нөхөн сэргээлт хийж байх зохицуулалт бий. Гэвч компаниуд нэг га-д хийх нөхөн сэргээлтийн хөрөнгийг хэт багаар тооцож жилдээ 100.000-2.5 сая төгрөг байршуулдаг ч буцааж авдаггүй, яам ч нэхэж шаарддаггүй. БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай санд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайланд мэдээлснээр сүүлийн 3 жилд тус сангаас зориулалтын дагуу нэг ч хөрөнгө гараагүй байгаа бөгөөд одоо 50 гаруй тэрбум төгрөг байхаар атал ердөө 10 тэрбум төгрөг байгаа мэдээлэл байна<sup>41</sup>. Энэ сангийн мэдээлэл бүрэн хаалттай, БОАЖЯ нууж хаацайлж байгаа нь зориулалт бусаар зарцуулдаг, хөрөнгийг компаниудаас төвлөрүүлдэг эсэх, яам Ногоон хөгжлийн бодлогоо хэрхэн манлайлан хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Ус бохирдуулсаны төлбөрийн хууль 2012 онд батлагдсан ч одоог болтол түүний бохирдлыг тооцох аргачлал журмыг БОАЖЯ батлаагүйгээс энэ хууль хэрэгжихгүй 7 жил болж байна. Байгаль орчны асуудал үнэхээр хурцадмал, анхаарах түвшинд очсон гэдгийг ААН-үүд хүлээн зөвшөөрч тэдний 86 хувь нь бохирдуулагч нь төлөх ёстой зарчмыг хүлээн зөвшөөрч, 90 хувь нь БО-д одооноос яаралтай анхаарал хандуулах ёстой гэсэн байгаа нь ихээхэн сайшаалтай бөгөөд харин төрийн зөв

---

<sup>41</sup> Хил хязгааргүй алхам ТББ-ын мониторингийн тайлан, 2017

оновчтой, цогц бодлого тогтолцоо бүрдүүлэхэд оролцогч талын хандлага бэлэн байгааг харуулж байна<sup>42</sup>.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

**МУТХҮБ-2030-᠔** Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно. Байгаль орчны багц үзүүлэлтээр дэлхийд 111-д байгааг 90 болгож урагшлуулах, Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээг бууруулж 78.2-оос 68 хувьд хүргэх, Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг 17.4 байгааг 30 хувьд хүргэх, гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг 100 хувь дотоодын эх үүсвэрээс хангах зорилтууд дэвшүүлсэн байна.

МУТХҮБ-2030-2.3.1.1.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ. I үе шат (2016-2020): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх.

МУТХҮБ-2030-2.3.3.1.Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална. I үе шат (2016-2020): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх зорилтууд 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр:** ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөндТХЗ-2030-н үзэл санааг бүрэн агуулсан, мөрийн хөтөлбөрийн зорилтоосоо илүү сайн арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа ч 2018 онд хүрсэн байх үр дүн нь гараагүй байна.

**Орон нутгийн ТХЗ:** Архангай аймаг орон нутгийн ТХ-ийн 44 зорилт, 70 дэд зорилттой 2026 он хүртэлх бодлого боловсруулан баталсан байна. Тус бодлогоо Архангай аймгийн ЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, МУ-ын Ногоон хөгжлийн бодлоготой уялдаатай боловсруулсан нь Дэлхийн ТХЗ-2030 үзэл санаа бүрэн туссан байна. Хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хувьд 2020 онд аймгийнхаа нийт нутгийн 35 хувийг тусгай хамгаалалттай газар нутагт хамруулах, байгаль орчны нөхөн сэргээлтийг 40 хувь, ойгоор бүрхэгдсэн газар нутгийн хэмжээг 18.5 хувьд хүргэж улсын хүрэх түвшнээс давуулах зорилт дэвшүүлсэн нь сайшаалтай байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

### Дүгнэлт

МУ-ын бодлогын баримт бичгүүдэд усны экологийн тогтолцоо, түүний үйлчилгээ, тухайлбал ой, намаг балчиг, уулс, хуурайшилттай газрыг олон улсын гэрээний

<sup>42</sup> ААН-үүдийн байгаль орчны асуудлуудын талаарх ойлголт мэдлэг, хандлагыг тодорхойлох суурь судалгаа, 2016 он, “Монголын марктенгийн судалгааны ассоциаци” ТББ

хүрээнд хүлээсэн үүргийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах асуудлаар багагүй бодлого хөтөлбөрүүд гаргасан нь сайшаалтай байна. Эдгээр бодлогууд нь ОУ-ын гэрээний болон ДТХЗ-15.1 дэх агуулгыг боломжтой байдлаар тусгасан бөгөөд шалгуур үзүүлэлтийг хэмжих бэлэн мэдээлэлтэй байна.

Цөлжилттэй тэмцэх, гамшгийн эрсдлийг бууруулах, доройтсон газар, түүнийг нөхөн сэргээх асуудлаар тодорхой бодлогууд гаргаж МУТХҮБ-2030-д агуулгыг хангалттай хэмжээнд тусгаж төлөвлөсөн байна.

Гэвч гэрээний үүрэг, бодлогын баримт бичгүүд ялангуяа үндэсний хөтөлбөрүүд, хууль тогтоомжийн хэрэгжилт практикт туйлын хангалтгүй байна. ДТХЗ-15-н зорилт нь БОАЖЯ-ны чиг үүрэгт хамаарах хэдий ч бусад салбар хоорондын зохицуулалт, ажлын уялдаа хангалтгүй зөвхөн гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлж тайлагнахын төлөө үйл ажиллагаа явуулж байна гэж үзэхээр байна.

Мөн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй төдийгүй тогтмол өөрчлөгддөг ялангуяа улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөх бүрт “уул уурхай байгаль орчны хууль тогтоомж” өөрчлөгдөж байна. Жишээ нь. АМТХ-иар хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгохоор заасан, /хүсэлт гаргасан дарааллаар олгох/ гэтэл 2016 оноос ЗГ-ын журмаар /хэн их мөнгө төлсөн дуудлага худалдаа/ олгох болсон нь хуулиас давсан захиргааны актаар нийтийн баялгийг олгож байна. Энэ тохиолдолд орон нутгийн захиргаа болон иргэдийн оролцоо бүрэн хаалттай болж байна.

Бизнесийн салбарт төр болон ААН ялгаагүй байгаль орчны хариуцлага (15.1, 15.2) хүлээхгүй байна. БО-ны шударга ёс, ашиг хүртэгчдэд үр нөлөөтэй хариуцлага тооцдог, шүүхээр хохирлыг тогтоох зэрэг арга хэмжээ огт авагдахгүй, энэ тогтолцоо ажиллахгүй байна. Тухайлбал, НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслийн судалгаанд дурьдсанаар байгаль орчны эсрэг гэмт хэргийн 60 хувь нь хэрэгсэхгүй болсон бол ердөө 5 хувь нь хэрэг үүсгэн шалгагдаж шүүхийн шийдвэр гарсан ч хэрэгжээгүй байна.

## Санал

- МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлж буй Алт-2 болон Гурван тулгуурт хөгжлийн бодлого зэрэг баримт бичгүүдийн үр нөлөөний судалгаа хийж ДТХЗ-6,13,15-н зорилтууд тэдгээрийн шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн сайжруулах, сөрөг нөлөө бүхий зарим бодлогуудын хэрэгжилтийг зогсоох,
- “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн хэрэгжилтэд нэн даруй анхаарал хандуулж БОАЖЯ үндсэн хариуцагчаар манлайлж ажиллах замаар усны засаглалыг сайжруулах,
- БОНБУ-ний тогтолцоонд олон нийтийн үүрэг оролцоог тодорхой болгох,
- БОНБУ-ний мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ИНБ-ын төлөөллийг оролцуулж, үйл ажиллагаа, хуралдааны тэмдэглэл, гаргасан шийдвэрийг олон нийтэд нээлттэй болгох,
- Засгийн газрын төслүүдэд БОНБУ-ний тухай хуульд заасан хуримтлагдах болон стратегийн нөлөөллийн үнэлгээг заавал хийх,
- Байгаль орчны аудитын үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд хийгдэж байгаа гэхээс илүүтэй сайн дурын үүрэг эсвэл хөрөнгө оруулагчийн шахалтаар

хийгдэж байгаа тул Төрийн өмчийн оролцоотой ААН, Засгийн газрын төслүүдэд аудит хийх,

- УТХГН-ийн хамаарах бүс дэх доройтсон орчныг нөхөн сэргээх байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах зорилго бүхий “ландшафтын нөөц газар” гэсэн ангилалыг шинээр бий болгон энэ зориулалтаар тодорхой газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авдаг эрх зүйн орчин бүрдүүлж, дүйцүүлэн хамгаалсан газрын экологийн үр ашгийг нэмэгдүүлэх,
- УТХГН-т хамгаалалтад авахдаа түүний экосистемийн үйлчлэлийн хамрах хүрээний бүсийг хамтад нь тогтоон түүний дотор нүүдлийн уламжлалт МАА-аас бусад аливаа бизнесийн зориулалтаар газар олгохгүй байх эрх зүйн орчин бүрдүүлэх,
- БО-ны улсын байцаагч нар болон цагдаагийн байгууллагууд байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн тухай иргэд, ТББ-н мэдээллийг хүлээн авч, үйл ажиллагааг нь дэмжиж, мэдээлэгч нарт санхүүгийн урамшуулал олгох, нууцлалыг хамгаалах механизмыг бүрдүүлж хэрэгжүүлэх,
- УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ, МХЕГ хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох зөвлөлдөх уулзалтын тогтолцоог бий болгох,
- Цөлжилтийг бууруулах, газрын доройтлыг сэргээх, нөхөн сэргээлт хийх, биологийн олон янз байдлыг хамгаалахад гарах санхүүжилтийг төрөөс гаргах, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар байгалийн нөөцийн төлбөрийг эргээд өөрийг нь сэргээхэд зарцуулах, ОУБ-ын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг зөвхөн чадавхи бэхжүүлэхээс илүүтэй нөхөн сэргээлт хийхэд зарцуулах,
- Уул уурхайн төслийн нөлөөлөлд өртсөн хадлан, өвөлжөө хаваржаа, мал, хүн, отор хадлангийн нутаг, рашаан ус зэрэг мэдээллийн үзүүлэлт гаргадаг болох.

### ТХЗ-16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох

#### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

##### *ТХЗ-16.1. Хүчирхийллийн бүх хэлбэр, түүнээс үүдэлтэй нас баралтын түвшинг дэлхий дахинд үлэмж хэмжээгээр бууруулах*

Жил бүр 10 гаруй хүн хүчирхийллийн улмаас амь насаа алдаж<sup>43</sup> байгаа явдал жөндөрт суурилсан хүчирхийлэл нэн тулгамдсан асуудал хэвээр байгааг харуулж байна.

*Зураг 10. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гаралт, 2010-2017 он*

<sup>43</sup> Цагдаагийн ерөнхий газрын статистик, 2017



**ТХЗ-16.1.3 Сүүлийн 12 сарын дотор бие бялдар, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн амын эзлэх хувь**

Сүүлийн 12 сард бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувийг нийт хүн амын тоонд тархааж, ЦЕГ-т бүртгэгдсэн ГБХ-ийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоотой харьцуулж үзвэл нийт тохиолдлын 0.9 хувь нь албан ёсоор ЦЕГ-т ГБХ-ийн гэмт хэрэг гэж бүртгэгдсэн байна<sup>44</sup>. Эндээс гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгддэг улмаар даамжирч, давтагдаж хүний амь нас эрсдэх аюултай байгааг харж болно.

Монгол улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай урьдчилан сэргийлэх хууль 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд 1 жил 10 сарын хугацаа өнгөрч байна.

Улсын төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хуваарилагдаагүй цагт бид хүчирхийлэлтэй тэмцэж чадахгүй юм.

Хүчирхийлэлд өртөгчдийн дийлэнх нь ид хөдөлмөрийн 20-44 насны залуучууд, тэдний хүүхдүүд байдаг. Иймд эдгээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүд орхигдсон эсвэл орхигдох эрсдэлд байгаа тул бодлого боловсруулагчид тэдний нөхцөл байдалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна.

**ТХЗ-16.2.1 Сүүлийн нэг сард асран хамгаалагчаасаа сэтгэл санааны болон бие махбодын ямар нэгэн шийтгэл хүлээсэн 1-17 насны хүүхдийн тухайн насны хүүхдэд эзлэх хувь**

Дэлхийн Зөн ОУБ байгууллага нь 2018 оны 12-р сард Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг үнэлэх зорилгоор Улаанбаатар хотын 6 дүүргийн 36 хороо, 11 аймгийн 52 суманд хөтөлбөрийн суурь судалгаа<sup>45</sup> явуулсан бөгөөд ТХЗ-16.2.1 шалгуур үзүүлэлтэд холбогдох мэдээллийг энд авч үзлээ.

**ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ**

<sup>44</sup> Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа, 2017, ҮСХ

<sup>45</sup> Дэлхийн зөн ОУБ, Хөтөлбөрийн суурь судалгаа, 2018

Эцэг эхчүүд хүүхдүүдээ асран хамгаалах гол үүрэг хариуцлага хүлээдэг учир гэр бүлийн орчинд хүүхдийн сайн сайхан байдал хангагдаж байгаа эсэхийг тодруулахын тулд өсвөр үеийнхнээс “**Чи гэр орондоо байхдаа ямар нэгэн айх аюулгүй байж чаддаг уу?**” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт өсвөр насныхны 69.4% нь, зорилтот бүлгийн хүүхдүүдийн 65.7% нь хамгаалагдсан орчинд амьдардаг гэж мэдээлсэн байна.

Эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд багачуудаас эцэг эхчүүдийн хэрэглэдэг хүмүүжлийн аргуудын талаарх асуултад өсвөр насны хүүхдүүдийн 50.9% (n=3412), эцэг эхчүүдийн 62% (n=3511) нь сүүлийн нэг сарын хугацаанд хүмүүжлийн сөрөг арга ашигласан гэж хариулсан байна. Эцэг эх, асран хамгаалагч нарын ашиглаж буй хүмүүжлийн сөрөг аргын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтүүдэд үзүүлээ.

Хүснэгт 7: Хүүхдээ хүмүүжүүлэх арга барил (Насанд хүрэгчдийн судалгааны дүнгээр)

N	Эцэг эхийн хариулт	Хүүхэд хүмүүжлийн сөрөг аргын 11 хэлбэр		Бие махбодийн шийтгэлийн 6 хэлбэр	
		#	%	#	%
1	Хүмүүжлийн сөрөг арга ашиглаагүй эцэг эх, асран хамгаалагч	2152	38.0	4422	78.1
2	1-3 сөрөг арга ашигласан эцэг эх, асран хамгаалагч	2691	47.5	1149	20.3
3	4 болон түүнээс дээш сөрөг арга ашигласан эцэг, эх асран хамгаалагч	820	14.5	92	1.6
	Нийт	5663	100.0	5663	100.0

Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх туршлага: Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 48.1%, эцэг эх, асран хамгаалагч нарын 48.8% нь хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх явцад гар хүрэх тохиолдол байж болно гэж хариулсан байна.

Монгол Хүүхдүүд: "Тогтвортой Хөгжлийн Зорилго-2030" Анхдугаар хэлэлцүүлэгт оролцогчдын санаачлага, Дэлхийн зөн ОУБ:

Тулгамдаж буй асуудал	Шийдэл
<p>Гэр бүл, сургуулийн орчинд хүчирхийлэл өндөр байна</p> <p>Цахим орчинд ялгаварлан гадуурхалт их байна</p> <p>Томчууд хүүхдийн санал бодлыг сонсохгүй байна</p> <p>Хүчирхийллийн тухай ойлголт дутмаг байна</p>	<p>Хүчирхийллийн эсрэг сургалтанд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч нарыг хамт суух</p> <p>Сургууль бүрт сэтгэл зүйч байнга ажиллуулах</p> <p>Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг тогтмол явуулж байх</p> <p>Сургууль дээр шинжлэх ухаан, технологийн, дэлхийн олон төрлийн мэдээллийг тогтмол хүргэдэг системтэй байх</p>

*Чанарын судлагаа: Орон нутгийн иргэдтэй ярилцлага хийх үеэр хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх явцад гар хүрэх нь байж болох энгийн зүйл гэж үзсэн байна. Монголын уламжлалт соёл, ёс заншил нь хүүхдийг хүмүүжүүлдэг гэдэгт итгэдэг бөгөөд хэрэв буруу зүйл хийсэн бол эцэг, асран хамгаалагч нь хүүхдээ сахилгажуулахын тулд бие махбодийн шийтгэл үзүүлэх нь зөв гэж үзсэн байна. Мөн түүнчлэн хүүхдүүд эцэг эхчүүд нь тэдний төлөө хамгийн сайн зүйлийг нь хийнэ гэдэгт итгэдэг учир тэдний зүгээс ирэх бүхий л зүйлсийг хүлээж зөвшөөрсөн байдаг.*

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хүүхдийн эсрэг гэмт хэрэг бүхий бүлгийг 2015 онд нэмж оруулсан. Хүүхдийн эрхийн тухай хуулийг 2016 онд батлахдаа аливаа хэлбэрээр хүүхдийг хүчирхийлэхийг хориглож, хүүхэд бүхий л орчинд зодож шийтгүүлэхээс ангид байх эрхийг тусгайлан баталгаажуулсан болно. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хамт үндэсний түвшинд хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг орон нутгийн түвшинд үзүүлэх хууль зүйн болон санхүүгийн баталгааг бүрдүүлж чадсан болно. Засгийн газрын 270 дугаар тогтоолоор 2017 онд Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг баталсан.

Монгол Улс Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх дэлхийн түншлэлд нэгдсэн.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хүүхэд хамгааллын тогтолцоог цогцоор нь чиг үүргээ гүйцэтгэхэд анхаарч, Хамтарсан баг бүр Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг чанд хэрэгжүүлэхүйц чадавхтай болоход анхаарах;
- Биет болон цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх мэдлэг, ойлголт, ур чадварыг үүрэг хүлээгч, эцэг эх, насанд хүрэгчдэд албан бус сургалтын хэлбэрээр даруй олгох;



- Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ажилладаг цагдаа, прокурор, шүүгч, хүүхдийн эрхийн байцаагч, бусад төрийн алба хаагчдад тасралтгүй, мэргэжлийн, давтан сургалтын хэлбэрээр хүүхдийн эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх;
- Хувийн хэвшлийн зүгээс хүүхдийн эрхийг хөхиүлэн дэмжих үүднээс ажилтнуудад хүүхдэдээ цаг зориулах хөдөлмөрийн уян хатан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Хүүхдийн тусламжийн утас 108 дугаарын хүний, санхүүгийн, техникийн нөөцийг дээшлүүлэх.

*ТХЗ-16.2.2100,000 хүнд ногдох хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын тоо, хүйс, насны бүлэг, мөлжлөгийн хэлбэрээр*

ЦЕГ-ын мэдээгээр зөвхөн хохирогчдын тоог ТХЗ-ын мэдээллийн санд гаргаж байгаа бөгөөд хүйс, насны бүлэг, мөлжлөгийн хэлбэрээр задалсан мэдээлэл байхгүй байна. Энэ нь бүрэн хэмжээний орчуулга хийгдээгүйтэй холбоотой байх талтай.

Албан ёсны статистикийн мэдээ нь ЦЕГ-ын мэдээлэлд тулгуурладаг. Харин амьдрал дээрх бүртгэл, судалгаанаас харахад ХТЭТ-өөр үйлчлүүлж буй хохирогчдын 2 хүн тутмын 1 нь цагдаагийн байгууллагад хандсан байдаг бөгөөд хандаагүй үлдсэн хохирогчдыг албан бус хохирогч хэмээн үзэж дээрх тоонд оруулан тооцоолол хийвэл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны тоо баримтыг зохих ёсоор гарсанд тооцож болохоор байна.

ТХЗ-16.2.2 үзүүлэлтийг үнэлэхэд тухайлбал, 2016 онд ХТЭТ нь ХХГХ-ийн нийт 29 хохирогчийг хүлээн авч туслалцаа үзүүлсэн байхад, ЭЦГ 14 тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн, 3 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, МУ-ын шүүх 9 гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн тоо баримт байгаа<sup>46</sup> нь тооны хувьд ТББ болон төрийн байгууллагуудын хооронд хэт зөрүүтэй байгааг харуулж байна.

*ТХЗ-16.2.318 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан 18-29 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь*


ГБХ-ийн гэмт хэргийн улмаас 2015-2017 онд нийт 225 хүүхдийн эрх зөрчигдөж хохирогч болжээ. Дээрх онуудад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн нийт хохирогч хүүхдийн 132 нь бага насны хүүхэд байсан бөгөөд 2015 онд хохирсон хүүхдийн 65%, 2016 онд 53.6%, 2017 онд 57.7% нь 14-өөс доош насны хүүхэд байсан байна<sup>47</sup>.

*Зураг 14. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн тоо, 2015-2017*

<sup>46</sup> Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн статистик мэдээлэл, 2015-2017


<sup>47</sup> Цагдаагийн ерөнхий газар





ХЭҮТ-өөр 2016-2018 онд үйлчлүүлж сэтгэлзүйн ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан нийт 163 хүүхдийн дийлэнх нь айдас, түгшүүрт автах (43%), уур уцаартай(35%), түрэмгий авиртай(46%), бусадтай харилцаа тогтоож чадахгүй(21%), өөрийгөө буруутгах(60%), өөрийгөө ямар ч хамгаалалтгүй мэт санах(24%) байдлууд нь буурч тайвширч, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргэж эхэлсэн үр дүн гарчээ.

Зураг 15. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэлзүйн байдал, үйлчилгээнд хамрагдахаас өмнө болон дараа, хүүхдийн хувиар



Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ)-д үйлчлүүлж буй гурван эмэгтэй тутмын нэгний хамтрагч нь бага байхдаа хүчирхийллийн харилцаатай гэр бүлд төрж, өссөн байв. Үүнээс үзэхэд бага насандаа хүчирхийлэлд өртөх, хүчирхийллийг харж өсөх нь цаашид хүчирхийлэл үйлдэх нэг хүчин зүйл болох тул дунд болон урт хугацааны **сэтгэлзүйн хүүхдийн үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэх шаардлагатай юм**<sup>48</sup>.

Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа, 2017-д хамрагдсан 10 эмэгтэй тутмын нэг нь хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэгчид нь гэр бүлийн бусад гишүүд (29.5%), найз нөхөд танилууд (19.0%), танихгүй хүн(18.7%) байсан

<sup>48</sup> Түвшинжаргал Г, Сувд Б. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэлзүйн байдал. Хүүхэд хөгжлийн орчин үеийн асуудлууд, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2018. х.520

гэжээ. Цагдаагийн байгууллагаас гаргасан судалгаагаар 2012 оны эхний 10 сарын байдлаар насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг 37 бүртгэгдсэн бол, 2013 оны эхний 10 сарын байдлаар 54 хэрэг, 2015-2016 онд улсын хэмжээнд 298 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэх тоон мэдээлэл байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид маш эмзэг хохирогч болдог. Гэмт хэргийн хохирогч болсон охидын эрсдлийг тооцон хүүхэд бүрт тохирсон хамгаалалт, эрүүл мэнд, сэтгэл засал болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх тусгайлсан механизм, стандарт байхгүй байна (ЭБЭЭНН, 2018). Охид бэлгийн хүчирхийлэлд нэг удаа өртөөд зогсохгүй байнгын бэлгийн дарамтад байх, улмаар өсвөр насандаа хүүхэд төрүүлэх, БЗДХ-т өвчнөөр өвчлөх явдал гарсаар байна. Хүчирхийлэлд өртсөн охидод дүгнэлт гаргахад эмч нар сургагдаагүйгээс бие бие рүүгээ түлхэх, өмгөөллийн хөлс, эрх зүйн туслалцаа үнэтэй, БЗДХ бусад өвчлөлийг оношлох, эмчлэх үйлчилгээ үнэ төлбөртэй, сэтгэлзүйн хохирлыг хуулиар тогтоодоггүй зэрэг нь хүүхдийг давхар давхар хохироосоор байгаа.

### *ТХЗ-16.5 Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах*

*Жишээ: Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын асуудал*

Улсын төсвийн томоохон хувь хэсэг, гадны зээл, буцалтгүй тусламжийг сүүлийн жилүүдэд зарцуулж ирсэн ч боловсролын салбарын нөхцөл байдал, үр дүн олон нийтийн хүлээлтэд хүрэхгүй түвшинд байгаагийн нэг шалтгаан нь боловсролын салбар дах авилгын асуудал гэж иргэний нийгмийн байгууллагууд үздэг. Салбар дахь авилгын үр уршгаар боловсролын чанар доройтож, хүртээмж хомсдож, эрх тэгш байдал алдагдаж, улмаар улс орны хөгжил дэвшилд хортой нөлөө үзүүлж байна гэдгийг Транспаренси Интернейшнл байгууллага дүгнэжээ. Хамгийн сүүлд Азийн сангийн боловсролын салбарт хийсэн “Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авлигын асуудалд” судалгаанд оролцсон эцэг эхчүүд боловсролын салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг 2.65 буюу “дунд зэрэг” гэж үнэлсэн бол салбарын багш, ажилтан, судлаачдын хувьд 3.37 буюу “их” гэсэн үнэлгээ өгч, илүү шүүмжлэлтэй хандаж байна. Харин сургууль, цэцэрлэгт хүүхэд элсүүлэх, шинээр оруулах, анги өөрчлөх, сурлагын дүн, үнэлгээ өөрчлөхөд мөнгө, албан тушаал, танил тал ашиглах явдал нийтлэг байна гэж нийт судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь ойлголт, төсөөлөлтэй байна. Харин чанарын судалгааны мэдээллээс үзэхэд авлигад зарцуулсан гэх мөнгөний хэмжээ хэдэн сая төгрөгөөр хэмжигдэж байна. Судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь нь энэ салбарын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаал дэвших, томилгоо, шагнал урамшуулал олгох үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил “их” гэсэн төсөөлөлтэй байна. Юуны өмнө салбарын удирдлага, ялангуяа сургуулийн захирлуудын ёс зүйн асуудал, мөн улс төрийн нам, албан тушаалтны зүй бус нөлөөлөлтэй холбоотой шүүмжлэлүүд багш, ажилтнуудын дунд их байна. Жишээлбэл, чанарын судалгаанд оролцсон багш, ажилчдын 13 хувь нь ажилд орох, албан тушаалын томилгоотой холбоотойгоор бэлэг сэлт, мөнгө өгч байснаа дурджээ. Тоон судалгаанд оролцогч иргэдийн 46 хувь нь салбарын худалдан авах ажиллагаанд авлига их бий гэсэн төсөөлөлтэй байна. Салбарын худалдан авах ажиллагаанд авлига, мөн өөрсдийн ажиглалт, бодит тохиолдлууд байгаа зэргийг хувийн хэвшлийнхэн хүлээн зөвшөөрч байна. Олонх тохиолдолд салбарын дунд, дээд шатны албан тушаалтнууд холбогдож байх бөгөөд тендертэй холбоотой авлигын дүн тухайн гэрээний үнийн дүнгийн 5-10 хувьтай тэнцүү байдаг байна.

Тухайлбал, чанарын ярилцлагад оролцсон 13 аж ахуйн нэгжийн зургаа нь авлигын замаар худалдан авах ажиллагаанд нөлөөлж байсан гэжээ. Ерөнхий боловсролыг бүх нийт үнэ төлбөргүй эзэмшинэ гэсэн заалт Монголын боловсролын тогтолцоонд бүрэн хэрэгжиж чадахгүй байна. Жишээлбэл; сурагчийн дүрэмт хувцас, ном сурах бичиг, ангийн фонд, сургууль, анги засварын мөнгө гэх мэт эцэг эхийн нуруун дээрх зардлууд байна. Судалгаанд оролцсон иргэдийн 50 гаруй хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургууль, цэцэрлэгт хандив тусламж, төлбөр хураамж өгчээ. Энэ нь сурагчдыг суралцах үйл явцаас сатаарах, ялгаварлан гадуурхалтад өртөх, багшийн зүгээс сурагчийг харах хандлага өөрчлөгдөх цаашлаад сургуулиа хаях үр дагавартай байна.

*ТХЗ-16.10.2 Олон нийтийн мэдээлэл авах эрхийг үндсэн хууль, хууль тогтоомж, дүрэм журам, бодлогын түвшинд баталгаажуулж, хуульчилсан эсэх*

Мэдээлэл олж авах эрхийн ахиц дэвшлийг үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

Монгол Улс 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хууль баталж, 2013 онд Нээлттэй засгийн түншлэлд гишүүнээр элссэн нь улс орны хүрээнд мэдээлэл олж авах эрхийг бэхжүүлэх улс төрийн хүсэл, зориг байгааг илтгэж байна. Тус эрхийг баталгаажуулсан хууль, эрх зүйн хүрээ нь харьцангуй сайн, өргөн цар хүрээг ч хамруулсан байдаг. Харамсалтай нь төрийн байгууллагын төлөөллийн тус хуулийн талаарх мэдлэг ойлголт хангалтгүй байдгаас үүдэн хуулийг бүрэн хэрэгжүүлэх нь Засгийн газрын хувьд томоохон сорилт хэвээр байна. Мөн Засгийн газар, төрийн байгууллагаас олон нийтэд ил тод болгох мэдээлэлд тогтоох хязгаарлалтууд их байгаа нь харамсалтай.

МУТХУБ-2030-2.1.5.7-д Төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлсэн байх зорилт дэвшүүлсэн. ТХЗ-16.10.2-г хэрэгжүүлэхэд Төр болоод Засгийн газрын байгууллагын ил тод, нээлттэй байдал нь мэдээллээ цахимаар нийтлэх, төрийн байгууллага бүр мэдээллийн бие даасан ажилтан томилох, иргэдийн илгээсэн мэдээлэл авах хүсэлтийг боловсруулах механизмтай болоход л хангалттай.

ДТХЗ-2030 хөтөлбөрийн чухал үзүүлэлтүүдийн нэг нь олон талт оролцогч талуудыг хамруулах билээ. Хөтөлбөрийн хүрээнд хүрэх, өөрчлөхөөр зорьж буй үйл явцыг нийгмийн аливаа төлөөлөл, тухайлбал, Засгийн газар, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аль нэг төлөөлөл, дан ганцаар удирдах, хэрэгжүүлэх боломжгүй юм. Мэдээлэл олж авах эрхийн хэрэгжилтийг үнэлэхдээ, бүрэн дүр зургийг гаргахыг зорих шаардлагатай. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжлийн газар зэрэг байгууллагууд мэдээлэл олж авах эрхийг хангах байдлын талаарх мэдээллийг иргэний нийгмийн байгууллагуудаас цуглуулж, үндэсний хэмжээнд нэгтгэж, үндэсний аливаа бодлого боловсруулах, төлөвлөх үйл явцад ашиглаж болно. Мэдээлэл олж авах эрхийн хэрэгжилтийг үнэлэх төрөл бүрийн арга зүйн дагуу өгөгдөл, мэдээлэл цуглуулсан нь анхны чухал алхам бөгөөд үнэлгээг цаашид тасралтгүй хийх нь эн тэнцүү ач холбогдолтой.

FOIAnet буюу Мэдээллийн эрх чөлөөний нөлөөллийн сүлжээ байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу Монгол Улсад мэдээлэл олж авах эрхийг хэрхэн хангаж буйг 2019 онд ТББ-ууд хөндлөнгийн үнэлгээ хийхэд боломжит 100 онооноос 39,8 оноо авсан буюу улаан, шар, ногоон гурван зэрэглэлээс **шар өнгө**тэй

үнэлэгдсэн болно. Судлаачдын зүгээс “Мэдээлэл олж авах эрхийн хуулийн хэрэгжилтийг хариуцдаг бие даасан, тусгай байгууллага Монгол Улсад байхгүй. Төрийн байгууллагуудад мэдээлэл хариуцсан ажилтан нь хуулийн талаарх мэдлэг ойлголт дутмаг, энэ чиглэлээрх албан ёсны сургалтад хамраагдаагүй. Байгууллагын нууцын талаарх тодорхой зааваргүй боловч нууцын талаарх хэвшсэн соёл хүчтэй хэвээр байна” хэмээн дүгнэжээ.

Мэдээлэл олж авах эрхийг хангаж буй өнөөгийн байдал төгс биш ч, ТХЗ-16.10.2 дахь шалгуур үзүүлэлтийг үнэмлэхүй хэмжээгээр ахиулах боломж ирээдүйд байгаа нь олзуурхууштай. Түүнчлэн, энэхүү ахиц дэвшил нь ТХЗ-ын бусад ололт, амжилт төдийгүй Монгол Улсын Үндэсний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хурдасгагч хөдөлгүүр болно.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний 2 дугаарт гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхэд төрсөн цагаасаа эхлэн өмчийн эзэн байх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ хэмээн заасан байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, 2017-2021-ийн 2.2.5 дугаар зорилтод хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгасан байгаа ч хөтөлбөрийн тайлагналт нээлттэй бус, орон нутагт үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв санхүү, арга зүйгээр дэмждэггүй, хөгжлийн оролцогч талуудын оролцоо сул байна. Энэ хөтөлбөр 2021 онд дуусахаар байгаа ч өнөөдрийг хүртэл хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ явагдаж чадахгүй байна.

МУ-ын Гурван тулгуурт хөгжлийн бодлогын 3.7.1.14-т хүүхдийг аливаа эрсдэл, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, энэ талаарх гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх хэмээн хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар тусгасан байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бол хамгийн ичгүүртэй хүний эрхийн зөрчил бөгөөд хамгийн түгээмэл тархсан зөрчил байдаг. Хүчирхийлэл оршсоор байгаа цагт бид тэгш эрх, хөгжил дэвшил, энх тайвныг бодитоор олж авахад ямар ч ахиц дэвшил гаргаж чадахгүй билээ. Иймээс ч ТХЗ-ын 5.2, 5.3, 16.1, 16.2-т эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлэх явдлыг таслан зогсоох, хүчирхийллийн бүх хэлбэр, түүнээс үүдэлтэй нас баралтын түвшинг дэлхий дахинд үлэмж бууруулах талаар тусгасан. Гэтэл МУТХҮБ-2030-д огт тусгагдаагүй бусад бодлогын баримт бичгүүдэд тунхаглал төдий тусгагдсан байгаа нь энэхүү хүний эрхийн ноцтой зөрчилд МУ-ын Засгийн газар сул анхаарч байна хэмээн үзэж байна.

Зөвлөмж:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах төсвийг суулгаж, ТХЗ-ын 16.1 дэх зорилтод заасан хүчирхийллийн бүх хэлбэр, түүнээс үүдэлтэй нас баралт, эндэгдлийг үлэмж бууруулах бүрэн боломжийг бүрдүүлэх,
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтанг орчуулагч, хэлмэрчээр бэлтгэх, 24 цагийн үнэ төлбөргүй, видео дуудлага хийх утас ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн түр хамгаалан байрлуулах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг улсын хэмжээнд бий болгох,
- Хүчирхийллийг таслан зогсооход Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын олон талт хамтын ажиллагааг чиглүүлэх,
- Үе дамжсан хүчирхийллийг таслан зогсоохын тулд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд мэргэжлийн байгууллага, сэтгэлзүйчид нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлыг эрүүл мэндийн даатгалын сан, хүүхэд хамгааллын хөтөлбөрийн санхүүжилтээр шийдвэрлэх,
- Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь бодит аюулд өртсөн, хамгаалалт шаардлагатай хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн үйлчилгээг хэвээр үлдээх,
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар хохирогчдод хэд хэдэн төрлийн үйлчилгээ үзүүлэхээр заасан байгаа боловч энэхүү үйлчилгээг хэн, хэрхэн хүргэх, үзүүлж буй үйлчилгээг хэрхэн санхүүжүүлэх асуудлыг хууль тогтоомжоор тусгайлан зохицуулах,
- ХХГХ-ийн хохирогчдын сэтгэл санааны нөхөн төлбөрийг хэрхэн шийдэх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байгааг анхаарч, цаашид үүнтэй холбогдуулан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- ХХГХ-ийн бодит нөхцөл байдлыг тодорхойлохын тулд албан бус тоо буюу ТББ-ын тоо бүртгэлийг ашиглах аргачлал бий болгох.

### ТХЗ 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

#### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

ТХЗ-17.4 Өрийн санхүүжилт, өрийн дарамтыг бууруулах, өрийн бүтэцдээ өөрчлөлт оруулах, их хэмжээний гадаад өртэй орнуудын өрийн ачааллыг хөнгөвчлөх асуудлыг шийдвэрлэх зэрэгт чиглэгдсэн нэгдсэн зохицуулалттай бодлогоор дамжуулан хөгжиж буй орнуудын өрийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

Монгол Улсын нийт төсөвт гадаадын шууд хөрөнгө оруулалт болон Хөгжлийн албан ёсны тусламж/ХАЁТ/ 2017 оны байдлаар 65.8 хувьтай тэнцүү байна /ҮСХ хороо/ гэж мэдээлсэн.

Монгол Улсын хувьд гадаадын зээл, тусламж нь эдийн засгийн голлох хүч хөдөлгүүр болдог ба 1991 оноос хөгжлийн албан ёсны тусламж /ХАЁТ/ -ийн хүрээнд түншлэгч орон, олон улсын байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, буцалтгүй тусламж авсаар ирсэн. Мөн тус улс нь зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний

үедээ гадаадын улс орон, олон улсын байгууллагуудаас авсан хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүнээс 1.6 дахин их хэмжээнд хүрч, шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн юм.

ХАЁТ-ийн хэмжээ 2007 онд ДНБ-ний 8 хувьтай тэнцэж байсан бол 2014 онд 3 хувь хүртэл буурч 2016 онд 4 хувьд хүрсэн байна. Хөгжлийн түншүүдээс Монгол Улсад үзүүлж буй дэмжлэг туслалцааны хэмжээ 3.2 тэрбум ам. доллартай тэнцэж байна. Албан ёсны тусламжинд хамгийн их хандив оруулж байгаа нь Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг ЖАЙКА, БНХАУ, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Мянганы Сорилын Корпораци<sup>49</sup> байна гэж МУ-ын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээнд дурдсан байна.

2017 оны байдлаар Дэлхийн Банк 213,5 сая ам долларын<sup>50</sup>, Азийн Хөгжлийн Банк 1.95 тэрбум ам.долларын засгийн газрын зээл, 237.21 сая ам.долларын буцалтгүй тусламж, 149.4 сая ам.долларын техникийн туслалцаа<sup>51</sup>, Япон улс нь 1.191.35 буцалтгүй тусламж, 1.579.44 хөнгөлттэй зээл, 496.86 техник хамтын ажиллагаанд нийт 3.267.65 /100 сая иен/<sup>52</sup> өртөгтэй төсөл хэрэгжүүлж байна.

Гадаадын зээл, тусламж авсан зарим салбаруудаас дурьдвал:

Барилга, хот байгуулалтын яам 2016 онд 174.450.000 ам. долларын болон 9.535.000 еврогийн төсөл, Зам тээвэр, хөгжлийн яам 2017 онд 422.2 сая ам. доллар, 65.6 тэрбум иенийн зээлээр 10 төсөл, Эрүүл мэндийн яам 2018 онд 545 тэрбум төгрөгийн 20-иод төсөл тус тус хэрэгжиж байна.

2018 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих 127 төсөлд нийт 941.7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Зарим төсөлд их хэмжээний мөнгө зарцуулсан ч бодитой үр дүнд хүрэхгүй байна. Үүний нэг жишээ нь: Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад олон төсөл хэрэгжсэнээс, 2008-2016 онд Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулахад 147 тэрбум төгрөг (60 орчим сая доллар), нэмэлт 60 сая ам долларыг хандивлагчдын санхүүжилтээр тус тус зарцуулсан байна. Мөн 175 мянган сайжруулсан зуух тараахад нийслэлийн гэр хорооллын нийт өрхийн 97.6% хамрагдаж, нийт 68 тэрбум төгрөг зарцуулсныг НҮБ, АХБ-ны “Монгол Улс ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаархи бодлогын зөвлөгөө өгөх” баримт бичигт дурдсан байна. Гэвч агаарын бохирдол буурахгүй бүр ихсэж, гамшгийн байдалд хүрээд байна.

“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахаар олон талт ажлуудыг хийсээр байгаа боловч дорвитой үр дүн харагдахгүй байсаар хүн амын өвчлөл улам ихсэж, 2000 онд 10.000 хүн ам тутамд 791 тохиолдол байсан амьсгалын тогтолцооны өвчин 2016 онд 1647 болж 2 дахин нэмэгдсэн байна” гэж ЭМ-ийн сайд цохон тэмдэглэлээ.

Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл хэрэгжих үед дараах дутагдлууд байсаар байна. Тухайлбал: Зарим яам, төрийн захиргааны

<sup>49</sup>МУ-ын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ: Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн төрөлжүүлэх нь 2018

<sup>50</sup>Дэлхийн банк

<sup>51</sup> Азийн хөгжлийн банк

<sup>52</sup>Япон улсын ЭСЯ-ны вэбсайт, Япон улсаас Монгол улсад үзүүлсэн ХАЁТ.2017.04.05

байгууллагууд хэрэгжүүлж байгаа төслийн хэрэгцээ шаардлагыг оновчтой төлөвлөөгүй, техник эдийн засгийн үндэслэлийг тодорхой /бодит байдал, эрсдэл, хэрэгцээ, шаардлагын судалгаа зэрэг/ хийдэггүй мөн төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээг цаг тухайд нь зохион явуулдаггүй, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаа зэрэг нь төслийн үр дүн, өгөөжид муугаар нөлөөлж байна гэж Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүнд 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд үзсэн байна.

Манай Улсын гадаадын зээл, тусламжаар авсан мөнгө нь буцааж төлөгдөх өр юм. Монгол Улсын Засгийн газрын өр 2017 оны 12 сарын 30-ны байдлаар 22.7 их наяд төгрөг байна. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт тайлант онуудад 773.6 тэрбум, үүнээс үндсэн төлбөрт 582.7 тэрбум, хүүгийн төлбөрт 190.9 тэрбум төгрөгийг төлжээ.

Манай улс нь 1991 оноос ХАЁТ-н хүрээнд түншлэгч орон, олон улсын байгууллагаас хөнгөлттэй нөхцөлтэй зээл, буцалтгүй тусламж авч, салбар бүрт эдгээр зээл тусламжаар олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж ирсэн. Гэвч эдгээр төсөл, хөтөлбөрүүд зохих хугацаандаа хэрэгждэггүй, зарим төслүүд нь үр дүн, бодит өгөөж муутай байдаг дутагдлууд гарсаар байгаа юм. Энэ талаар 2018 оны 10 сарын УИХ-ын чуулганаар “Төсөл хөтөлбөрүүдийн үр дүнгийн талаар” хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн С.Бямбацогт хэлэхдээ:

Өнөөдөр манай улсад гадаад, дотоодын зээл тусламжийн хүрээнд нийтдээ 47 төсөл хэрэгжиж 400 гаруй хүн ажиллаж байгаа юм байна. Төслийн нэгж нь байгуулагдчихаад төсөл нь хэрэгждэггүй нь үнэн. Жишээ нь Эгийн голын усан цахилгаан станц. Нэлээд их хөрөнгөөр төслийн нэгжийг байгуулсан атал өнөөг хүртэл үр дүн байхгүй. Мөн гэр хорооллыг хөгжүүлэх зорилгоор Германаас 50 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг аваад зарцуулчихсан. Гэтэл утаа алга болсонгүй. Гэр хорооллыг хөгжүүлэх тодорхой бодлого чиглэл гарсангүй. Мөн эрчим хүчийг сайжруулах чиглэлээр Германаас төсөл хэрэгжүүлсэн. Тус төслийн 55 хувь нь буцаад зөвлөх үйлчилгээний зардалд зарцуулагдсан. Ийм байдлаар төслүүдийн үр өгөөж нь харагдахгүй байна. Төсөл хэрэгжихээс өмнө их сайхан зүйл ярьдаг. Гэтэл бодит байдалд үр дүн байдаггүй. Японоос 80 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр экспортыг дэмжих төсөл хэрэгжүүлж байгаа. Гэтэл 5700 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээс хэд нь өнөөдөр экспортод татваргүй гарч байна вэ. Төслийн нэгжүүд хэр хангалттай ажиллаж байна вэ гэдэгт хяналт байна уу гэжээ.

Төр засаг нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэх нөхцөл-боломж бий болгох үүрэгтэй. Улсын болон ард иргэдийн санхүүгийн эрх хамгийн эрсдэлтэй, нэн аюултай нөхцөлд ноцтой зөрчигдөж энэ талаар төрөөс нэгдсэн цэгцтэй бодлого боловсруулж, бодитой зорилт дэвшүүлээгүй байна.

Монгол улсад гадаад орнуудын 24-н элчин сайдын яам, 4-н өргөмжлөлт консулын газар, НҮБ-ын байгууллагууд, 2-талт болон олон талт хамтын ажиллагаатай байгууллагууд, ОУ-ын тусламжийн байгууллагууд оршин байрлаж хамтарч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ХАЁТ-ийн хүрээнд албан мэдээгээр 1219 төсөл хөтөлбөр хэрэгжсэн болон хэрэгжиж багагүй хөрөнгө нөөцийг дайчилжээ. Гэвч хүмүүсийн амьдрал, улс орны хөгжил дээрдэхгүй улам доройтсоор байна. Монгол улсын иргэн бүр, 2050 оноос хойш төрөх хүүхэд ч өртэй, энэ талаар төрийн бодлого зохицуулалт байхгүй, өрийн удирдлагын хууль хэрэгжихгүй-өрийн удирдлага



алдагдлаа. Хөрөнгө оруулалтууд өмнөх өрүүдийн эргэн төлөлтөд явсаар улсын өр нэмэгдэх, хөрөнгө оруулах хэмжээгээр татвар төлөгчдийн ачаа нэмэгдэж, өрийн таазаа өндөрлөж байна. Чанартай ажлын байр бий болохгүй, хөдөлмөрийн нэгдсэн үнэ тарифгүй, гэрээ хийхгүй, гэрээгээ зөрчдөг, хөдөлмөрийн хүний эрх ашгийг хамгаалах механизм байхгүй, шүүхийн шийдвэр биелэхгүй байна. Багахан хэмжээний бэлэн мөнгө тараах ажлын хүрээнд их хэмжээний мөнгийг үргүй зарцуулан шамшигдуулж, улс төрийн хоосон амлалт олон нийтийг туульдуулж, төрдөө итгэх итгэлийг үгүй хийлээ.

## БОДЛОГОД ТУССАН БАЙДАЛ

*МУТХҮБ-2030-д 2.1.6.3* “Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2020 он гэхэд 58.6 хувиас, 2025 он гэхэд 50 хувиас, 2030 он гэхэд 40 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах” гэж тусгагдсанаас өөр зүйл байхгүй байна.

*Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт* “Гадаадын хөрөнгө оруулагчдын бодлогын хамтын ажиллагааны болон хууль эрх зүйн тогтвортой байдал, тааламжтай орчинг бүрдүүлж, тэдгээрийн эрх ашигт хамаарах олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, дэд бүтэц, бусад бүх салбарт төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож, *Шилэн тендер шалгаруулалт* бодлого хэрэгжүүлнэ” гэж орсон байна.

*Гурван тулгуурт хөгжлийн бодлогод* Гадаадын зээл тусламжийн талаар тодорхой зүйл тусгаагүй байна.

Эдгээр баримт бичгүүдэд ХАЁТ-н хүрээнд хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийн чиглэлээр хийгдэх үйл ажиллагааг сайжруулах, зээл тусламжийн үр, өгөөжийг нэмэгдүүлэх талаар тодорхой зүйл тусгаагүй байна гэж харлаа.

Зээл тусламжийн үр дүнгийн талаар ил тод, нээлттэй байх асуудал туйлын хангалтгүй байдаг. Гадаадын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд гэрээний дагуу хэр зэрэг бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа мөн үр өгөөж нь бодитой байгаа эсэх нь учир дутагдалтай байдаг талаар улсын үндэсний аудитын шалгалт, зарим ТББ байгууллагаас хийсэн мониторингийн дүнгээс харагдаж байгаа юм. Ийм учраас бодлогын баримт бичгүүдэд гадаадын зээл тусламжийн хүрээнд нийгдэх үйл ажиллагааг сайжруулах талаар, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тодорхой тусгаж өгөх нь зүйтэй байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад гадаадаас үзүүлж байгаа зээл, тусламж чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл эдгээр зээл, тусламжийн хэрэгжилт, түүний үр өгөөжийн байдалд тавих хяналт төдийлөн тогтвортой, бодитой бус, үйл ажиллагаа нь нээлттэй, тодорхой биш байна.

Технологи, инновацийн дэвшилттэй хөрөнгө оруулалт хийж байгаа нэрийн дор дэлхийд шахагдсан хоцрогдсон үйлдвэр тоног төхөөрөмжүүд ирж байна.



ОУ-ын түвшинд мэдээлэл хуваалцах цахим ертөнцөд аюулгүй ажиллагаа явуулах хууль дүрэм, норм стандарт тогтоох ажил хугацаа алдан хоцорч явна.

Байгаль орчинд ээлтэй технологийг боловсруулах, үнэ хөнгөлөх концесс хийхдээ төрийн өндөр дээд албан тушаалтан, УИХ-ын гишүүдэд бүрэн эрх олгож авилгад автаад байна. ШУ, технологи, инновацийн өндөр бүтээмж ашиглалт нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн хөгжлийн шугаманд нэгдэн үндэсний төлөвлөгөөтэй уялдуулах, ОУ-д чөлөөт худалдаа хийх мэдлэг чадвар-сэтгэл дутагдаж байнга алдагдалтай ажилласаар байна.

Дохагийн хөгжлийн төлөө хөрөнгө оруулалт зэрэг баримт бичгийг олон нийтэд таниулж мөрдөөгүй, экспортыг эрс нэмэгдүүлэх нэрээр түүхий эдийн хог хаягдлыг авч үлддэг. ДХБ-аас хөнгөлөлтэй нэрээр дотоодын зах зээлийн хамгаалалт, хил гаалийн хяналт алдагдан үндэсний үйлдвэрүүд дэлхийн тэрбумтнуудтай шудрага бус өрсөлдөөнд орж эрсдэж байна.

Гадаадын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслийн хэрэгжилтэд ИНБ-ын оролцоог хангах, хариуцлагатай, хамтын ажиллагааг идэвхижүүлэх нь төсөл хэрэгжүүлэх үед гарах элдэв зөрчил, дутагдлыг таслан зогсоох, ил тод ажиллагааг хангах улмаар зээл, тусламжийн үр өгөөжийг сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ.

#### Зөвлөмж

- Бүх салбаруудыг хамарсан гадаадын зээл тусламж, ХАЁТ-ийн үр өгөөжийг хэмжих мэдээллийг МУТХҮБ-2030-н шалгуур үзүүлэлтэд нэмж оруулах;
- Зээл тусламжийн үр нөлөөг сайжруулах талаар Парисын тунхаг, Аккрагийн үйл ажилагааны хөтөлбөр, Үр ашигтай хөгжлийн төлөө Бусаны түншлэл зэрэг санаачлагын хүрээнд “ИНБ-тай хамтран ажиллах талаар авсан амлалт”-ыг бодитойгоор хэрэгжүүлэх;
- Хамтын ажиллагааны зөвлөлдөх төрөл бүрийн шатны уулзалт болон бусад үйл ажиллагаанд ИНБ-ын төлөөллийг оролцуулах, олон талын оролцоог хангах;
- Санхүүгийн хүртээмж, дэд бүтцийг бий болгож, өндөр болзолтой хөрөнгө оруулалт-нууц хэлэлцээрүүдийг ил болгох;
- Ямар ч сонголтгүй арилжааны банкны /банкны систем сайжруулах-ТИКА5, 1510-МОН/SF төслүүд/ өөртөө давуу эрх олгосон, тулгасан гэрээний хүчингүй байдлийг олон нийтэд ил болгох,
- 24-96, түүнээс дээш хувийн хүүтэй болон өдрийн зээлэнд, өмч хөрөнгөө /газар-баялаг/ шүүхийн шийдвэргүй хураалгах явдлыг таслан зогсоох, хөрөнгийг нөхөн төлүүлэх,
- Татвар ногдуулалт том, жижиг аж ахуйн нэгжид шударга үйлчилдэг байх,
- ХАЁТ-н хүрээнд дайчилсан хөрөнгөөр ардчилсан өмчлөл, чанартай ажлын байр, цалин хөлсний нэгдсэн тариф бий болгох,
- Хөрөнгө оруулалтаар өмнөх өрийн эргэн төлөлт хийж, өрийн ачааг жирийн иргэн, татвар төлөгчдийн нуруунд үүрүүлж, өрийн тааз өндөрсгөдөг үйлдлийг зогсоох,
- Тэтгэлэг нэрээр өчүүхэн хэмжээний бэлэн мөнгө тараах, утаагүй зуух, утаагүй түлш, жижиг дунд үйлдвэр /химийн үйлдвэрүүд/, ДЦС зэргээр мөнгө угаах зэрэг улс төрийн хоосон амлалтаа зогсоох,
- “Монголд үйлдвэрлэв” брэнд нэрийг өндөрт өргөн ашиглаж, хог хаягдалгүй, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох,

- Шаардлагагүй импортоос татгалзаж дотоодын зах зээл, үндэсний үйлдвэрүүдийг хил гаалийн бодлогоор хамгаалах,
- ОУ-ын хөрөнгө оруулалт, ЗГ-ын худалдан авалтын хүрээнд дэлхийгээс шахагдсан техник тоног төхөөрөмж-хуванцар нийлэг материалаас эрс татгалзах,
- ОУ-ын банк санхүүгийн байгууллагуудыг ил тод оруулж, монголын банк нэртэй ч гадаад эзэдтэй, банк нэрийн дор мөнгө хүүлэгч нарт шудрага өрсөлдөөн бий болгох.

## V. АГААРЫН БОХИРДОЛ: ХӨГЖЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

### ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Монгол улсын нийт хүн амын бараг тал хувь нь оршин суудаг Улаанбаатар хот 2016 оноос хойш дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой нийслэл гэж нэрлэгдсэн ба одоо дэлхийн хамгийн их PM2.5 тоосонцортой хот болсон байна.


МУ-ын ҮСДИ-д хөгжлийн тулгамдаж буй асуудлын нэг нь “агаарын бохирдол” гэж авч үзсэн бөгөөд ИНБ-н сүлжээний тайланд холбогдох асуудлыг эх, нялхсын эрүүл мэнд талаас нь тодотгохыг зорьлоо. МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ 2019 оны 5-р сард **Эмэгтэйчүүдийн нүдээр: Агаарын бохирдол ба эх, хүүхдийн эрүүл мэнд XIII чуулганыг зохион байгуулсан нь ТХЗ-н хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр болж байна.** Тус чуулганаар:

- ✓ МУТХҮБ-2030”-д тусгагдсан зорилт, шалгуур үзүүлэлтийг хангахад тулгарч буй сорилтуудыг тодруулах;
- ✓ Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бодлого, арга хэмжээ, санхүүжилт нь эх, хүүхдэд учрах нөлөөлөл, эрсдлийг бууруулахад чиглэгдэж байгаа эсэхийг хэлэлцэж, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
- ✓ Агаарын бохирдлыг бууруулах дунд болон урт хугацааны зорилгын зэрэгцээ нэмэгдүүлэхгүй байх, эх, хүүхдийн эрүүл мэндэд учирч буй эрсдэл, сөрөг нөлөөллийг арилгахад шаардлагатай бодлого, стратегийг бий болгох хэрэгцээ, шаардлагын талаар хэлэлцэж, нэн тэргүүнд авах боломжит арга хэмжээнүүд болон бодлогын нөлөөллийн чиглэлийг тодорхойлох;
- ✓ Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах, агаарын бохирдлын улмаас эх, хүүхдэд учирч байгаа эрсдэл, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа төв, орон нутаг, иргэдийн санаачилга, сайн туршлага, инноваци, хүрсэн үр дүн, сургамжийг хуваалцах;
- ✓ Төр, засгаас агаарын бохирдлыг бууруулахаар хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр, арга хэмжээ, санхүүжилтийн эрэмбэ, чухалчлах түвшинд нөлөөлөх чиглэл, хамтын зорилт, стратегиудаа тодорхойлж, байр суурь, дуу хоолойгоо нэгтгэх зэрэг асуудлын хүрээнд хэлэлцэж, шийдлээ илэрхийлсэн юм.

Энэ бүлэгт дээрх чуулганд тавигдсан илтгэл, мэдээллээс түлхүү иш татсан болно.

Бүдүүн ширхэглэлт PM10<sup>53</sup> болон нарийн ширхэглэлт PM2.5 тоосонцоруудын хүлцэх хэмжээ стандартыг даваад зогсохгүй жилийн ихэнх өдрүүд агаарын бохирдолтой байгаа тухай албан ёсны статистик мэдээллийг Зураг 15-д үзүүлээ.

Зураг 15. Тоосонцоруудын хүлээн зөвшөөрөх хэмжээнээс давсан өдрийн жилд эзлэх хувь, 2011-2018 он



Тоосонцорын дундаж агууламж 2011 онд жилийн 365 хоногийн дунджаар 237 өдөр хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс давж байсан бол 2018 онд 338 өдөр болж өссөн байна<sup>54</sup>.

Улаанбаатар хотын агаарын бохирдол нь хүүхэд болон жирэмсэн эмэгтэй бүрийг эрсдэлд оруулах хэмжээнд хүрсэн ба ялангуяа гэр хороололд амьдардаг хүүхдүүд, жирэмсэн эхчүүд хамгийн өндөр эрсдэлтэй байна. Эдгээр эрсдэлүүд нь амьгүй төрөлт, дутуу төрөлт, жин багатай төрөлт, хатгалгаа, бронхит, гуурсан хоолойн багтраа өвчин болон хүүхдийн нас баралт зэргээр хязгаарлагдахгүй болж байна. Энэ нөхцөлд тэдний хувьд эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байна<sup>55</sup>.

### 1. Ургийн эндэгдэл

Агаарын бохирдол хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэх үеэс сөргөөр нөлөөлж, хэвлийдээ эндэх гол шалтгааны нэг болж байна. Хорт агаар жирэмсэн эхийн хэвлийд байгаа ургийн уушиг болон амьсгалын замын тогтолцоонд нөлөөлж, улмаар хугацаанаасаа өмнө төрөх, өсөлтгүй болох, зулбах аюулд хүргэж байна.

<sup>53</sup> Барилгын ажил, гудамж талбайн цэвэрлэгээ, салхи шуурга, хүн, автомашины хөдөлгөөн зэрэг голдуу механик ажиллагаанаас бүдүүн тоосонцор PM10 үүсдэг. Түүнчлэн ургамлын тоос, бактер, хөгц, үнс, хөө тортог зэрэг нь бүдүүн тоосонцорт орно.

<sup>54</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яам

<sup>55</sup> Аюулын харанга: Агаарын бохирдол ба хүүхдийн эрүүл мэнд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүүхдийн сан, 2018 оны 2 дугаар сар

Манай улсад ургийн эндэгдлийн өвөл, зуны улирлын хоорондох ялгаа 3.5 дахин зөрүүтэй байна<sup>56</sup>. Энэ нь өвлийн улиралд жирийн үеийнхээс 3.5 дахин их хүүхэд хэвлийдээ эндэж байна гэсэн үг юм.

Жирэмсний тээлтийн дунд болон сүүлийн 3 сард хүхрийн давхар исэл, тээлтийн бүх хугацаанд том ширхэглэгт тоосонцорын агууламж хүлцэх хэмжээнээс ихсэхэд нярайн төрөх үеийн жинг дунджаар 138 граммаар бууруулж байна. Жирэмсний тээлтийн дунд болон сүүлийн 3 сард хүлцэх хэмжээнээс 2 дахин ихэссэн том ширхэглэгт тоосонцор ба хүхрийн давхар ислийн агууламж нь дутуу төрөх эрсдлийг 2 дахин нэмэгдүүлж ураг 26-30 долоо хоногтойдоо дутуу төрж байна. Жирэмсний тээлтийн эхний 3 сард том ширхэглэгт тоосонцорын болон азотын давхар исэлийн агууламж хүлцэх хэмжээнээс 10 нэгжээр ихсэхэд ураг амьгүй болох эрсдэлтэй байна<sup>57</sup>.

## 2. Нялхсын эндэгдэл<sup>58</sup>

Улсын хэмжээнд 2018 онд 79.0 мянган хүүхэд төрсний 1465 (1.9%) нь гадаадад төрсөн байна. Манай улсад 77.1 мянган эх амаржиж, 77.5 мянган хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 3174 (4.3%)-өөр, амьд төрсөн хүүхэд 3200 (4.3%)-гаар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд нялхсын эндэгдэл 2018 онд 1037 болж, өмнөх оноос 28 (2.8%)-аар нэмэгджээ. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2018 онд 13 болж, өмнөх оноос 1 хүүхдээр буурчээ.

## 3. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл<sup>59</sup>

Улсын хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1310 болж, өмнөх оноос 66 (5.3%)-гаар нэмэгдсэн байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17 болж, өмнөх онтой адил түвшинд байна. МУТХҮБ-2030-д 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2020 он гэхэд 15.0 болгон бууруулна гэж заасан. Гэвч агаарын бохирдлоос шалтгаалан энэ зорилтдоо хүрэх боломж улам алдагдаж байна.

Тухайлбал, уушигны хатгалгаа нь 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байна. 2017 онд тав хүртэлх насандаа 1244 хүүхэд эндсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 384 тохиолдлоор буюу амьд төрсөн 1 000 хүүхдэд ногдох эндэгдэл 4.1 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 86.4 хувь нь өвчнөөр, 13.6 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн бөгөөд 72.6 хувь нь эмнэлэгт, 27.4 хувь нь эмнэлгээс гадуур эндсэн байна<sup>60</sup>.

---

<sup>56</sup> Д.Энхмаа., ба бусад, ‘Монгол Улсад улирлын чанартай агаарын бохирдол нь ураг аяндаа зулбахтай шууд корреляци хамааралтай’, BMC Pregnancy and Childbirth, 2014, 14, (1), х. 146

<sup>57</sup> Агаарын бохирдол урагт, бага насны хүүхдийн хатгалгаа өвчинд нөлөөлөх нь, АУ-ны доктор, Д.Гантуяа, АШУИС, НЭМС

<sup>58</sup> МУ-ын Нийгэм, эдийн засгийн байдал 2018, ҮСХ

<sup>59</sup> МУ-ын Нийгэм, эдийн засгийн байдал 2018, ҮСХ

<sup>60</sup> Эрүүл мэндийн хөгжлийн төв

Гэтэл 12-р сард 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 121 байсан бол ганцхан сарын дотор 21(21.0%)-ээр тус тус нэмэгджээ<sup>61</sup>.

#### 4. Нярай болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл

Улаанбаатар хотод амьсгалын замын халдвар сүүлийн 10 жилд 27 хувиар өссөн байх бөгөөд нийслэлд амьдардаг хүүхдүүдийн уушиг хөдөө амьдардаг хүүхдүүдээс 40 хувиар илүү өвчлөмтгий байгааг НҮБ-ын Хүүхдийн сангийн тайланд<sup>62</sup> дурьдсан байна.

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлд хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 25.4 хувь, цочмог амьсгуурстас 21.0 хувь, томуу, томуу төст өвчлөл 10.9 хувийг тус тус эзэлж байна<sup>63</sup>.

#### **Хүснэгт 3.6.3 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, хувиар**

/хот, хөдөө/, 2017 он

	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	37.3	66.7	42.8	66.6
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	10.3	10.1	12.0	13.7
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	12.5	4.1	6.9	2.2
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	2.0	0.7	8.3	1.8
Халдварт ба шимэгчит зарим өвчин	3.8	0.9	8.3	2.9
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	8.2	4.3	10.5	5.3

■ Тэргүүлэх шалтгаан  
 ■ Хоёрдугаар шалтгаан  
 ■ Гуравдугаар шалтгаан

Хатгалгаа өвчнөөр өвдсөн хүүхдийн тоо 2016 онд 10, 000 байсан бол 2018 онд 14,000 болж өссөн тухай Үндэсний статистикийн хороо мэдээлээд байна. 2018 онд амбулаториар үйлчлүүлсэн 0-5 насны хүүхдийн тоо гэхэд л өмнөх оноосоо 76.8% өссөн буюу 67,000-д хүрчихээд байна.

Түүнчлэн агаарын бохирдол хүүхдийн эхийн хэвлийд байх үед, төрсний дараах эхэн үед хүүхдийн тархины болон танин мэдэхүйн хөгжилд сөрөг нөлөөтэй болохыг сүүлийн үеийн судалгааны баримтууд харуулж байна. НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан “Агаарт буй аюул: бага насны хүүхдийн тархины хөгжилд агаарын бохирдол хэрхэн нөлөөлдөг вэ?” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлд агаарт буй нарийн ширхэгтэй хорт бодисууд нь хүүхдийн уураг тархины эд эсийг гэмтээж, танин мэдэхүйн хөгжилд сөргөөр нөлөөлж, улмаар хөгжлийн хоцрогдолд хүргэн, насан туршийн сөрөг үр дагавар дагуулдаг талаар нотолж байна. *Тархины хөгжлийн хамгийн чухал үе амьдралын эхний 1000 хоногт явагдаж, энэ үед мэдрэлийн систем төлөвшдөг.* Нярай болон бага насны хүүхдийн тархи нь төрөхөөс өмнө

<sup>61</sup> МУ-ын Нийгэм, эдийн засгийн байдал 2018, ҮСХ

<sup>62</sup> Аюулын харанга: Агаарын бохирдол ба хүүхдийн эрүүл мэнд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүүхдийн сан, 2018 оны 2 дугаар сар

<sup>63</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт 2017, Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ

бүрэлдсэн маш эмзэг мэдрэлийн холбоос, цогц харилцаа бүхий бүтэцтэй байдаг гэдгийг НҮБ-ийн Бага насны хүүхдийн хөгжил хариуцсан дарга Пиа Рэбэлло Брито хэлжээ. Тэрээр “Эдгээр мэдрэлийн холбоос нь хүүхдийн бодож сэтгэх, сурах, эрүүл мэнд, ой санамж, хэл шинжлэл, танин мэдэхүйн чадварыг бий болгодог. Сөрөг хүрээлэн буй орчин тэр дундаа хортой агаарын нөлөө нь хүүхдийг өсөлт хөгжлийн явцад илүү эмзэг болгож, тэдний тархийг бүрэн хөгжихөд саад болдог” гэсэн байна.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн илтгэлд дурдсанаар, агаарын бохирдлын бага насны хүүхдийн тархины хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хоол тэжээл, хайр халамжаар дутсан, эсвэл хүчирхийлэлд өртсөн хүүхдэд гарах сөрөг үр дагавартай адил байдаг гэжээ. Ялангуяа энэхүү аюул нь хүүхэд эхийн хэвлийд бүрэлдсэнээс хойш 24 сар хүртэлх 1000 өдрийн туршид хамгийн өндөр байдаг нь тогтоогдсон. Тухайлбал:

- Агаар бохирдуулагч бодисууд тун нарийн ширхэгтэй тул хүүхдийн цусанд шууд нэвтэрч, уураг тархинд хүрч, судас, тархины хоорондох шүүлтүүрийг даван мэдрэлийн эдийн үрэвсэл үүсгэдэг.
- Магнетит буюу монголоор соронзон хүдрийн төмөр зэрэг зарим хэт нарийн ширхэгтэй бохирдуулагч нь үнэрлэх эрхтэн, хоол боловсруулах замаар дамжин биед нэвтрэн орж соронзон чанараараа исэлдэх стресс үүсгэж, мэдрэлийн тогтолцооны нөхөн сэргэшгүй хүнд өвчлөлүүдийн үндэс болдог.
- Нүүрс, шатахуун, тос, хог, тамхи зэргийг шатаахад үүсдэг Полициклик ароматик гидрокарбон гэх мэт бохирдуулагчид нь хүүхдийн сурах, хөгжих суурь болсон тархины мэдрэлийн эсийн холбоосыг гэмтээдэг.
- Бага насны хүүхдийн тархи насанд хүрэгчдийнхээс бага хэмжээтэй тул илүү мэдрэг байдаг тул багахан хэмжээний хорт бодис ч хүүхдийн тархийг илүү хүчтэй хордуулдаг байна. Хүүхэд том хүнтэй харьцуулахад илүү хурдан амьсгалдаг, хүүхдийн бие махбодын өөрийгөө хамгаалах дархлааны чадвар сул байдаг тул агаарын бохирдолд томчуудаас илүү хорддог байна.

## АГААРЫН БОХИРДОЛТОЙ ХОЛБООТОЙ ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛД ЗАРЦУУЛЖ БУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДАЛ БОЛОН САНХҮҮЖИЛТ

### **Улаанбаатар хотын эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудад ирэх эдийн засгийн ачаалал**

Улаанбаатар хотын агаарын бохирдлоос үүдэлтэй өвчилсөн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зардал сүүлийн 5 жилд их хэмжээгээр нэмэгдэж, хүүхдүүдийн тухайд энэ үзүүлэлт бараг 2 дахин өссөн.

МУЗГ-аас агаарын бохирдлын асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхгүй бол 2025 он гэхэд 0-18 насны хүүхдүүдтэй холбоотой Улаанбаатар хотын эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудад ирэх эдийн засгийн ачаалал 24.8 тэрбум төгрөг (9.8 сая ам.доллар) болно. Энэ нь агаарын чанарын түвшин, хүн амзүй, эрүүл мэндийн үйлчилгээний бүтэц зэрэг нь хэвээр хадгалагдах нөхцөлд 2017-2025 оны хооронд агаарын бохирдолтой холбоотой хүүхдийн өвчлөлийг эмчлэхэд 24.8 тэрбум төгрөг (9.8 сая ам.доллар)-өөр илүү их хөрөнгө шаардагдана гэсэн үг. Энэ нь үр ашигтай арга хэмжээнүүдийг одоо авч хэрэгжүүлэх зардлаас давж байгаа юм<sup>64</sup>.

<sup>64</sup> Аюулын харанга: Агаарын бохирдол ба хүүхдийн эрүүл мэнд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ын Хүүхдийн сан, 2018 оны 2 дугаар сар

2025 он гэхэд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах талаар арга хэмжээ авахгүй байх зардлын гуравны хоёр нь хүүхэдтэй холбоотой гарах болно. 0-18 насны хүүхдүүдэд зарцуулагдах эс үйлдлийн зардлын хамгийн их хувийг дүүргийн эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэх тасгууд үүрэх болно. Энэ нь томуу, томуу төст өвчин ихсэж байгаатай холбоотойгоор эмнэлгүүдийн ачаалал нэмэгдэж, Эрүүл мэндийн яамнаас насанд хүрэгчдийн хэвтэж эмчлүүлдэг бүх тасгаа хүүхдийн ор болгон, орны тоогоо 700-гаар нь нэмээд ч ачаалал буурахгүй байгаагаас харагдаж байна.

### **Гэр бүлд учрах дарамт ба эцэг эх, асран хамгаалагчийн алдагдсан бүтээмж**

Агаарын бохирдолтой холбоотой эрсдэл болон өвчлөлийг даван туулахад зарцуулах шууд зардал гэр бүлд улам нэмэгдсээр байна. Үүнээс гадна өвдсөн хүүхдүүдээ асрахын тулд эцэг эх, асран хамгаалагчийн бүтээмж алдагдахтай холбоотой гарах зардал улам өсч байна.

Агаарын бохирдлын улмаас хүүхдүүд өвдөж, тэднийг асран харж буй ээжүүд ажил хийж чадахгүй байна. 2018 оны 3 улиралд 110,800 ээж нар хүүхдээ асарсан байна.

Жил ирэх тусам хүүхдээ хараад, эдийн засгийн идэвхгүй хүн амд тооцогдож байгаа эхчүүдийн тоо өсч байна. Улирлаар нь авч үзэхэд 2013 оны 4 улиралд энэ тоо 10.8% байсан бол 2018 оны 3 улиралд 13.3% болж өсчээ<sup>65</sup>.

Монгол улсын ядуурлын түвшин 29.6 хувьд хүрсэн, 3 сая хүнээс 907.5 мянган хүн нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа нөхцөлд<sup>66</sup> хүүхдийн өвчлөл нэмэгдэж байгаа нь гэр бүлийн төсөвт ачаалал нэмж, шаардлагатай эмчилгээг бүрэн хийлгэж чадахгүйд хүрч байна.

**Жишээ: Эмэгтэйчүүдийн нүдээр чуулганд тавигдсан “Гэр бүлд учрах дарамт ба алдагдсан боломж”<sup>67</sup> танилцуулгаас хэсэгчлэн авлаа.**

Утааны саруудад хүүхдийн өвдөх давтамж: **800 хүнээс авсан санал асуулгын дүн.** Таны хүүхэд утаатай саруудад хэдэн удаа амьсгалын замын халдварт өвчин тусч байна вэ? гэсэн асуултад хариулсан 768 хүний 62.9% 0-5 удаа, 30% нь 5-10 удаа гэж хариулсан байна.

**Цэвэр агаар ямар үнэтэй вэ?**

<sup>65</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 1212.mn, 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, шалтгаанаар, улирал, жилээр 2018

<sup>66</sup> Ядуурлын дүр төрх -2016 судалгаа, ҮСХ

<sup>67</sup> Эмэгтэйчүүдийн нүдээр чуулган: Гэр бүлд учрах дарамт ба алдагдсан боломж, Я.Мөнхчимэг, О.Гэрэлээ “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-ын гишүүд, 2019



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ,  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ЗАРЦУУЛЖ БУЙ  
ЗАРДАЛ**



*Залуу ээж: Хүүхдүүддээ утааны айдсыг мэдрүүлж өсгөхөөс айж, бронхит нь мянган сайн антибиотик хэрэглээд ч намдахгүй хөлснөөс нь хүртэл үнэртэх үед яах гэж энэ нялх амьтныг ингээн ингээн зовоох гэж төрүүлэв дээ гэж хүртэл харамсах шөнүүд цөөнгүй байна. Би 1-3 насны 2 хүүхэдтэй. Утааны улиралд буюу 11-5 сарын хооронд дор хаяж 5 удаа ханиад хүрч ганц шөнийн дотор бронхит, ларенгит, хатгаа болж эмнэлэгт хэвтнэ. Энэ тийм ч хүсээд байх хүүхэд нас биш. Би бага байхдаа хүчирхийлэл дарамтаас ангид байсан ч өнөөдрийнх шиг Утаанаас айх айдастай амьдралыг туулаагүйгээрээ азтай.*

**Агаарын бохирдлоос эцэг эх, асран хамгаалагчийн алдагдсан бүтээмж**

Хүн бүр, гэр бүл бүр үр хүүхдээ агаарын бохирдлоос хамгаалахын тулд өөр өөрийн онцлог, санхүүгийн боломж, бололцоондоо таарсан арга хэмжээ авч байна. Энэ ачаалал зөвхөн гэр бүлийн нуруун дээр байна. Гэр бүл төлөвлөлтөд утаа нөлөөлж эхэлсэн байна. Ээж, эмээ, эгч гээд ихэвчлэн эмэгтэйчүүд агаарын бохирдлоос болж өвдсөн хүүхдээ асрах ачааллыг үүрч байна. Нөгөө талд гэр бүлийн бусад гишүүдэд санхүүгийн давхар ачаалал ирж байна. Гэр бүлийн нөхцөл эмзэг байх тусмаа илүү хүнд тусч, өрх толгойлсон эцэг, эхэд давхар ачаалал ирж улам эмзэг болгож байна.

Агаарын бохирдол амьдралын чанарт нөлөөлж байна. Цэвэр агаараар амьсгалах нь “тансаг хэрэглээ” болж нийгэмд тэгш бус байдлыг гааруулж байна. Гэр хорооллынхныг агаарын бохирдлын гол буруутан гэх хандлага нь улам ихэсч улмаар ялгаварлан гадуурхалт бий болж байна. Агаарын бохирдол залуу, бага насны хүүхэдтэй гэр бүлүүдэд эдийн засгийн хувьд асар их дарамт учруулж байна.

Хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, хөгжих, баталгаатай орон байртай байх, хуримтлал үүсгэж болох, хамгаалагдах, эрүүл байх гэх мэт эрхүүдээ эдлэх боломж

алга. Бие болон сэтгэцийн эрүүл мэнд, цаг хугацаа, амрах боломж, хүлээгдсэн хүүхэд, амьгүй ураг, зулбалт түүнээс үүсэх сэтгэл зүйн эмгэг гээд маш олон хохиролтой тулгарч байна. Утаанаас гарч байгаа хохиролыг тооцоолох боломжгүй бөгөөд эргээд хэзээ ч нөхөгдөхгүй гарз хохиролууд бидэнд учирч байна.

“Утааны саруудад хүүхдийн өвдөх давтамж” асуулгад оролцогчид “Хүүхэд тань өвдөхөд эмчилгээ, үйлчилгээ авахдаа ЭМД-ын сангаас олгодог хөнгөлөлтөд хамрагдаж байсан уу?” гэсэн асуултад 774 хүн хариулснаас 74.7 нь ҮГҮЙ гэж хариулсан байна. Үүний шалтгаан нь Хөнгөлөлттэй эмийн жагсаалтанд тухайн эм байдаг эсэхийг мэддэггүй, мөн тухайн эм нь ордоггүй, явдал суудал ихтэй зэрэг шалтгааныг нэмж дурдсан.

Эмэгтэйчүүдийн нүдээр чуулганд тавигдсан илтгэлд<sup>68</sup> дурдсанаар, ЭМД-ын санд төвлөрч буй мөнгө бол ажил олгогч, даатгуулагч иргэдийн бүрдүүлсэн орлого бөгөөд юуны өмнө эмийн хөнгөлөлт, хүүхдийн эмчилгээг үнэ төлбөргүй болгоход зориулагдах ёстой гэж үзэж байгаагаа илэрхийлсэн болно.

Эмнэлгүүд MNS 4621-2008 түгээмэл үйлдлийн стандарт барьж өвчтөнүүдийг эмнэлэгт 5- 7 хоног л хэвтүүлэн эмчилдэг. Үүндээ өвчтөн, эмчлүүлэгчдийн тоо их байгаа, даатгалын сангаас санхүүжилт өгдөггүй гэдэг тайлбар хэлдэг. ЭМД-ын сангаас ахмад настан, иргэдэд хөнгөлөлттэй олгож байгаа эмийн 50% нь зайлшгүй шаардлагатай жороор олгох эм биш байдаг, олон улсад 1 төгрөгөөр зарагддаг эмийг эмийн комданиуд 10 төгрөгөөр худалдаад ЭМД-ын сангаас 3 төгрөгийг нь хөнгөлдөг.

Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нэрээр ЭМД-ын мөнгөөр рашаан сувилал, фитнес, спорт клубуудээр үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлнэ гэдэг нь ашгийн төлөө ААН-ийн санхүүжилтийг л дэмжсэн шийдвэр болсныг эргэж харах ёстой. Иргэд, олон нийтэд хүртээмжгүй арга хэмжээ юмаа.

Харин ахмад настаны эмийг үнэгүй болгох, хүүхдэд шаардлагатай эмнэлгийн бүх үйлчилгээг үнэгүй болгоход ЭМД-ын сангийн санхүүжилтийг зарцуулах хэрэгтэй. Эдгээр олон асуудлыг шийдвэрлэхийн тулд ЭМД-ын тухай хуулийг сайжруулж, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

### **Сургууль завсардах болон хувь хүний орлогыг бууруулах магадлал**

Агаарын бохирдол бронхит, гуурсан хоолойн багтраа өвчин зэрэг хүүхдэд хүндээр тусдаг өвчлөл үүсгэж, хүүхэд сургууль завсардах, сурах хөгжих бусад боломж хумигдахад хүргэдэг байна. Уушигны үйл ажиллагааны хүчин чадал, функц муудах, амьсгалын замын архаг өвчинтэй болох зэрэг байдлаар хүүхдийн өсөлт, хөгжилд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг аж. Мөн агаарын бохирдол нь айдас түгшүүртэй болох, сэтгэл гутралд орох, анхаарал сулрах зэргээр хүүхдийн сэтгэцэд нөлөөлдөг байна. Судлаачид сургууль завсардсанаас үүдэх шууд бус зардлыг тооцоолох оролдлого хийжээ. Сургуульд суралцахын эдийн засгийн өгөөжийг тооцсон олон тооны судалгааны ажлууд байдаг. Жишээлбэл, Монтенегро ба Патринос (2014) сургуулийн боловсролын эдийн засгийн өгөөжийн дүн шинжилгээг хийсэн. Монгол Улсын хувьд, сургуульд суралцсан нэг жил тутамд ирээдүйн орлого 9.1 хувиар нэмэгддэг гэж үзсэн. Анхан, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшсэний өгөөж тус тус

<sup>68</sup>Эмэгтэйчүүдийн нүдээр чуулган : Эрүүл мэндийн даатгалын зарчим, хүртээмж, ЭМДХ ТББ, 2019

13.4, 4.2 ба 10.1 хувь байсан нь Ази Номхон далайн бүс нутгийн үзүүлэлттэй ижил төстэй байгаа юм. Голчлон өндөр орлоготой орнуудаас хуримтлуулсан нотолгоог үзэхэд, сургалтын жилийн 10 хувийг тасалсан буюу хичээл таслалтын урхаг нь сургууль завсардах, цаашилбал хувь хүний орлогын хэмжээг бууруулах магадлалтай байдаг ажээ.

Хүүхдийн эрүүл мэнд, суралцах чадварт тэдний 2 дахь гэр болох сургуулийн хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийн үзүүлэх нөлөөлөл 20-70 хувь, тухайлбал сургуулийн дотоод орчны агаарын чанар, бичил цаг уур, цэвэрлэгээ зэрэг эрүүл ахуйн нөхцөлөөс гадна бусад олон хүчин зүйл сөргөөр нөлөөлдөг болохыг судлаачид тогтоосон байдаг. Prabjit Barn нарын судалгааны дүнгээс харахад HEPA шүүлтүүрийн үр ашиг 15-40 хувь байгааг судлан тогтоосон байна.

Хүүхдүүд өдрийн 8-10 цагийг өнгөрүүлдэг цэцэрлэгийн анги танхим дахь агаарын бохирдлын судалгааг 2017 оны хоёрдугаар сард “Улаанбаатар-Цэвэр Агаар” төсөл, АШУҮИС, Нийгмийн Эрүүл Мэндийн сургуультай хамтран СБД-ийн 150, 51, ЧД-ийн 43, 31-р цэцэрлэгт явуулжээ. **Судалгааны үр дүнд** агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийг цэцэрлэгийн анги танхимд суурилуулах нь дотоод орчны агаарын бохирдлыг 3.2 дахин бууруулж, улмаар хүүхдийн нойрсох хугацааг уртасгаж байгааг тогтоожээ.

Монгол Улсын Засгийн газраас боловсролын байгууллагуудыг HEPA шүүлтүүртэй агаар цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангахаар шийдвэрлэсний дагуу “Улаанбаатар-Цэвэр Агаар” төслөөс нийслэлийн төвлөрөл, агаарын бохирдол ихтэй гэр хороололд байрлах 50 цэцэрлэгийг сонгож, 200 агаар цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулж байна. Дараагийн шатанд гэр хороололд байрлаж байгаа нийт 83 цэцэрлэгт бүгдэд нь агаар цэвэршүүлэгч өгөх, нэг цэцэрлэгт ногдох тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийг дагалдуулан агаарын бохирдлыг хэмждэг лазер төхөөрөмж цэцэрлэг тус бүрт нэгийг хүлээлгэн өгөх бөгөөд энэхүү хэмжүүрийн тусламжтайгаар агаар дахь бохирдлыг хэрхэн бууруулж байгааг харах боломжтой болно.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй хяналт шалгалтын хүрээнд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагад олгосон агаар цэвэршүүлэгчийн ашиглалтын талаар тандалт судалгаа хийжээ.

### **Сонгосон асуудалтай холбоотой дүгнэлт, зөвлөмж**

Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээнүүд нь дунд болон урт хугацаанд илүү төвлөрсөн, зөвхөн эрчим хүчний салбарт төвлөрсөн, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд голчлон анхаарчээ. Эдгээр нь агаарын бохирдлыг бууруулахад үүрэг гүйцэтгэх хэдий ч энэ хугацаанд олон мянган хүүхдүүд болон жирэмсэн эхчүүд өндөр эрсдэл дунд амьдарч байгааг тооцоолж, эрсдлээс хамгаалах арга хэмжээнүүдийг нэн яаралтай авах стратеги барих шаардлагатай байна. Хот суурин газарт амьсгалын замын өвчин ихсэж байгаа нь хүйтний улиралд агаарын бохирдол үлэмж хэмжээгээр нэмэгддэгтэй холбоотой юм. Ялангуяа хүүхэд, жирэмсэн эхчүүд, амьсгалын замын өвчин тусах, энэ нь ургийн хэвийн өсөлт бойжилтод сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байна гэж ТХЗ-н хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар

бодлогын зөвлөгөө өгөх НҮБ, АХБ-ны хамтарсан ажлын хэсгийн 2018 оны тайланд дурдсаныг анхааралдаа авах хэрэгтэй байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад олон төсөл хэрэгжсэнээс, 2008-2016 онд Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулахад 147 тэрбум төгрөг (60 орчим сая доллар), нэмэлт 60 сая ам долларыг хандивлагчдын санхүүжилтээр тус тус зарцуулсан байна. Мөн 175 мянган сайжруулсан зуух тараахад нийслэлийн гэр хорооллын нийт өрхийн 97.6% хамрагдаж, нийт 68 тэрбум төгрөг зарцуулсныг дээрх тайланд дурдсан байна. Гэвч агаарын бохирдол буурахгүй бүр ихсэж, гамшгийн байдалд хүрээд байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Агаарын бохирдлыг бууруулах дунд болон урт хугацааны зорилгын зэрэгцээ учирч буй сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн хамгаалалтын арга хэмжээг яаралтай авах;
- Үүссэн нөхцөл байдлыг онцгой байдал гэж авч үзэх, агаарын бохирдолд хамгийн их өртөж байгаа жирэмсэн эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг эрэмбийн хувьд тэргүүн ээлжинд авч үзэх;
- Агаарын бохирдлын үр дагавар болон шийдлийг бүхэлд нь харж, өртөж байгаа хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, ялгаатай хүчин зүйлийг тооцон, цогц дэмжлэг үзүүлэх стратеги барих;
- Бага насны хүүхдийг өвдсөн тохиолдолд эдийн засгийн боломжоос үл хамааран анхан шатны эмчилгээг шуурхай авах боломжийг бүрдүүлэх ;
- Эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүд дунд амьсгалын замын цочмог үрэвсэл, уушгины архаг өвчлөлийг эмчлэх сайн чанартай эмийг эрүүл мэндийн даатгалаас үнэ төлбөргүй эсвэл хөнгөлөлттэй олгох;
- Магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн жирэмсний хяналтын оношлогоо, шинжилгээг эрүүл мэндийн даатгалаас нөхөн төлдөг болгох;
- Эрүүл мэндийн даатгалаараа фитнессээр үйлчлүүлэх боломж олгосон хуулийн зохицуулалтыг эргэн харах;
- Гэр хороололд оршин суудаг жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхдийг агаарын бохирдолд өртөх байдлыг бууруулах багц арга хэмжээг тодорхойлох, зардлын тооцооллыг хийх.

## VI. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

- Тогтвортой хөгжлийн зорилгын бичиг баримтын **албан ёсны** орчуулгатай болж, бүх нийтээр баримтлах,
- ТХЗ-ыг орон нутгийн иргэдэд мэдээлэх, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгах, хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах, тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд иргэдийн сайн дурын үйл ажиллагааг дайчилдаг болох,
- **Мэдээлэл шинээр бий болгох, нэмэгдүүлэх чиглэлээр:**
- ✓ Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн ялгаатай бүлгүүдийн хэрэгцээг судлан бодлого, төлөвлөлтөд тусгах, төсөв хөрөнгө хуваарилах замаар тэдэнд хөгжлийн үйл явцад тэгш оролцох, үр ашгийг тэгш хүртэх боломж олгохын тулд МУТХҮБ-2030-д жендэрийн тэгш байдлыг хангах зорилгыг ДТХЗ-ийн хөтөлбөрийн агуулгаар нь бие даасан зорилт болгон тусган өөрчлөх,

- ✓ Бэлгийн болон нөхөн үржихүйн зорилт, шалгуур үзүүлэлтийг ТХҮБ-2030-д тусгайлан боловсруулж оруулах;
- ✓ Ойлголт тодорхойлолт, аргачлалыг өөрийн болгох, жишээ нь “ядуусын хороолол”, “тэнэмэл хүмүүс” г.м томъёоллыг өөрчлөн нэгдмэл байр суурьтай байх,
- ✓ Гачигдал, хомсдолыг яаж хэмжих вэ? Монголчууд хэнийг ядуу гэж ойлгож байна вэ гэдэг өөрийн онцлог бүхий тодорхойлолттой болох,
- ✓ Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодисын хэрэглээ, эрсдэлт зан үйлийг тодорхойлох үндэсний хэмжээний тандалт судалгаа хийх,
- ✓ Хэнийг ч орхигдуулахгүй зарчмыг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон бусад зорилтот бүлгийн мэдээллийг гаргах боломжийг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны асуулгад нэмж оруулах,
- ✓ Эрүүл мэндийн хичээл заахаар тусгайлан бэлтгэгдсэн багш нарын тоог ТХЗ 3.7-ийн шалгуур үзүүлэлт болгох,
- ✓ Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг үнэ төлбөргүй авсан зорилтот бүлгийн тоог ТХЗ 3.8-ийн шалгуур үзүүлэлт болгох,
- ✓ ТХЗ-8: ажил, мэргэжлийн ангиллаар задалсан мэдээлэл бий болгох,
- ✓ Уул уурхайн төслийн нөлөөлөлд өртсөн хүн, мал, хадлан, өвөлжөө хаваржаа, отор хадлангийн нутаг, рашаан ус зэрэг үзүүлэлтийг шинээр гаргах,
- ✓ Бэлгийн болон нөхөн үржихүйн зорилт, шалгуур үзүүлэлтийг ТХҮБ-2030-д тусгайлан боловсруулж оруулах;
- ✓ Эрүүл мэндийн хичээл заахаар тусгайлан бэлтгэгдсэн багшийн тоог ТХЗ 3.7-ийн (бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилтийг харуулах) шалгуур үзүүлэлтийн нэг болгож тусгах;
- ✓ Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг үнэ төлбөргүй авсан зорилтот бүлгийн тоог ТХЗ 3.8-ийн (санхүүгийн эрсдлийн хамгаалалт, нэн шаардлагатай чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэх) шалгуур үзүүлэлтийн нэг болгож тусгах;
- ✓ Шалгуур үзүүлэлтийн орчуулгатай холбоотой зарим санал:

ДТХЗ-н эх хувилбар	Одоо ашиглаж байгаа хувилбаруудад	ИНБ-н санал болгож байгаа нэмэлт өөрчлөлт
16.2 End abuse, exploitation, trafficking and all forms of violence against and torture of children	16.2 Хүүхэдтэй зэрлэгээр харьцах, тэднийг мөлжих, наймаалах, тамлан зовоох, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсоох устгах (1212.mn)  16.2.Доромжлол, мөлжлөг, хүн худалдаалах, хүүхдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг таслан зогсоох (UNDP)	<b>16.2:</b> Хүүхдийн эсрэг дарангуйлал, хүүхдийн мөлжлөг, хууль бус наймаа, хүчирхийллийн бүх хэлбэр, хүүхдийг тарчлан зовоох явдлыг зогсоох(тайлан бичсэн бүлэг)
16.2.2 Number of victims of human trafficking per 100,000 population, by sex, age and form of exploitation	<b>16.2.2</b> 100,000 хүнд ногдох хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын тоо	<b>16.2.2</b> 100,000 хүнд ногдох хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын тоо, <b>хүйс, насны бүлэг, мөлжлөгийн хэлбэрээр</b>
10.1 By 2030, progressively achieve and sustain income growth of the bottom 40 per cent of the population at a rate	<b>10.1</b> 2030 он гэхэд <b>бага орлоготой</b> хүн амын 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр түвшинд аажмаар хүргэж, хадгалах	... <b>хамгийн</b> бага орлоготой...  Хэрэгжилтийн үр дүнг бууруулах тул “Хамгийн” гэсэн үгийг орхиж болохгүй.

higher than the national average		
----------------------------------	--	--